# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

2018 он 03
сарын 30 өдөр

Дугаар 3Г-1/68

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Үндсэн чиглэлийн биелэлтийг
өргөн мэдүүлэх тухай

"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн биелэлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд У.ХҮРЭЛСҮХ

001192

МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 03 дугаар
сарын 29-ны өдөр

Дугаар ХЭГ/618

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ЦОЛМОН ТАНАА

Тов тогтоолгох тухай

"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн биелэлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга Г.ЗАНДАНШАТАР

001986

# МОНГОЛ УЛСЫН
# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
# ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлд:

“XXIX.2.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг боловсруулсан.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх, эдийн засгийн хүндрэлийг даван туулах, үйлдвэрлэл, дэд бүтцийн томоохон төслүүдийг эрчимжүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх; инфляцийг зорилтот түвшинд байлгах; ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах; нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг өмнөх оны түвшнээс бууруулах замаар дунд хугацаанд төсвийн үндсэн тэнцлийг эерэг болгох нөхцөлийг бүрдүүлэх; Засгийн газар, Хөгжлийн банкны гадаад бондыг эргүүлэн төлөх эх үүсвэрийг шийдвэрлэж, дунд хугацаанд өрийн дарамтыг бууруулах бодлого хэрэгжүүлэх; валютын орох урсгал түр зуур нэмэгдэх үед төгрөгийн нийлүүлэлтийг огцом нэмэгдүүлэхгүй, валютын нөөцийг хамгаалах зарчим баримтлах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд

1. Макро эдийн засгийн бодлого
2. Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого
3. Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого
4. Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого
5. Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого

гэсэн нийт 5 бүлэг, 17 зорилтын 104 бодлогын арга хэмжээг тусган, боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлсэн. Улмаар Байнгын хорооны хуралдаан болон УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар гишүүдийн гаргасан саналаар 14 арга хэмжээ шинээр нэмэгдэж 118 бодлогын арга хэмжээтэйгээр УИХ-ын 2016 оны 70 дугаар тогтоолоор "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл" батлуулав.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгасан 5 бүлэг, 17 зорилтын 118 бодлогын арга хэмжээг нийтдээ 5.4 их наяд тэрбум төгрөгийн санхүүжилтээр, үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 353.9 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 825.2 тэрбум төгрөг, төр хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хөрөнгө оруулалтаар 4.1 их наяд, бусад эх үүсвэрээс 104.0 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөн боловсруулсан.

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАЙЛАН

(2017 оны жилийн эцсийн байдлаар)

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг төслийг боловсруулахад ашиглахад оршино.

## ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ыг баримтлав.

## ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Үндсэн чиглэлд туссан зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх болон биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах үүрэг бүхий 13 яам, 5 агентлаг, Монголбанк, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, зэрэг 20 төсвийн Ерөнхийлөн Захирагчийн хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний биелэлтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

## ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 118 арга хэмжээнд давхардсан тоогоор Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримталаас 80.5 хувь буюу 95 арга хэмжээ, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс 95.7 хувь буюу 113 арга хэмжээ, бусад бодлогын баримт бичгээс 8.5 хувь буюу 10 арга хэмжээ тусгагдсан бөгөөд нийт 5 бодлого, 17 зорилт, 118 арга хэмжээний биелэлтийг 2017 оны жилийн эцсийн байдлаар үнэлэхэд биелэлт **79.3 хувьтай** гарлаа. Энэ нь 2017 оны эхний хагас жилийн хэрэгжилттэй харьцуулахад **25.5 хувиар** өссөн байна.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ БОДЛОГЫН ТӨРЛӨӨР, БИЕЛЭЛТИЙН ХУВЬ

*Хүснэгт.1*

| № | Бодлого | Арга хэмжээний тоо | 100 | 70 | 40 | 0 | Үнэлэх боломжгүй арга хэмжээ | Нийт хэрэгжилтийн хувь хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Бүгд** | **118** | **53** | **50** | **14** | **1** | **-** | **79.3** |
| **1** | Макро эдийн засгийн бодлого | 12 | 9 | 2 | 1 | - | - | 90 |
| **2** | Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого | 31 | 8 | 13 | 9 | 1 | - | 66.8 |
| **3** | Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого | 17 | 6 | 9 | 2 | - | - | 77.0 |
| **4** | Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого | 38 | 19 | 17 | 2 | - | - | 83.4 |
| **5** | Засаглал, эрхзүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого | 20 | 11 | 9 | - | - | - | 86.5 |

*Хүснэгт.2*




*Хүснэгт.3*



## ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭНҮҮД :

Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувиар үнэлэгдсэн дараах 14, үр дүнгүй буюу 0 хувиар үнэлэгдсэн 1 арга хэмжээ байна. Үүнд:

- **2.3** Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах хууль, эрх зүйн орчныг сайжруулж, урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; **/2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар 100; **ҮХГ/**

  **Биелэлт:** Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах хууль, эрх зүйн орчныг сайжруулах, урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэхээр холбогдох төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран судалгааны ажлыг эхлүүлсэн.

- **3.1** Малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор малын удмын санг хамгаалж, үржил селекцийн аргаар шинэ үүлдэр, омгийг бий болгох; **/2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Импортоор авах болон дотоодод үйлдвэрлэх үхрийн гүн хөлдөөсөн үр, 100 мянган тун; **ХХААХҮЯ/**

  **Биелэлт:** Малын удмын сангийн үндэсний төвийн үндсэн үйл ажиллагаа болох шилмэл хээлтүүлэгч малаас үр үйлдвэрлэх ажлыг явуулын лабораторийн нөхцөлд гүйцэтгэн "Газар-Агро" ХХК-ийн ОХУ-аас импортлон цэврээр үржүүлж байгаа махны чиглэлийн Герефорд үүлдрийн 10 бухнаас 14.0 мянга, Дорнод аймгийн салбар нэгжид үржүүлж буй Барга үүлдрийн хуцнаас 4.0 мянган тун үрийг тус тус үйлдвэрлэн хөлдөөсөн.

- **3.6** Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, хот суурин газрын хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах; **/2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Шинээр нэмэгдэх хүлэмжийн талбайн хэмжээ, 100 мян.м2, Хүлэмжийн ургацын нэмэгдэх хэмжээ, 4 мян.тонн; **ХХААХҮЯ/**

  **Биелэлт:** Төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 20.0 мянган м2 өвлийн хүлэмж, 68.8 мянган м2 нийлэн хальсан хүлэмжийг байгуулсны үр дүнд орон нутагт хүнсний ногооны таримлын нэр төрөл нэмэгдэн, үйлдвэрлэл 2 мян тн-оор нэмэгдэхээр байна.

- **3.7** Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн менежментийг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх; **/2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Үйл ажиллагааны хэрэгжилт 100 хувь; **ХХААХҮЯ/**

  **Биелэлт:** Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн менежментийг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор "Бэлчээр хамгаалах тухай" хуулийн төслийг боловсруулж байна. Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоотой хамтран "Монгол орны бэлчээрийн үндэсний форум"-ыг зохион байгуулж, бэлчээрийн доройтлыг хязгаарлах, зүй зохистой ашиглалтыг нэвтрүүлэх, зохицуулалт, хариуцлагыг өндөржүүлэх бодлогын шинэчлэлийн чиглэлээр томоохон хэлэлцүүлэг хийж саналыг тусган ажиллаж байна.

- **5.2** Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, Тавантолгойн орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцлийг байгуулж, төслийн үйл ажиллагааг эхлүүлэх; **/2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын явц, 20 хувь; Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцлийг байгуулах ажлын явц, 100 хувь; **УУХҮЯ/**

**Биелэлт:** Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 155 дугаар Захирамжаар "Уул уурхайн Бодлогын зөвлөл"-ийг байгуулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 256 дугаар тушаалаар Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн төлөвлөгөөнд санал дүгнэлт өгөх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд санал, дүгнэлтээ танилцуулсан.
Мөн Таван толгойн ордыг иж бүрнээр ашиглах тухай (төмөр зам, авто зам, баяжуулах үйлдвэр, усан хангамж, ордыг түшиглэсэн аж үйлдвэрийн цогцолбор) төлөвлөгөө боловсруулан Монгол Улсын Ерөнхий сайдад 2018 оны 1 дүгээр сарын 8-ний өдөр, Засгийн газрын хуралдаанд 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр тус тус танилцуулсан.

- **6.1** Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх; **/2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Дарханы ДЦС-ын барилгын ажлын явц, 100 хувь, Эрдэнэтийн ДЦС-ын барилгын ажлын явц 10 хувь; **ЭХЯ/**

**Биелэлт:** Дарханы ДЦС-ыг өргөтгөх төслийн хүрээнд 1. 40000Квт трансформатор угсарч суурилуулсан 2. Өргөтгөлийн барилгын түр ханын суурийг хийсэн. 3. Ажилчдын түр амьдрах байрыг барьсан. Одоогийн байдлаар төслийн талбайд өргөтгөлийн барилгын төмөр хийцийн угсралт, эргэлтийн усны насос станцын шугамын тулгууруудын ажил, 6кв-ын хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил, хөргөгч цамхагын авлагын ажлууд тус тус хийгдэж байна.
Эрдэнэтийн ДЦС-ийг өргөтгөх төслийн гүйцэтгэгчээр БНХАУ-ын Hunan Industrial Equipment Installation компани шалгаруулж 2017 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр гэрээг байгуулсан. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Экспорт Импортын банкны хооронд байгуулсан зээлийн ерөнхий гэрээний дагуу төсөл болон төслийн гүйцэтгэгчээр шалгарсан компанид аудит хийх ажил явагдаж байна.

- **6.2** Өмнөд говийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах хүрээнд Тавантолгойн цахилгаан станцыг байгуулах бэлтгэл ажлыг хангах; **/2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Бэлтгэл ажлыг хангах ажлын явц, 100 хувь; **ЭХЯ/**

**Биелэлт:** Төслийн хөрөнгө оруулагч Маребуни, Эм Си Эс компанийн түншлэл "450 МВт-ын ДЦС барих" төслийн "Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ"-ний хэлэлцээрийг Оюу толгой компанитай хийж байна. Хэлэлцээр амжилттай болж Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулагдсаны дараа санхүүгийн хаалтын гэрээний хэлцэлд орно. 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Маребуни, Эм Си Эс компанийн түншлэл, Рио тинто компанитай уулзахаар төлөвлөж байсан хэдий ч уулзалт тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.

- **6.5** Аймгийн төвүүдэд байгаль орчинд ээлтэй дулааны станц, шугам сүлжээ барих ажлыг үргэлжлүүлэх; **/2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Барилгын ажлын явц 10 хувь; **ЭХЯ/**

  **Биелэлт:** 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ барих төслийн өмнөх хэлэлцээрүүдийг 2017 онд үргэлжлүүлж үр дүнд хүргэх, БНСУ-ын талаас хөнгөлөлттэй зээл олгох асуудлыг түргэвчлүүлэх арга хэмжээг авч байна. Дээрх төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлүүдийг орчуулан, холбогдох материалын хамт БНСУ-ын талд хүргүүлсэн. 2017 оны 7 дугаар сард БНСУ-ын "ЭКСИМ" банкны төлөөлөгчид манай улсад ажиллаж, 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ барих төслийн ТЭЗҮ-ийг "ЭКСИМ" банкны хөрөнгөөр 2018 оны 6 дугаар сард багтааж шинэчлэн боловсруулах санамж бичигт МУ-ын Сангийн яам, Эрчим хүчний яам, БНСУ-ын "ЭКСИМ" банкны төлөөлөгчид гарын үсэг зурсан.

- **7.4** Гадаад, дотоод худалдааг хөнгөвчлөх тээвэр, логистикийн төвийн үйлчилгээг бий болгох ажлыг үргэлжлүүлэх; **/2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Замын-Үүд сумын холимог тээврийн терминал, логистикийн төв байгуулах ажлын явц, 80 хувь; Хөшигийн хөндийд холимог тээврийн логистикийн төв байгуулах бэлтгэл ажлын явц, 100 хувь; **ЗТХЯ/**

  **Биелэлт:** 2017 онд улсын төсвийн санхүүжилтээр 4.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий логистикийн төвийн 50 тн-ийн даацтай вандан кран нийлүүлэх ажил хийгдэхээр тендер зарлагдан Хятад улсын "Хэнань Дафан Хүнд Машин механизм" компани шалгаран гэрээ байгуулсан ба гэрээний гүйцэтгэл 40 хувьтай байна. Нийт төлөгдөх ёстой санхүүжилтийн 71 хувь хийгдлээ. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэх Логистикийн төвийн барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгчээр "Хятадын төмөр замын 21 дүгээр товчоо" компани, хяналтын зөвлөхөөр БНСУ-ын "Сүсонг инженеринг компани", Монгол Улсын "Геозураглал", "NBCC" ХХК-иудын түншлэл ажиллаж байгаа бөгөөд 32.4 сая ам.долларын санхүүжилт хийгдэв. **Нийт барилгын ажлын гүйцэтгэл 81 хувьтай байна.**

  Хөшигийн хөндийд тээвэр логистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулах хөрөнгийн асуудал шийдвэрлэх ажлын хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтад танилцуулга хүргүүлэв. Азийн хөгжлийн банкнаас 2017 оны санхүүжүүлэх төслийн жагсаалтад Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулах асуудал тусгагдаагүй.

- **7.6** Дотоодын усан замын тээврийг хөгжүүлж, аюулгүй байдлыг хангасан нэгдсэн зогсоол, төв буудал барих бэлтгэл ажлыг хангах; **2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Төв буудал барих бэлтгэл ажлын явц, 100 хувь; **ЗТХЯ/**

  **Биелэлт:** Усан замын төв буудал барих газрыг Хөвсгөл аймгийн Засаг даргын 2017 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 1/542 тоот, Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2017 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн А/16 тоот захирамж, Хатгал тосгоны захирагчийн 2017 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 1/71 тоот захирамжаар тус тус шийдвэрлүүлж, газар зүйн солбицол, координатыг тогтоолгоод байна. Усан замын төв буудал барих ТЭЗҮ, зураг төслийн санхүүжилтийг гадаад эх үүсвэрээс шийдвэрлүүлэх зорилгоор АХБ, Дэлхийн банк, Жайка зэрэг 11 байгууллагад хандсан хүсэлтийг 03/2678

тоот албан бичгээр хүргүүлсэн. Үндэсний хөгжлийн газраас концессын сонгон шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна.

- **8.5** Улаанбаатар хот болон аймгуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэх; **/2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Шинээр барих цэвэрлэх байгууламжийн тоо-6; **БХБЯ/**

**Биелэлт: Өвөрхангай** аймгийн төвийн цэвэрлэх байгууламж, бусад туслах үйлчилгээний А1.4 дугаартай ажлын тендерийн үнэлгээг дуусгаж, үнэлгээний тайланг АХБ-нд зөвшөөрөл авахаар хүргүүлсэн. "**Өмнөговь** аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ" А1.3 багцын сонгон шалгаруулалтаар АХБ-аас ирүүлсэн зөвшөөрөлд үндэслэн "НАБ" ХХК-ийн түншлэл гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулав. **Дорноговь** аймгийн төв Сайншандад баригдах бохир ус цэвэрлэх байгууламжийн өөрчлөлтийн ажлын зураг, Ар, өвөр шандыг холбох ариутгах татуургын шугамын ажлын зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчээр зураг төслийн "Хайдро Дизайн" ХХК шалгарч, гэрээ байгуулан ажлаа гүйцэтгэж байна. **Архангай** аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламж, бусад туслах үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн Үнэлгээний хороо байгуулсан.

- **9.9** Байгаль хамгаалах, байгалийн нөөц баялгийг арвижуулах, нөхөн сэргээх ажилд иргэд, олон нийтийн оролцоо, үйл ажиллагааг дэмжиж ажиллах **/2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Шинээр бий болох ажлын байрны тоо-200; **БОАЖЯ/**

**Биелэлт:** Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Ойн тогтвортой менежмент хэрэгжүүлж нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих нь" төслийн хүрээнд Сэлэнгэ сумын Түнхэл сумын 7 нөхөрлөлийг чадавхижуулж, шинээр **80 гаруй** ажлын байрыг бий болгон ажиллаж байна.

- **12.4** Монгол контентыг хөгжүүлж, интернетийн дотоод урсгалын хэмжээг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд экспортлох боломжтой программ хангамж, техник хангамжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх; **/2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Интернетийн дотоод урсгалын нэмэгдэх хэмжээ 20 хувь; **ХХМТГ/**

**Биелэлт:** Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/30 дугаар тушаалаар "Тоон контентийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Уг ажлын хэсгээс суурь судалгаа, орчны шинжилгээг хийж, хөтөлбөрийн төслийг боловсруулан 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдөр даргын зөвлөлийн хуралд танилцуулж, өгсөн чиглэлийн дагуу хөтөлбөрийн төслийн агуулгыг сайжруулж байна.

- **14.5** Бичил аж ахуйн нэгж, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг зээлийн бодлогоор дэмжих; / **2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Шинээр боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо-2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авах бичил аж ахуйн нэгж, иргэдийн тоо-6000, Шинээр бий болох ажлын байрны тоо-10000; **ХНХЯ/**

**Биелэлт:** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагааг 2017 онд Төрийн банк, Капитал банк, Голомт банк

хариуцан гүйцэтгэж 1915 зээлдэгчид 9.8 тэрбум төгрөгийн жижиг зээлийг олгосноор 6163 ажлын байр шинээр бий болсон байна.

- **7.3** Бодит салбарын өсөлтийг дэмжих төмөр замын төслүүдийг хэрэгжүүлэх; / **2017 оны хүрэх түвшин, үр дүн:** Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, 60 хувь, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц 10 хувь, Шивээхүрэн-Сэхэ чиглэлийн боомтын төмөр замын барилгын ажлын явц 100 хувь, Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц 20 хувь, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилтийн явц 10 хувь, Богдхан төмөр замын төслийн хэрэгжилтийн явц 10 хувь; **ЗТХЯ/**

**Биелэлт:** Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг БНХАУ-аас Монгол Улсад хөнгөлөлттэй зээлээр олгох 1 тэрбум ам.доллараас 400 сая ам.доллар олгохоор Засгийн газрын 2017 оны 222 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Засгийн газрын 2017 оны 312 дугаар тогтоолоор дээрх 400 сая ам.доллар олгох тогтоолыг хүчингүй болгосон. Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын техникийн зураг төслийг боловсруулах ажлын хүрээнд БНХАУ-ын “Башинь төмөр зам” компанийн захиалгаар БНХАУ-ын Зураг төслийг 3 дугаар хүрээлэн ТЭЗҮ-ийг боловсруулсан. Тус хүрээлэнгээс хураангуй ТЭЗҮ-ийг ирүүлсэн бөгөөд ТЭЗҮ-ийн эх хувийг хүлээж авахаар ажиллаж байна. Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын шугамын чигийг тогтоох Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж 2017 оны 126 дугаар тогтоолоор батлуулсан. “Мөнгөн зөрлөг” ХХК-тай 2017 оны 05 дугаар сард гэрээ байгуулан ТЭЗҮ, зураг төслийг шинэчилүүлсэн. Тус чиглэлийн царигийн өргөний хэмжээг тогтоох тухай УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлал, холбогдох бусад материалыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 35 дугаар тэмдэглэлээр УИХ-д өргөн барихаар тогтсон. Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын чигийг Засгийн газрын 2017 оны 10 дугаар тогтоолоор батлуулсан. 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Эрдэнэт хотод төмөр замын барилгын ажлын нээлтийг хийж шав тавих ёслолыг хийсэн. Олон улсын банк санхүүгийн байгууллагын шаардлага хангасан ТЭЗҮ-ийг 2018 оны эхний улиралд багтаан боловсруулж дуусган төмөр замын барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг БНХАУ-ын "Си Ар И Си" компани өөрийн хөрөнгөөр боловсруулж, “Монголын төмөр зам” ТӨХК-д хүлээлгэн өгөхөөр харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. “Си Ар И Си” компани нь ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан бөгөөд Монгол хэл рүү орчуулах ажил хийгдэж байна. УИХ-аар тус чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээ тогтоолгохоор ажиллаж байна. “Богдхан” төмөр замын чигийн 5 хувилбарыг 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, улмаар 5 дахь чигийн хувилбарыг дэмжиж, координат болон солбицлыг Засгийн газрын хуралдаанаар батлуулахаар шийдвэрлэсэн. Зөвлөх компани чигийн судалгааны эцсийн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүлээлгэж өгсөн. Тус төмөр замын чигийг Засгийн газрын хуралдаанаар батлуулж, ТЭЗҮ, зураг төслийг боловсруулахаар ажиллаж байна.

**ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ :**

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлтийг яамд, холбогдох агентлагуудаас ирүүлсэн материалд үндэслэн гаргахад дараах зүйлүүд дээр анхаарч ажиллах талаар Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгох саналтай байна. Үүнд:

- Үндсэн чиглэлийн биелэлтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан хугацаанд бүрэн ирүүлэх;
- Үндсэн чиглэлийн биелэлтийг зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлэх;
- Тухайн арга хэмжээг хамтран хэрэгжүүлж байгаа салбарын яамд болон агентлагуудын хоорондын ажлын уялдааг сайжруулах;
- Зорилт, арга хэмжээний биелэлтэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхой тусгах;
- Яам, агентлагын хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтнуудын чадавхийг сайжруулах зэрэг болно.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ :**

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн эхний хагас жилийн хэрэгжилтийг холбогдох яамд, агентлагуудаас ирүүлсэн материалд үндэслэн гаргахад дараах зүйлүүд дээр анхаарч ажиллах талаар Засгийн газрын гишүүдэд үүрэг болгох саналтай байна. Үүнд:

- Үндсэн чиглэлийн биелэлтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хугацаанд бүрэн гүйцэд ирүүлдэг байх;
- Үндсэн чиглэлийн биелэлтийг тайлагнахдаа зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан тайлагнах;
- Тухайн арга хэмжээг хамтран хэрэгжүүлж байгаа салбарын яамд болон агентлагуудын хоорондын ажлын уялдааг сайжруулах;
- Зорилт, арга хэмжээний биелэлтийн зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхой тусгах;
- Яамд, байгууллагуудын хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтнуудын чадавхийг сайжруулах зэрэг болно.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

| Д/д | Дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг | Зорилт, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин, үр дүн | Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр | Хүрсэн түвшин, хэрэгжит | Хэрэжил тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **Зорилт 1. Макро эдийн засгийг богино хугацаанд тогтворжуулах бодлого хэрэгжүүлнэ** | | | | | | | |
| 1.1 | МУТХҮБ-ын 2.1 дэх хэсэг, ЗГҮАХ-ийн 1.1 дэх заалт | Уул уурхай, дэд бүтцийн томоохон төслүүдийг эрчимжүүлж, эдийн засгийн өсөлтийг хангах | Дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид “ДНБ” гэх/-ий бодит өсөлт, хувиар | 3.0 | - | Үндэсний статистикийн хорооноос зарласан ДНБ-ий урьдчилсан гүйцэтгэлээр **Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт 2017 онд 5.1 хувьд хүрч, зорилтод түвшин хангагдлаа.** Эдийн засгийн өсөлтөд боловсруулах аж үйлдвэр 22.8 хувиар, хөдөө аж ахуй 2.3 хувиар, үйлчилгээний салбар 8.5 хувиар өссөн нь голлон нөлөөллөө. Хөрөнгө оруулалтын хэмжээ 2017 онд бодит дүнгээрээ 32 хувиар өссөн. Энэ нь Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажилтай холбоотой. Түүнчлэн, Өмнөд говийн эрчим хүчний хангамжийн сайжруулах хүрээнд Оюутолгой-Цагаансуваргын 220 кВ-ын 2 хэлхээт 159.5 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ажлыг дуусгаж, Чойрын дэд станцын өргөтгөлийн барилга угсралтын ажил 60 хувьтай байна. Эрдэс бүтээгдэхүүнийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажлын хүрээнд “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК нь евро стандартад нийцсэн, жилд 20 мянган тонн ган бөмбөлөг үйлдвэрлэх хүчин чадалтай, давтах аргын технологитой үйлдвэрийг ашиглалтад оруулллаа. | 100 |
| 1.2 | МУТХҮБ-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.3.6 дахь дэд заалт | Ажлын байрыг нэмэгдүүлэх зарчим баримталж, ажилгүйдлийн түвшинг | Ажилгүйдлийн түвшин, хувиар | 9.0-өөс ихгүй | 46.7 ХЭДС | 2017 онд “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бууруулах | | | | иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр", "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр"-үүдийг батлан хэрэгжүүлж 51319 иргэнийг хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 46.7 тэрбум төгрөгийг зарцуулснаар 9385 байнгын ажлын байр, 16328 түр ажлын байр шинээр бий болж ажилгүйдлийн түвшин **2017 оны 4 дүгээр улирлын байдлаар 7.3 хувьд хүрэв.**<br>Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгад төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлэх үйлчилгээ, арга хэмжээний төрөл, хэлбэрийг олон улсын чиг хандлага, өөрийн орны онцлогт нийцүүлэн "халамжаас хөдөлмөр эрхлэлт рүү" зарчмын хүрээнд нарийвчлан тогтоож, зохион байгуулалтын тогтвортой, хүртээмжтэй байдлыг бий болгох зүйл, заалтыг тусгасан. Түүнчлэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг нэмэлт эх үүсвэрээс бүрдүүлэх, зарлагыг Төсвийн тухай хуульд нийцүүлэх тухай холбогдох харилцааг зохицуулав. | |
| 1.3 | МУТХҮБ-ын 2.1 дэх хэсэг | Инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах | Инфляцийн түвшин, оны эцэст хувиар | 6.5 | - | Инфляцийн түвшин **2017 оны 12 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.4 хувьд** хүрч Монголбанкны зорилтот түвшинд нийцтэй гарлаа. 2017 оны эхэнд улсын хэмжээнд 1.1 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 0.5 хувиар хэмжигдэж байсан инфляци ийнхүү нэмэгдэхэд зарим хүчин зүйлс нөлөөллөө. Тухайлбал, оны эхний хагаст Үндэсний статистикийн хорооноос инфляцийг тооцох аргачлал болон хэрэглээний сагсны бүтээгдэхүүн, тэдгээрийн бүтцэд өөрчлөлт оруулав. Мах, хүнсний бүтээгдэхүүний үнэ өсч, нийлүүлэлтийн гаралтай инфляцийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлэв. Харин оны сүүлийн хагаст махны үнэ буурах хандлагатай болсон. Бусад бүтээгдэхүүний хувьд 3 дугаар улиралд сүү, хүнсний ногоо зэрэг хүнсний бүтээгдэхүүн, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хатуу түлш зэрэг дотоодын бараа болон хувийн боловсролын үнийн өсөлт инфляцийг голлон тайлбарлаж байсан бол 4 дүгээр улиралд эдгээр бүтээгдэхүүний инфляцийг нэмэгдүүлэх нөлөө багасч, улмаар инфляцийн түвшин саарах хандлагатай болов. Монголбанкнаас макро эдийн засаг, инфляцийн богино, дунд хугацааны төлөв байдалтай уялдуулан мөнгөний бодлогын төлөвийг алгуур сулруулах арга хэмжээг 2017 оны туршид авч хэрэгжүүлэв. | |
| 1.4 | МУТХҮБ-ын 2.1.6, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 1.4 дэх заалт | Дунд хугацаанд төсвийн үндсэн тэнцлийг зэрэг болгох нөхцөлийг бүрдүүлж, нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг өмнөх оны түвшингээс бууруулах | Нэгдсэн төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хэмжээ, хувиар | 9.1 | - | Олон Улсын Валютын сантай хамтран хэрэгжүүлэх "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд нэн тэргүүнд төсвийн нэгдмэл байдлыг бодитойгоор хангах, сахилга батыг чангатгах, төсвийн тогтвортой орлогын эх үүсвэрийг бий болгох, төсвийн зарлагын үр ашгийг сайжруулах замаар төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулахаар зорьж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд:<br>- Улсын Их Хурлын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөлөлд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2017 онд -9.5 хувь, 2018 онд -7.9 хувь, 2019 онд -6.2 хувь тус тус байхаар батлагдсан.<br>Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар батлууллаа. Уг хуульд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2018-2020 онд 23.8 хувь, 24.2 хувь, 24.3 хувь, зарлагын дээд хэмжээ ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2018-2020 онд 31.8 хувь, 30.4 хувь, 28.7 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2018-2020 онд -7.9 хувь, -6.2 хувь, -4.5 хувь тус тус байхаар хуульд тусгасан. Ийнхүү төсвийн алдагдлыг жилд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дунджаар 1.7 хувиар буурахаар төлөвлөсөн ба **2017 оны гүйцэтгэлээр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ -6.4 хувьтай гарлаа.** | |
| 1.5 | МУТХҮБ-ын 2.1.6, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 1.8 дахь заалт | Засгийн газар, Хөгжлийн банкны гадаад бондыг эргүүлэн төлөх эх үүсвэрийг шийдвэрлэж, дунд хугацаанд өрийн дарамтыг бууруулах бодлого хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Монгол Улсын Засгийн газар, Хөгжлийн банкны 580 сая ам.долларын Евро бондыг Засгийн газрын 7 жилийн хугацаатай, 8.75 хувийн хүүтэй Хуралдай бондоор солих саналыг бондын эзэмшигчдэд тавьж 2016 оны 3 сард нийт 476 сая ам.долларын бонд эзэмшигчид буюу 82.1 хувь нь энэхүү саналыг хүлээж авснаар хэлцэл амжилттай болсон. Дээрх хэлцэлтэй залгуулан Хөгжлийн банкны бондын үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэсгийг төлөх зорилгоор 124 сая ам.долларын Хуралдай бондыг нэмж арилжаалахаар зарласан бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчид уг бондыг авахаар нийт 3.3 тэрбум ам.доллар буюу 27 дахин илүү дүнтэй санал ирүүлж, эцсийн дүнгээр 124 сая ам. долларын бондыг 7.6 хувийн зах зээлийн өгөөжтэйгээр арилжаалсан. Хөгжлийн банкны евробондын өрийг хугацаанд амжилттай шийдвэрлэсэн. Монгол Улсын Засгийн газар 2018 оны 1 сард эргэн төлөгдөх 500 сая ам.долларын Чингис бонд, 2018 оны 6 сард эргэн төлөгдөх 1.0 тэрбум юанийн Дим сам бондуудыг болон зарим дотоодын үнэт цаасыг дахин санхүүжүүлэх зорилготойгоор олон улсын зах зээлд 800 сая ам.долларын Гэрэгэ бондыг 5.5 жилийн хугацаатай, 5.625 хувийн хүүтэйгээр 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдөр олон улсын зах зээлд амжилттай арилжаалсан. Чингис бонд болон Дим сам бондуудын хөрөнгө оруулагчдаас бондыг буцаан худалдан авах саналыг 5 хоногийн хугацаанд хүргүүлсэн. Үүний үр дүн 2017 оны 10 сард Чингис бондын хөрөнгө оруулагчдын 74.5 хувь, Дим сам бондын хөрөнгө оруулагчдын 9.5 хувь нь бондоо буцаан худалдан авах саналыг хүлээж авсан болно. Гэрэгэ бондын хөрөнгөөр Чингис, Дим сам | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бондын Тэндэр хийгдсэн хэсгийн төлбөрийг гүйцэлдүүлж, үлдсэн хэсгийг Төрийн сангийн дансанд 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр оруулж ирснээр Засгийн газрын гадаад бондын дахин санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэв. | |
| 1.6 | МУТХҮБ-ын 2.1 дэх хэсэг | Валютын орох урсгал түр зуур нэмэгдэх үед төгрөгийн нийлүүлэлтийг огцом нэмэгдүүлэхгүй байх, валютын нөөцийг хамгаалах зарчим баримталж, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх | Гадаад валютын албан нөөц, импортын сарын хэрэгцээгээр | 5-аас доошгүй | - | Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монголбанк 2017 онд нийт 20.01 тонн алт худалдаж авсан ба үүнээс 19.37 тонн алтыг цэвэршүүлж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлсэн. Олон Улсын Валютын сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд 700 гаруй сая ам.долларын санхүүжилт орж ирсэн. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар Олон улсын хөрөнгийн зах зээлд "Хуралдай", "Гэрэгэ" бондыг амжилттай гаргасан бөгөөд **Гадаад валютын улсын нөөц 2017 онд 3 тэрбум ам.долларт хүрч импортын 8.3 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.** | 100 |
| **Зорилт 2. Санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангана** | | | | | | | |
| 2.1 | МУТХҮБ-ын 2.1 дэх хэсэг, ЗГҮАХ-ийн 1.20 дахь заалт | Олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран санхүүгийн системийн тогтвортой байдлын үнэлгээ хийх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Олон Улсын Валютын сантай тохирсон хөтөлбөрийн хүрээнд бүх банкны актив хөрөнгийн чанарт гадаадын нэр хүнд бүхий мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэх арга хэмжээ авсан. Үнэлгээгээр банкуудын зээлийн эрсдэлийн удирдлага, барьцаа хөрөнгийн үнэлгээтэй холбоотой нөхцөл, шаардлагыг сайжруулах шаардлагатай гэж үнэлэгдэн төлбөрийн чадварын хувьд Монгол Улсын банкны салбар бүхэлдээ тогтвортой байна гэж Олон Улсын хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэгдсэн байна. | 70 |
| 2.2 | МУТХҮБ-ын 2.4, Зорилт 4 | Гадаадын банкны салбар нэгж байгуулах нөхцөл болон эрх зүйн | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | "Банкны зөвшөөрлийн журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд гадаадын банкны тодорхойлолтыг өөрчлөн шинэчилсэн. Мөн банк үүсгэн байгуулагч, банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагад | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | орчныг сайжруулах | | | | тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн илүү ойлгомжтой дэлгэрэнгүй байдлаар тусгасан. "Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам"-ыг боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А-190 дугаар тушаалаар батлуулав. | |
| 2.3 | ЗГҮАХ-ийн 5.6.6 дахь дэд заалт | Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах хууль, эрх зүйн орчныг сайжруулж, урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах хууль, эрх зүйн орчныг сайжруулах, урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэхээр холбогдох төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран судалгааны ажлыг эхлүүлээд байна. Үүнд:<br>- Дэлхийн банк групп, Олон улсын санхүүгийн корпораци /ОУСК/-тай хамтран хэрэгжүүлж буй "Хөрөнгө оруулалтын бодлого, Хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих нь" төслийн хүрээнд "Хөрөнгө оруулалтын шинэтгэлийн зураглал" гаргах, судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан, 2017 оны 1 дүгээр сарын 23-31-ний өдрүүдэд нийт 8 удаагийн уулзалт, 3 дугаар сарын 24-31-ний өдрүүдэд нийт 9 удаагийн уулзалт, ярилцлага, хэлэлцүүлгийг тус тус төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөллүүдтэй зохион байгуулан, Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, хөрөнгө оруулалтын потенциал, хууль эрх зүйн хэрэгжилт, бизнесийн үйл ажиллагаа явуулах нөхцөл, тулгамдаж буй хүндрэл, эрсдэл, хөрөнгө оруулалтын хамгаалал, хамгааллын механизм бий болгох талаар санал солилцож судалгаа, мэдээллийг цуглуулан ажилласан. "Хөрөнгө оруулалтын шинэтгэлийн зураглал" гаргах ажлын хүрээнд Дэлхийн банк групп, Олон улсын санхүүгийн корпорацийн экспертүүдтэй хамтран "Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтын потенциал", "Хөрөнгө оруулалтын бодлого, хууль эрх зүйн орчин" гэсэн 2 чиглэлээр мэдээлэл цуглуулах, судалгаа хийх, | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | анализ хийх дэд ажлын хэсгийг байгуулан 2017 оны 6 дугаар сарын 7-ны өдөр судалгааны явцыг танилцуулж, цаашид үргэлжлүүлэн судлах чиглэлийг харилцан тохиролцов.<br>- Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах чиг үүрэг бүхий Үндэсний хөгжлийн газрын даргын 2017 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн А/15 тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийг 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А-41 дүгээр тушаалаар Дэлхийн банк группын Олон улсын санхүүгийн корпорацитай хамтарсан "Хөрөнгө оруулалтын шинэтгэлийн зураглал гаргах" ажлын хэсэг болгож өөрчилсөн.<br>- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Үндэсний хөгжлийн газрын даргын хамтарсан 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А33/А49 тоот тушаалаар "Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр судалгаа хийх үүрэг бүхий" ажлын хэсгийг байгуулан холбогдох байгууллагуудаас судалгааг нэгтгэн авч анализ хийж, дүгнэлтийн төслийг боловсруулан "Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл"-д хүргүүлсэн. Уг дүгнэлтээр Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хийдэл, давхцал болон бусад салбарын хуулиудтай уялдахгүй байгаа зүйл заалтуудыг тодорхойлж өгөв. Хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийн талаар 5 заалт, Хөрөнгө оруулалтын тухай хуульд тодорхойлох шаардлагатай асуудлуудын талаар 12 заалт, бусад асуудлаар 4 заалт бүхий судалгааны тайланг гаргалаа.<br>Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т тусгагдсан төсөл арга хэмжээнээс тодорхой нэг төслийг сонгон хөрөнгө оруулалт босгох, санхүүгийн зураглалыг боловсруулахаар тохиролцож 2017 оны 10 дугаар сарын 21-ний өдөр "Эмээлт үйлдвэрлэл технологийн парк" | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төслийн нэгж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас бүрдсэн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж ажиллав. | |
| 2.4 | ЗГҮАХ-ийн 5.6.6 дахь дэд заалт | Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл байгуулж ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Засгийн газрын "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцийг шинэчлэн батлах тухай" 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 10 дугаар тогтоолын 2 дахь заалтад "Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг" Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын дэргэд байгуулан ажиллуулж, Ажлын албаны чиг үүргийг тус газрын Хууль, эрх зүйн газарт хариуцуулав.<br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 353 дугаар тушаалаар "Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн ажиллах журам"-ыг батлав.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын "Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай" 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 136 дугаар захирамжаар 17 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл байгуулагдав.<br>*<u>Зөвлөлийн хуралдааны мэдээлэл:</u>*<br>Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн анхны хуралдааныг 2017 оны 3 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж, Үндэсний хөгжлийн газраас гадаадын шууд хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, хөрөнгө оруулалтын гэрээнүүдийн үйл явц, хөрөнгө оруулагчдын гомдлыг барагдуулж буй байдлын талаар мэдээлэл хийсэн. Зөвлөлийн анхны хуралдаанаар судалгааны ажлын хэсэг байгуулахаар шийдвэрлэсний дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Үндэсний хөгжлийн газрын даргын хамтарсан 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А33/А49 тоот тушаалаар "Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр судалгаа хийх үүрэг бүхий" ажлын хэсгийг байгуулав.<br>Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөлийн хоёрдугаар хуралдааныг 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулж, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан “Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тоон мэдээлэл”, “Хөрөнгө оруулагчдын гомдол шийдвэрлэх механизмыг хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаанд оруулах санал” сэдвээр мэдээлэл хийж оролцлоо.<br>Зөвлөлийн ээлжит хуралдааныг 2017 оны 12 дугаар сарын 1-ний өдөр зохион байгуулж гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан “Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах” саналыг Үндэсний хөгжлийн газраас, Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны өнөөгийн байдалд өгөх урьдчилсан санал дүгнэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас танилцуулав.<br>*<u>Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөл байгуулагдсанаас хойш шийдвэрлэсэн гомдол:</u>*<br>“Мобиком нэтворкс” ХХК-ийн гомдлыг шийдвэрлэж Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн №01 дугаартай зөвлөмжийг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэв.<br>“Инфра Инвестмент Партнерс” ХХК, “Монцемент Билдинг Материалс” ХХК, “Алтайн зам” ХК-иас ирүүлсэн гомдол, хүсэлтэд хийсэн тайлбарыг 2017 оны 5 дугаар сарын 5-ны 01/456 тоот албан бичгээр хүргүүлэв. | |
| 2.5 | ЗГҮАХ-ийн 1.3, 1.4, 1.5 дахь заалт | Төсвөөс гадуурх санхүүжилтийг бүрэн зогсоож, төсвийн нэгдмэл байдлыг хангах, төсвийн урсгал зардал болон | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | - Төсвөөс гадуурх санхүүжилтийг зогсоох, төсвийн нэгдмэл байдлыг хангаж үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр Сангийн яам, бусад салбарын яам, Олон улсын валютын сантай хамтран өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн төслийг боловсруулах үеэр судлаж, судалгаанаас гарсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Хөгжлийн банкны төсвөөс эргэн төлөгдөх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад үр ашгийн шинжилгээ хийх | | | | нөхцөлтэй төсөл, арга хэмжээг улсын төсөвт нэгтгэх, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын эргэн төлөлтийг төлөвлөлтийн шатанд нь төсөвтэй уялдуулах, төсөвт учруулж болох дарамт, нөлөөллийг урьдчилан тодорхойлох, цаашид өрийн бичиг гаргаж хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэхгүй байх, ипотекийн зээлийг Засгийн газар хариуцан хэрэгжүүлэх зэргээр төсвийн нэгдмэл бодлого, сахилга батыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг тусган Улсын Их Хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн чуулганаар хэлэлцүүлэн батлууллаа.<br>- Төсвийн урсгал зардалд шинжилгээг хийж боломжит зардлыг багасгах талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын салбарын урсгал зардлын өөрчлөлт 82.9 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн салбарын урсгал зардлын өөрчлөлт 41.6 тэрбум төгрөгөөр тус тус буурахаар Монгол Улсын 2018 төсөвт тусгагдсан.<br>- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, зарцуулалтын үр ашигтай байдал, хөрөнгө оруулалтын үр өгөөж, хөрөнгийн бүртгэл болон тухайн төсөл хөтөлбөр, арга хэмжээний үр дүнд иргэд олон нийтийн сэтгэл ханамжтай байдал, мэдээллийн ил тод байдал зэрэгт судалгаа хийх аргачлалыг боловсруулж нийт 6 бүлэгт хамаарах 33 асуулт бүхий шалгуур үзүүлэлтийн дагуу 330 сумыг үнэллээ. Үүнд:<br>- Олон нийтийн оролцоо;<br>- Сумын төсвийн төлөвлөлт;<br>- Сумын төсвийн ил тод байдал;<br>- Сумын төсвийн гүйцэтгэл;<br>- Сумын хяналт, шинжилгээ үнэлгээ;<br>- Сумын өмчийн удирдлага. | |
| 2.6 | ЗГҮАХ-ийн 1.9, 1.10 дахь заалт | “Хөгжлийн банкны бонд, зээл болон “Үнэ тогтворжуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон зээлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдэд нөлөөлсөн нөлөөллийг тодорхойлж, холбогдох санал, дүгнэлт гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | " хөтөлбөрийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт үнэлэлт дүгнэлт өгөх, олон нийтэд мэдээлэх" | | | | боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Сангийн сайдын тушаалаар байгуулж, ажлын хэсгийн удирдамж, ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулах чиглэлд ажиллаж байсан боловч уг асуудлыг **1 дүгээрт** ОУВС өргөтгөсөн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газарт тавьсан нөхцөлийн дагуу УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 2 дугаар тогтоолоор байгуулагдсан Ажлын хэсэг хийж гүйцэтгэхээр туссан**, 2 дугаарт** Дэлхийн банкнаас Монгол Улсын Засгийн газарт Монголбанкны үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгүүлэх шаардлага тавьсантай холбогдуулж Сангийн яамнаас уг асуудлыг тус хөндлөнгийн аудитын асуудалд тусган дүгнэлт гаргуулах болсон. Хөндлөнгийн аудитыг олон улсын PWC аудитын компаниар хийлгэхээр болсон ба тус компани аудитын дүгнэлтээ танилцуулах юм. Тус ажлын хэсэг дүгнэлт гаргаж, 2017 оны 5 дугаар сард Улсын Их Хуралд танилцуулсан бөгөөд уг ажлын хэсгээс гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч 2017 оны 6 дугаар сарын 27-ны өдөр A184 тоот тушаал гаргасан бөгөөд уг тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО** | | | | | | | |
| **Зорилт 3. Мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний гарц, ашиг шимийг нэмэгдүүлнэ** | | | | | | | |
| 3.1 | МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.33 дахь заалт | Малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор малын удмын санг хамгаалж, үржил селекцийн аргаар шинэ үүлдэр, омгийг бий болгох | Импортоор авах болон дотоодод үйлдвэрлэх үхрийн гүн хөлдөөсөн үр, мян.тун | 100 | 0.004 Улсын төсөв | "Малын зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг өргөжүүлэх аян"-ы хүрээнд мал эмнэлэг, үржлийн газраас 9.1 сая төгрөгөөр санхүүжүүлэн, үржлийн үнэт чанар нь олон улсын түвшинд үнэлэгдсэн сүүний, мах-сүүний хосолмол, махны чиглэлийн өндөр ашиг шимт бухны гүн хөлдөөсөн үр, багаж, хэрэгсэл, шингэн азотоор хангаж дэмжлэг үзүүлэн ажилласнаар тайлант онд 9 аймгийн 22 сум, нийслэлийн 2 дүүрэгт нийт 2100 толгой үнээг зохиомлоор хээлтүүлсэн бөгөөд хээл авалт 74,2 хувьтай байна. Малын удмын сангийн үндэсний төвийн үндсэн үйл | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагаа болох шилмэл хээлтүүлэгч малаас үр үйлдвэрлэх ажлыг явуулын лабораторийн нөхцөлд гүйцэтгэн "Газар-Агро" ХХК-ийн ОХУ-аас импортлон цэврээр үржүүлж байгаа махны чиглэлийн Герефорд үүлдрийн 10 бухнаас 14.0 мянга, Дорнод аймгийн салбар нэгжид үржүүлж буй Барга үүлдрийн хуцнаас 4.0 мянган тун үрийг тус тус үйлдвэрлэн хөлдөөж Монгол Улсын малын үндэсний генийн санг арвижуулснаар тоо толгой нь буурч, үүлдэрлэг байдал нь алдагдан, ашиг шим нь буурч байгаа Сэлэнгэ үүлдрийн үхэр, Барга үүлдрийн хонины үржлийн чанарыг сайжруулахад чиглэгдсэн зохиомол хээлтүүлгийн ажлыг өргөжүүлэхэд шаардлагатай үрээр хангах, удмын санг нь хамгаалах боломжийг бүрдүүллээ. | |
| 3.2 | МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.32 дахь заалт | Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх | Хамрагдах малын тоо, сая толгой | 44-өөс доошгүй | 17.4 Улсын төсөв | Улсын хэмжээнд 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн албаны мэдээгээр давхардсан тоогоор 540 суманд 1140 удаагийн халдварт өвчний гаралт бүртгэгдэж нийт 20 төрлийн халдварт өвчнөөр 9984 мал өвчилсний 26.4 хувь буюу 2638 мал хорогдсон байна. Халдварт өвчний гаралт, өвчлөлийг өмнөх онтой харьцуулахад сумын тоо 57, гаралт 157, хорогдол 776 тохиолдлоор тус тус буурсан байна.<br>Хонины цэцэг өвчнөөс сэргийлэх вакцинжуулснаас хойш сүүлчийн тохиолдол 2017 оны 7 сард, бог малын мялзан өвчний сүүлчийн тохиолдол 2017 оны 10 дугаар сард бүртгэгдэж, 2017 оны 11 дүгээр сарын байдлаар тус өвчнүүдээр тайван байна. Шүлхий өвчний тухайд 2017 оны 1 дүгээр сараас эхэлсэн дэгдэлт нийт 9 аймаг, нийслэлийн 44 сум дүүргийг хамарснаас өнөөдрийн байдлаар 4 аймгийн 5 суманд хорио цээрийн дэглэм хэрэгжиж байна. Улсын хэмжээнд урьдчилсан гүйцэтгэлээр гоц халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад нийт 47.1 /шүлхий, цэцэг, бог малын мялзан/ сая толгой мал хамруулж, үйлчилгээний хөлсөнд 7.2 тэрбум | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөг олгохоос 5.5 тэрбум төгрөгийг олгосон байна. | |
| 3.3 | МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.36 дахь заалт | Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлж, бэлчээрт хөнөөл учруулдаг мэрэгч амьтан, шавьжтай тэмцэх | Нөөцөд авах нийт бэлчээрийн талбайн хэмжээ, мян.га | 750 | 1.734 Улсын төсөв | Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бэлчээр шинээр бий болгох судалгааны ажлын үр дүнд Хөвсгөл аймгийн Арбулаг сумын 45 мян.га, Бүрэнтогтох сумын 17.1 мян.га, Тосонцэнгэл сумын 1.0 мян.га, Цагаан-Уул сумын 17.2 мян.га, Төмөрбулаг сумын 7.6 мян.га, Цэцэрлэг сумын 87.1 мян.га нутгийг отрын бэлчээрээр ашиглах боломжтой болохыг тогтоосон. (175.8 мян.га.) Үүнээс: 2017 онд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутаг дахь 87.1 мян. га бэлчээрийг улсын тусгай хэрэгцээнд авахаар "Улсын тусгай хэрэгцээний отрын бэлчээрийн судалгаа хийх" үүрэг бүхий ажлын хэсэг тус суманд ажиллахаар төлөвлөсөн боловч сумын зөвшөөрөл гарахгүй байгаагаас ажил хийгдээгүй. | 70 |
| | | | Үлийн цагаан оготнотой тэмцэх талбайн хэмжээ, мян.га | 650 | | 2017 онд бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээнд нийт 1,8 тэрбум төгрөгийг төлөвлөсөн. Үлийн цагаан оготнын тодотгох судалгааг 12 аймгийн 78 суманд хийснээс 9 аймгийн 59 суманд 380.0 мянган га бэлчээрт тэмцэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Микробиологийн аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг "Шим" ХХК-тай гэрээ байгуулан 400.0 сая төгрөгөөр 2017 оны 5 дугаар сард Баянхонгор, Өвөрхангай аймгийн 50.0 мянган га бэлчээрт, 2017 оны 10 сард Өвөрхангай аймгийн Тарагт, Уянга, Нарийнтээл, Хайрхандулаан сумын 50.0 мянган га бэлчээрт нийт 100 га, энгийн механик аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг улсын төсвийн 768.0 сая төгрөгөөр 12 аймаг, аймаг дундын отрын бэлчээрт нийт **480.0 мян га** бэлчээрт зохион байгууллаа. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Царцаатай тэмцэх талбайн хэмжээ, мян.га | 100 | | Царцааны хөнөөлийн тодотгох судалгааг гаргуулж, Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай аймагт 89.8 мян.га-д царцаатай тэмцэх бэлтгэл ажлын хүрээнд 119.0 мянган төгрөгөөр царцаатай тэмцэх 13.5 мянган литр Карате бодисыг худалдан авч Баян-Өлгий аймагт 6.0, Ховд аймагт 6.0, Говь-Алтай аймагт 1.5 мянган литрийг тус тус хуваарилан хүргүүлсэн. Нийт 360.0 сая төгрөгийн санхүүжилтээр **89.8 мян. га-д** царцаатай тэмцэх ажлыг зохион байгуулсан. | |
| 3.4 | МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.45 дахь заалт | Газар тариалангийн салбарт лизингийн үйлчилгээг хөгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх | Техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийн хувь | 70.0 | 28.3 Улсын төсөв, Гадаад эх үүсвэр | "Газар тариалангийн техникийн шинэчлэл" төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ОХУ-д үйлдвэрлэсэн хөдөө аж ахуйн зориулалттай техник худалдан авахад зориулж ОХУ-ын Хөгжлийн банкнаас 10.0 сая ам.доллар (ойролцоогоор гадаадын эх үүсвэрээс 24.4 тэрбум, улсын төсвийн хөрөнгөөс 1.7 нийт 26.1 тэрбум төгрөг )-ын хөнгөлөлттэй зээлийг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан авав. Хөдөө аж ахуйн салбарт нэн хэрэгцээтэй 19 нэр төрлийн 543 ширхэг техник тоног төхөөрөмж нийлүүлснээр 48.0 мянган га талбайн уринш боловсруулах, 15.6 мянган га талбайд үр тариа тариалах, 27.3 мянган га талбайн үр тариаг технологийн хугацаанд хураан авах техник үйлдвэрлэлд шинээр нэвтрэв. Төслийн үр дүнд үр тариа үйлдвэрлэлийн техникийн шинэчлэл өнгөрсөн оныхоос 7 хувиар нэмэгдэж 70 хувьд хүрсэн. Улсын төсвийн 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр дунд оврын 19 трактор, хүнсний ногооны 27 иж бүрдэл техник худалдан авах ажил зохион байгуулав. Худалдан авсан трактор, техник, тоног төхөөрөмжийг техникээр төлбөртэй үйлчилгээ үзүүлдэг ногоочид, ногоочдын хоршоо, бүлэгт 2018 онд хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох болно. Ингэснээр нийт 600 га талбайн хүнсний ногооны хөрс боловсруулах, арчлах, хураах ажлыг механикжуулах нөхцөл бүрдсэн. | 100 |
| 3.5 | МУТХҮБ-ын 2.1.1, | Таримал ургамлын | Үрийн нөөц бүрдүүлэх аж | 3 | 1.5 Улсын төсөв | Ургамал газар тариалангийн хүрээлэнг түшиглэн Дархан-Уул аймгийн Хонгор, Өвөрхангай | **70** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.41 дэх заалт | үрийн аж ахуйг хөгжүүлж, нутагшсан сортын үрийн нөөц бүрдүүлэх замаар үрийн сорт, чанарыг сайжруулах | ахуйн тоо | | | аймгийн Хархорин суманд анхдагч үрийн аж ахуй байгуулан техникийн шинэчлэл хийх зорилгоор улсын төсвийн 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр трактор, үр тариа хураах комбайн, үрлүүр, сийрүүлүүр, хор шүршигч тус бүр 2 ширхгийг худалдан авах ажлыг зохион байгуулав. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлснээр 2018 оноос эхлэн улаанбуудайн 2500 тн, тэжээлийн болон сэлгээний таримлын 800 тн элит үр үйлдвэрлэж дотоодын хэрэгцээгээ хангадаг болно. Тариалангийн төвийн бүсээс үр тариа, тэжээлийн таримлын үр үржүүлэх 11 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, хамтран ажиллах гэрээ байгуулсан. Тариалан эрхлэлтийг дэмжих сан 2018 оны тариалалтад зориулж 39 аж ахуйн нэгжээс үрэнд тэнцсэн 23.4 мянган тн үрийн улаанбуудай авч нөөцөлснөөс үр үржүүлэгч “Эг тариа” ХХК, “Баян дулаан уул” ХХК-аас ганд тэсвэртэй “Бурятская остистая” сортын нийт 2450 тн улаанбуудайн үр худалдан авч үрийн нөөц бүрдүүлсэн. | |
| 3.6 | МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.44 дэх заалт | Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, хот суурин газрын хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах | Шинээр нэмэгдэх хүлэмжийн талбайн хэмжээ, мян.м$^2$ | 100 | 1.8 Улсын төсөв | 2017 оны 3 дугаар улиралд хүлэмжийн талбай 10.0 /50 мян.м.кв/ га талбайгаар нэмэгдсэн. Улсын төсвийн 1.65 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 720 иж бүрдэл 68.8 мянган м$^2$ талбай бүхий нийлэг хальсан хүлэмжийг тендер шалгаруулан нийлүүлж, нийслэл, 21 аймгийн хүнсний ногоо тариалагчдад 30 хувийн урьдчилгаатай, 4 жилийн хугацаатай зээлэнд хамруулсан. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 20.0 мянган м$^2$ өвлийн нийлэг хальсан хүлэмжийг байгуулав. | 40 |
| | | | Хүлэмжийн ургацын нэмэгдэх хэмжээ, мян.тонн | 4 | | | |
| 3.7 | МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.36 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.37 дахь заалт | Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн менежментийг сайжруулах эрх зүйн | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн менежментийг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор “Бэлчээр хамгаалах тухай” хуулийн төслийг боловсруулж байна. Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоотой хамтран “Монгол орны бэлчээрийн үндэсний форум”-ыг зохион байгуулж, бэлчээрийн доройтлыг хязгаарлах, зүй зохистой | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | орчныг бүрдүүлэх | | | | ашиглалтыг нэвтрүүлэх, зохицуулалт, хариуцлагыг өндөржүүлэх бодлогын шинэчлэлийн чиглэлээр томоохон хэлэлцүүлэг хийж саналыг тусган ажиллаж байна. | |
| 3.8 | МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.18 дахь заалт | “Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангах | Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | 30.0 | 0.2 Улсын төсөв | “Эрүүл хүнс–Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн төслийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу холбогдох тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагуудаас санал авахаар бэлтгэж байна.<br>Мах, сүүний анхдугаар аяныг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-45 дугаар тушаалаар батлуулж, тус төлөвлөгөөний дагуу 2017-2020 онд 5 зорилтын хүрээнд холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж байна.<br>Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг УИХ-ын 2017 оны 12 сарын 08-ны өдрийн чуулганаар баталсан. Малын генетик нөөцийн тухай” хуулийг УИХ-ын 2017.12.14-ний өдрийн хуралдаанаар батлав. Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 168 дугаар тогтоолоор “Гаалийн албан татвараас чөлөөлөх жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсийн жагсаалт”-ыг батлуулсан. Уг тогтоолын хүрээнд мах, сүү боловсруулах салбарын импортоор авсан мах, сүүны үйлдвэрийн тоног төхөөрөмж гаалийн албан татвараас чөлөөлөгдсөн.” Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар баталсан.<br>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон “Мах, сүүний анхдугаар аян”-ыг эрчимжүүлэх зорилгоор 2017 онд дотоодын эх үүсвэрээс санхүүжүүлэхээр “Махны болон сүүний чиглэлийн үхэр” үржүүлж буй аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл шалгаруулалтыг зохион байгуулсан. ХХААХҮ-ийн Сайдын 2017 оны А-127 дугаар тушаалаар нийт 11 аймаг, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийслэлийн ойролцоо, мах болон сүүний үхрийн аж ахуй эрхлэж буй 54 аж ахуйн нэгжид тус бүр 10-20 сая төгрөгний хөнгөлөлттэй зээл олгосон. Нийт төсөвт өртөг 800.000.000,0 /Найман зуун сая/ төгрөг. Мөн ХХААХҮ-ийн Сайдын А-135-р тушаалаар “Гацуурт” ХХК-иас зээлийн эргэн төлбөрт өгөх зээлийн гэрээний нөхцөл, стандартын шаардлага хангасан 200 толгой “Ангус” үүлдрийн хээлтэгч, хээлтүүлэгчийг Сэлэнгэ аймагт 65 хээлтүүлэгч, Удмын сангийн үндэсний төвд-5 хээлтүүлэгч, 20 өсвөр гунж Төв, Архангай, Хэнтий, Дорнод аймгуудад тус бүр 5, Дархан-Уул аймагт 4 хээлтүүлэгч, Мал хамгаалах санд 6 хээлтүүлэгч, 80 өсвөр гунжийг тус тус хувиарласан. Мал хамгаалах санд хувиарлагдсан6 хээлтүүлэгч, 80 өсвөр гунжийг төсөл сонгон шалгаруулалт зарлаж ХХААХҮ-ийн Сайдын А-146дугаар тушаалаар 4 иргэн, 2 аж ахуйн нэгжид 5 жилийн хугацаатай эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон.<br>Сүүний боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр тогтвортой хангах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйг дэмжих зорилгоор “Сүүний хөргөлтийн танк, цахилгаан хөдөлгөөнт саалтуур” нийлүүлэх тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан аж ахуй нэгжтэй гэрээ байгуулсан. Гэрээний дагуу нийлүүлсэн тоног төхөөрөмжийг 2017 оны 11-р сарын 23-нд хүлээн авч Мал хамгаалах санд шилжүүлсэн. Энэ арга хэмжээний дүнд сүүний хөргөлтийн танк 10 ширхэг, цахилгаан хөдөлгөөнт 144 ширхэг саалтуурыг сүүний чиглэлийн эрчимжсэн үхрийн аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй нөхцлөөр олгосон. “Мах, сүүний анхдугаар аян”-ы хүрээнд орон нутгийн сүүний нөөцөд тулгуурлан байгуулах хуурай сүүний бага, дунд оврын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг танилцуулах практик сургалт, хэлэлцүүлгийг “MDM” ХХК-тай хамтран 2017 оны 2-р сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Аяны хүрээнд 2017 оны 6-р сарын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 28-30-нд Архангай аймгийн Тариат суманд хөдөө, орон нутгийн сүүний нөөц ашиглалтыг сайжруулах, түүхий эд бэлтгэлийг хоршоодоор дамжуулж бэлтгэх, сүү, цагаан идээ боловсруулах талаар Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоотой хамтран уулзалт, зөвлөгөөн зохион байгуулсан. Аяны хүрээнд "Нэг Архангай шинэ хөгжлийн тэмүүлэл" ТББ-тай хамтран 2017 оны 6-р сарын 2-6-ны өдрүүдэд орон нутгийн сүүний нөөц ашиглалтыг сайжруулах, сүүн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэх, нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор "Цагаан идээ-зөв хэрэглээ" сургалт, зөвлөгөөнийг Архангай аймгийн Чулуут суманд зохион байгуулсан. Зөвлөгөөнд Архангай аймгийн 19 сумаас нийт 170 малчид, саальчид оролцсон. | |
| **Зорилт 4. Хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ** | | | | | | | |
| 4.1 | МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.20 дахь заалт | Хүнсний үйлдвэрлэлийн салбарын эрх зүйн орчныг сайжруулж, хүнсний хангамж, аюулгүй байдлыг дээшлүүлэх | Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | 3 | | 1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар Органик хүнсний тухай хуулийн хүрээнд гарах дараах журам, аргачлалын төслийг боловсруулж батлуулсан. Хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах багц 3 журмыг ХХААХ-ын сайд зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар батласан:<br>• Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам;<br>• Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулахад тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам;<br>• Органик хүнсний орцын найрлага тооцох аргачлал.<br>2.УИХ-ын нэр бүхий гишүүдээс Баяжуулсан хүнсний тухай хуулийн төслийг 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн.<br>3.Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуулийн төсөл боловсруулж байна.<br>4."Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт"-ын төслийг боловсруулсан.<br>5. УИХ-аас Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдөр баталсан.<br>6. Хоол үйлдвэрлэлийн салбарын эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.<br>7. Малын генетик нөөцийн тухай хуулийн төсөл 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар батлагдсан. | |
| | | | Хүнсний хангамж, аюулгүй байдал, хяналтын судалгаа хийх ажлын явц, хувиар | 100.0 | | 1. Согтууруулах ундааны хангамж, аюулгүй байдлыг хангах, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор согтууруулах ундаа үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, бүтээгдэхүүн экспортлох нөхцөл, боломж, арга замын талаарх судалгааны ажлыг хүнсний зөвлөх инженер, доктор Ц.Батсүхийн ахалсан багаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, хүлээж авсан.<br>2. "Хүнсний аюулгүй байдал" эрдэм шинжилгээний бага хурлыг 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдөр НҮБ-ын ХХААБ-ын суурин төлөөлөгчийн газар, Монголын хүнсчдийн холбоотой хамтран зохион байгуулсан. Тус бага хуралд хүнсний хангамж, хүртээмж, аюулгүй байдлын чиглэлээр нийт 33 судалгааны ажил ирснээс, зохион байгуулах ажлын хэсгийн зүгээс хянаж үзэн 20 илтгэлийг хэлэлцүүлж, оюутан болон судлаачийн тус бүр 3 илтгэл шалгаруулсан. Бага хурлыг жил бүр зохион байгуулах нь судалгааны ажлын цахим сан бүрдэх, судалгаанд тулгуурласан хүнсний аюулгүй байдлын бодлого, хөтөлбөр боловсруулахад чухал ач холбогдолтой.<br>3. Засгийн газрын 2017 оны 46 дугаар | |

тогтоолоор өгсөн үүргийн дагуу ХХААХҮЯ-наас ажлын хэсгүүдийг томилж, МХЕГ-тай хамтран улсын хэмжээнд 2017 оны 4-р сарын 17-ноос 5-р сарын 12-ны өдрийн хооронд согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтад Ховд, Дорнод, Өмнөговь, Увс, Баян-Өлгий, Дундговь, Хөвсгөл, Архангай, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Булган, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Төв аймаг болон Улаанбаатар хотын согтууруулах ундааны үйлдвэрүүдийг хамруулсан.

ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А-470 дугаар тушаалаар дараах нэр бүхий 11 компанийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 3 сарын хугацаагаар түдгэлзүүлж, МХЕГ, ТЕГ холбогдох аймаг, нийслэлийн ЗДТГ, татварын хэлтэст тус тус мэдэгдэл хүргүүлсэн.

1. "Трансинконсульт" ХХК /архи/
2. "Сэлэнгэ шим" ХК /архи/
3. "Алтайн дэлгэрэх" ХХК /архи/
4. "Мөнхийн болор" ХХК /шар айраг/
5. "Хаан брой" ХХК /шар айраг/
6. "Мини макро" ХХК /шар айраг/
7. "Интер стандарт брьюри" ХХК /шар айраг/
8. "Гүнжүү" ЗБН /шар айраг/
9. "Түшиг тулга трейд" ХХК /дарс/
10. "Морьт хангай" ХХК /архи/
11. "Арван ундрага" ХХК /архи/

Дээрх аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд МХЕГ-аас хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд тус газраас Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.3, 14.1.5 дахь заалтад тус тус заасны дагуу тусгай

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвшөөрлийг сэргээх эсхүл хүчингүй болгох талаар санал, дүгнэлт боловсруулан Засгийн газарт хүргүүлэхээр бэлтгэж байна. | |
| 4.2 | МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.54 дэх заалт | Хөнгөн үйлдвэрийн салбарыг бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хөнгөн үйлдвэрийн технологийн парк байгуулах | Ноос, арьс ширэнд олгох урамшууллын хэмжээ, тэрбум төгрөг | 38 | 35.3 Улсын төсөв | Арьс ширний урамшуулалд 2016 онд 9.5 тэрбум төгрөг байсан бол 2017 онд 12.7 тэрбум төгрөг болж өссөн байна. Ноосны урамшуулалд 2016 онд 19.3 тэрбум төгрөг байсан бол 2017 онд 22.6 тэрбум төгрөг болж өссөн. Нийт урамшуулалд 2016 онд 28.8 тэрбум төгрөг байсан бол 2017 онд **35.3 тэрбум төгрөгийн** урамшуулалыг тус тус олгосон байна. | 70 |
| | | | Технологийн парк байгуулах бэлтгэл ажлын явц, хувиар | 100.0 | | 2. Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоолоор Арьс, ширний үйлдвэрүүдийг Эмээлтийн үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг Засгийн газарт даалгасны дагуу "Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн ҮТП" Орон нутгийн өмчит тооцоот үйлдвэрийн газар, "Налайхын барилгын материалын ҮТП" Орон нутгийн өмчит тооцоот үйлдвэрийн газар, "Эрдэнэ хүнс САМО" ХХК зэрэг байгууллагуудад тусгай зөвшөөрлийг олгож, гэрээ байгуулж, "Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2017 оны 173 дугаар захирамжаар байгуулан ажиллаж байна. | |
| 4.3 | МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.15 дахь заалт | Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг санхүү, зээлийн бодлогоор дэмжих | Санхүүжүүлэх төслийн тоо | 400 | 49.8 Улсын төсөв | Жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай хөнгөлөлттэй зээлийг шалгаруулах, олгох, хяналт тавих журмын төслийг боловсруулан Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А/76 тоот тушаалаар батлан хэрэгжүүлэв. Журмын хүрээнд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр **154** төслийг 49,7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлж шинэ 30 үйлдвэр байгуулагдаж, 124 үйлдвэр үйл ажиллагаагаа өргөтгөсний үр дүнд шинээр 2811 ажлын байр бий болж 1373 ажлын байр хадгалагдаж үлдсэн байна. 2017 онд Сум | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжүүлэх сангаас Орон нутгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор **680** төсөлд 4.5 тэрбум төгрөг, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төслөөс **63** төслийг 29.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн. Зээлийн батлан даалтын сангаас **39** төслийг 7.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх батлан даалт гаргасан. | |
| 4.4 | МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.48 дахь заалт | "Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх 21:100" хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг эхлүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | 10.0 | 0.012 Улсын төсөв | Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/57 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөр боловсруулж, Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаар батлагдсан. Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн хүрээнд 2017 онд дараах аймгуудад үйлдвэрүүд байгуулагдсан. Үүнд: Увс аймагт "Хүмэн нэгдэл ХХК" мал төхөөрөх үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлсэн. Баян-Өлгий аймагт малын тэжээлийн үйлдвэр, Говь-Алтай аймагт ТИКА-ийн тусламжаар Халал аргаар мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр, Баянхонгор аймагт ЖДҮ-ийн инкубатор төвийг ашиглалтад оруулсан. Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай, Дундговь, Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ аймгуудад хуурай сүүний үйлдвэрийн барилгын ажил дууссан. Дархан-Уул аймагт дэл сүүл боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж оруулж ирсэн. Орхон аймагт Чех-Монголын хамтарсан мал төхөөрөх үйлдвэрийн барилгын ажлыг дуусгав. Хөвсгөл аймагт хуурай сүүний үйлдвэрийг байгуулсан. | 70 |
| 4.5 | МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 5.6.8 дахь дэд заалт | Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор | Зохион байгуулах үзэсгэлэн худалдааны тоо | 2-оос доошгүй | 0.088 Улсын төсөв | Монгол Улс, БНХАУ-ын хооронд байгуулсан "Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглалыг хэрэгжүүлэх зорилгоор "Монгол-Хятадын Экспо" хоёр дахь удаагийн хурал, форумын арга хэмжээ, Хөрөнгө оруулалтын чуулга уулзалт, Үзэсгэлэн худалдаа, Олон улсын соёлын арга хэмжээ гэсэн 4 үндсэн чиглэлээр нийт 22 арга | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | гадаад орнуудад "Монголд үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдааг зохион байгуулах | | | | хэмжээг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотноо 2017 оны 9 дүгээр сарын 26-30-ны өдрүүдэд зохион байгууллаа.<br>Уг арга хэмжээнд Монгол Улсад үйлдвэрлэсэн хүнс, хөнгөн үйлдвэрийн онцлох бараа бүтээгдэхүүнийг зохион байгуулагч тал импортын гаалийн албан татвараас чөлөөлөн аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлсэн. Монголын талаас 420 үндэсний үйлдвэрлэгчид оролцсон бөгөөд 3 өдрийн хугацаанд нийт 6.1 сая юань буюу 2.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийж өмнөх онтой харьцуулахад борлуулалтын хэмжээ 5 дахин өссөн дүнтэй байна.<br>АНУ-ын Чикаго болон Канадын Торонто хотод "Монголд үйлдвэрлэв-2017" үзэсгэлэн худалдааг 2017 оны 9 дүгээр сарын 13-25-ны өдрүүдэд зохион байгуулж, 20 гаруй аж ахуйн нэгж ноос, ноолуур, арьс шир, оёмол хувцас, гутал, гоо сайхны бүтээгдэхүүнээр оролцож, Монгол Брэндийг сурталчилж, бизнес форум зохион байгуулж, 280.0 сая орчим төгрөгийн бараа борлуулсан дүнтэй байна. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хянган аймгийн Улаан хотод Хятад, Монголын Олон улсын органик ногоон бүтээгдэхүүний үзэсгэлэнг Мишээл экспо ХХК-тай хамтран 2017 оны 5 дугаар сарын 25-30-ны өдрүүдэд зохион байгуулж Монголын талаас хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын 84 аж ахуй нэгж оролцлоо. | |
| **Зорилт 5. Геологи, уул уурхайн салбарын хөгжлийг дэмжиж, хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ** | | | | | | | |
| 5.1 | МУТХҮБ-ын 2.1.4, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.59 дэх заалт | Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор | Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар /1:50000 масштаб/ | 37.0 | 9.4<br>Улсын төсөв | 1. Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн 22 төслийн үр дүнг хүлээн авахаас 14 төслийн үр дүнг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, сайдын холбогдох тушаалуудаар хүлээн авсан. Ингэснээр нийт нутаг дэвсгэрийн **37.4 хувь бүрэн** хамрагдсан. Харин Цогт-50, Бурхант толгой-50, Дэвсгийн нуруу-50, Хөхөлзөгийн нуруу-50, Хулгарын элс-50, Улаантолгой-50, Өлийн овоот-50, Шивээт-50 төслүүдийн үр дүнг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэх | | | | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.<br>2. Үргэлжлэн хэрэгжих 12 төслийн төсөв, төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэв. Төслүүдийн хээрийн судалгааны ажилд шуурхай хяналтыг хийж хээрийн анхдагч баримт материалыг хүлээн авсан. Харин Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлын хүрээнд 2017 онд нийтдээ 6 төслийг шинээр хэрэгжүүлж эхэлсэн.<br>3. Баруун Монголын цул сульфид-2014, Металлогени-2014, Геомэдээллийн сан-2013, Сансрын зургийн тайлалт-2013 төслүүдийн төсөв, төлөвлөгөөг сайдын А/96, төслүүдийн ажлын аргачлал, хэмжээ, төсөвт тодотгол хийж сайдын А/241 дүгээр тушаалаар батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан. Үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.<br>4. Монгол орны төв, зүүн бүсийн алтны нөөцийн хэтийн төлвийн үнэлгээ хийх геологийн судалгааны ажлын ТЗМ-Алт-2017 төслийн геологийн даалгавар болон ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулав. Төслийн хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авлаа.<br>5. Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан "Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени" төслийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн хүлээн авлаа. | |
| | | | Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар /1:200000 масштаб/ | 100.0 | | **Улсын геологийн 1:200000-ны** масштабын иж бүрдэл зураг зохиох 4 төслийн үр дүнгийн 4 тайланг хүлээн авахаас УГЗ-200-ТМ-VI төслийн үр дүнгийн тайланг хүлээн аваад байна. УГЗ-200-ТМ-V, УГЗ-200-ДМ-VI, VII төслийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.<br>**1:200000** масштабын геологийн эрэл хайгуулын ажилд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулсан бөгөөд 1:200000-ны масштабын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иж бүрдэл зургийг нэгтгэх төсөл К хавтгайн хэмжээнд үргэлжлэн хэрэгжиж байна. Төслийн 2017 оны төсөв, төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авлаа.<br>Агаарын геофизикийн Алтай-1, Алтай-2, Ховд-1 төслүүдийн 2017 оны ажлын төлөвлөгөө, төсвийг баталж, хэрэгжилтийг ханган ажиллав. Төслүүдийн 2017 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авсан. | |
| 5.2 | МУТХҮБ-ын 2.1.4, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.24 дэх заалт | Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, Тавантолгойн орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцлийг байгуулж, төслийн үйл ажиллагааг эхлүүлэх | Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар | 20.0 | | Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд далд уурхайн босоо амны малталтууд, хөндлөн нэвтрэлтүүд, туслах дэд бүтцийн ажлууд ахицтай үргэлжилж байна.<br>Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажил 2017 оны жилийн эцсийн байдлаар:<br>✓ Хос налуу амын нийт нэвтрэлт (конвейерийн налуу ам, үйлчилгээний налуу ам) 1600 метр болсон.<br>✓ Далд уурхайн 2 дугаар босоо аманд 1284 метр нэвтрэлт хийхээс 2017 оны 11 дүгээр сарын байдлаар 1268 метрт хүрээд байна.<br>✓ 5 дугаар босоо аманд 1178 метр нэвтрэлт хийхээс 2017 оны 11 дүгээр сарын байдлаар 1007 метрт хүрсэн.<br>✓ Хөндлөн болон хэвтээ нэвтрэлийн ажлууд 6101 метрт хүрсэн бөгөөд гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу явагдаж байна.<br><br>Төслийн нийт капитал хөрөнгө оруулалтын төсөв 5.34 тэрбум ам доллар бөгөөд нийт 1.4 тэрбум ам.долларыг Монгол компаниудтай гэрээлээд байна.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 155 дугаар Захирамжаар "Уул уурхайн Бодлогын зөвлөл"-ийг байгуулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 256 дугаар тушаалаар Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн төлөвлөгөөнд санал дүгнэлт өгөх | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд санал, дүгнэлтээ танилцуулсан. | |
| | | | Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцлийг байгуулах ажлын явц, хувиар | 100.0 | | Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 104 тоот захирамжаар Тавантолгойн ордод хөрөнгө оруулж, хамтран ажиллахаар шалгарсан хөрөнгө оруулагчтай хийх гэрээний нөхцөлийг сайжруулж, хэлэлцээр хийх ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн удирдамжийг баталсан.<br>Ажлын хэсэг Тавантолгойн ордоос олборлосон нүүрсийг БНХАУ болон гуравдагч зах зээлд борлуулах бүтцийг тодорхойлох, төмөр замын суурь бүтцийг барьж, тээвэрлэлтийн үйл ажиллагааг эрхлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт нэн тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр нийлүүлэх, Тавантолгойн ордыг ашиглах ТЭЗҮ-ийг гэрээ байгуулснаас хойш 9 сарын дотор боловсруулах зэрэг чиглэлүүдээр хөрөнгө оруулагчтай хийх гэрээний саналыг боловсруулсан.<br>Хөрөнгө оруулагчид болох БНХАУ-ын Чайна Шэнхуа Энержи Компани Лимитед, Энержи Ресурс ХХК болон Сумитомо Корпорацийн төлөөлөлтэй уулзалт хийж ажлын хэсгийн удирдамжид заасан асуудлаар Монголын талын саналыг хүргүүлээд байгаа бөгөөд хөрөнгө оруулагчдын зүгээс ямар нэг хариу ирүүлээгүй байна.<br>Мөн Таван толгойн ордыг иж бүрнээр ашиглах тухай (төмөр зам, авто зам, баяжуулах үйлдвэр, усан хангамж, ордыг түшиглэсэн аж үйлдвэрийн цогцолбор) төлөвлөгөө боловсруулан Монгол Улсын Ерөнхий сайдад 2018 оны 1 дүгээр сарын 8-ний өдөр, Засгийн газрын хуралдаанд 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр тус тус танилцуулсан. | |
| 5.3 | МУТХҮБ-ын 2.1.4, | "Алт-2 хөтөлбөр"-ийг | Хөтөлбөр боловсруулж, | 100.0 | - | "Алт-2" хөтөлбөрийн төслийг Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.68 дахь заалт | боловсруулан батлуулж, хэрэгжилтийг эхлүүлэх | батлуулах ажлын явц, хувиар | | | аялал жуулчлалын сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2016 оны 403, А/68, А/136, А-339 тоот хамтарсан тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг эцэслэн боловсруулж Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, 20 дугаар тогтоолоор батлав.<br>“Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 2017 оны А/66, Сангийн сайдын 202, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/174, Монгол банкны ерөнхийлөгчийн А-166 дугаар хамтарсан тушаалаар баталсан.<br>“Алт-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:<br>- 2017 оны 3 дугаар сарын 17-ны өдөр “Монгол алт 2017”, 3 дугаар сарын 23-24-ны өдрүүдэд “Монголын геологи хайгуул 2017” чуулганд хөтөлбөрийн талаар танилцуулга илтгэл хийгдэж, төр, хувийн хэвшил, мэргэжлийн холбоод зөвлөлдөж, хамтын ажиллагааг эхлүүлсэн.<br>- 2017 оны 6 дугаар сарын 16-22-ны хооронд УУХҮЯ-ны Төрийн бичгийн даргын 85 дугаар тушаалаар УУХҮЯ, АМГТГ-ын удирдах болон холбогдох хүмүүсийн бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг байгуулан бүх аймгууд сумдаар ажиллуулж салбарын цаг үеийн асуудал, Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг суртчилан танилцуулж, зарим аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай газар дээр танилцаж, тулгамдаад байгаа асуудлуудаар санал солилцсон.<br>- Санхүүжилт шаардлагатай байгаа алтны төслийн судалгааг гаргаж Хөгжлийн банкинд хүргүүлсэн ба одоогийн байдлаар Хөгжлийн банк зээллэг хүссэн 25 аж ахуйн нэгжийг судалж, материалын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүрдэл хангасан 8 аж ахуйн нэгжид 24,8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон.<br>- Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/62, А-98 тоот хамтарсан тушаалаар Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх талаар судалгаа хийж, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монголбанк, Стандарт хэмжил зүйн газар, “Эрдэнэс Монгол”ХХК -ийн төлөөлөл оролцсон Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн технологийн харьцуулсан судалгааны ажлуудыг тус тус гүйцэтгэсэн байна. | |
| 5.4 | МУТХҮБ-ын 2.1.4, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.61 дэх заалт | Ашиглахад бэлэн болсон уурхайн үйл ажиллагааг эхлүүлж, олборлолт, экспортыг нэмэгдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | 2017 онд нийт 46 аж ахуйн нэгж Улсын комисс ажлуулах хүсэлт ирүүлсэн, бичиг баримтын бүрдэл хангасан 20 уурхай, 1 баяжуулах үйлдвэрт Улсын комисс ажиллаж, цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг өгч, ажиллав. | 70 |
| 5.5 | МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 3, 4 ЗГҮАХ-ийн 2.71, 2.72, 2.73 дахь заалт | Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар | 100.0 | | Засгийн газрын 2017 оны 88 дугаар тогтоолоор "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх байршил болон хүчин чадал өөрчлөгдсөнтэй холбогдуулан Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн захиалгаар хийж гүйцэтгэсэн БНХАУ-ын “ENFI” компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг тодотгох боломжгүй болсон. Цаашид Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийн хөрөнгө оруулагч үйлдвэрийн хүчин чадал, байршилд тохируулан **ТЭЗҮ-ийг шинээр боловсруулах шаардлага тулгарч байна.** Үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/109 тоот тушаалаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр" барих | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талбайн байршлыг төмөр зам, эрчим хүчний хангамж болон бусад дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлттэй уялдуулан тодорхойлох зорилгоор “Оюутолгой” ХХК-ын удирдлага болон орон нутгийн төр, захиргааны байгууллагуудтай Өмнөговь аймагт уулзалт зохион байгуулж ажилласан бөгөөд ЗТХЯ, “Оюутолгой” ХХК болон “Монголын Төмөр Зам” ТӨХК-тай үйлдвэрийн байршлын асуудлаар хэлэлцэж газрыг урьдчилсан байдлаар товлон, 2018 оны газар хуваарилалтын төлөвлөгөөнд тусгуулахаар холбогдож материалыг бүрдүүлэн Өмнөговь аймгийн Засаг даргад хүргүүлэв. | |
| | | | “Уул уурхай, металлургийн цогцолбор” төслийн 2 дугаар шатны барилгын ажлын явц, хувиар | 10.0 | | “Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл”-ийн ТЭЗҮ-ийн эцсийн тайланг 2017 оны 9 дүгээр сард уг төслийн зөвлөх “Hatch” компани ажлын хэсэгт танилцуулсан ба ТЭЗҮ-ийг урьдчилсан байдлаар хүлээн авсан. Тус төслийн Байгаль орчны нөлөөлллийн нарийвчилсан үнэлгээг 2018 оны 1 дүгээр улиралд хүлээн авахаар Дэлхийн банкнаас хугацааг сунгасан. Мөн газар доогуур инженерийн шугам сүлжээг байгуулах зураг төслийн ажлыг хийж гүйцэтгэж байгаа ба төвийн дулааны шугам сүлжээнд гангийн үйлдвэрийн барилгыг холбосон. Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК нь 2017 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр евро стандартад нийцсэн, жилд 20 000 тонн ган бөмбөлөг үйлдвэрлэх хүчин чадалтай, давтах аргын технологитой үйлдвэрийг ашиглалтанд оруулж нээлтээ хийсэн. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийг Герман Улсын "Shuler" компани, бусад дагалдах төхөөрөмжийг Итали улсад үйлдвэрлэж, нийлүүлсэн болно. | |
| | | | Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн | 100.0 | | “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл”-ийн үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийн эцсийн тайланг 2017 оны 5 дугаар сарын 5-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Шинжлэх ухаан, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ТЭЗҮ боловсруулах, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх ажлын явц, хувиар | | | технологийн зөвлөлийн Хүнд үйлдвэрийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж хүлээн авсан.<br>Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төслийн "Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ"-г гүйцэтгэгч "Грийн трендс" компани урьдчилсан тайлангаа 2017 оны 7 дугаар сарын 03-ны өдөр УУХҮЯаманд хүлээлгэн өгсөн. Урьдчилсан тайланд төслийн нарийвчилсан ТЭЗҮ-тэй холбоотой зөвлөмж, дүгнэлтүүд гарсан бөгөөд УУХҮЯ-ны дэргэдэх "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх нэгж"-ээс холбогдох саналыг Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компанид хүргүүлсэн.<br>Зөвлөх компани дээрх зөвлөмж, дүгнэлтийг нарийвчилсан үнэлгээнд тусган 2017 оны 8 дугаар сарын 24-ний өдөр эцсийн тайланг хүлээлгэн өгөөд байна.<br>Зөвлөх компани "Бүс нутгийн байгаль орчны үнэлгээний тайлан"-г "Дэлхийн банк", "Уул уурхайн дэд бүтцийг хөгжүүлэх" төслүүдэд хүргүүлж, дүгнэлт гаргуулсан. | |
| 5.6 | МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.63, 2.70 дахь заалт | Газрын тосны эрэл, хайгуул, олборлолтыг тогтвортой нэмэгдүүлж, газрын тос боловсруулах үйлдвэрийг барих бэлтгэл ажлыг хангах | Нарийвчилсан ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар | 100.0 | - | Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн "Төрийн өмчит компани" байгуулах тухай 92 дугаар тогтоол батлагдаж "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэх 100 хувь төрийн өмчит компани байгуулахаар шийдвэрлэсний дагуу "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.<br>Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг хийж гүйцэтгэх Зөвлөх компанийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2017 оны 2 дугаар сараас 8 дугаар сарын хооронд зохион байгуулж улмаар Энэтхэг Улсын "Инженерс Индия Лимитед" компани шалгарч Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гурвалсан гэрээг УУХҮЯ, Монгол газрын тос ТӨХХК-тай 2017 оны 8 дугаар сарын 9-ний өдөр | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулсан. Гэрээний дагуу зөвлөх компанийн төлөөлөгч нар нарийвчилсан ТЭЗҮ хийх ажлын хүрээнд Монгол Улсад 2017 оны 9 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд албан айлчлал хийж Дорноговь аймгийн Алтанширээ сумдад ажиллаж, үйлдвэр барих талбай, үйлдвэрт ашиглах усны эх үүсвэрийн талбай, бусад дэд бүтэцтэй танилцсан. Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компани үйлдвэрийн байршил, дамжуулах хоолойн трассын төлөвлөлттэй холбоотой байрзүй, геодези, инженер-геологи, усны судалгааны ажлыг хоёр улсын Зээлийн ерөнхий хэлэлцээрт тусгасны дагуу Монгол Улсын туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхээр болж, туслан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2017 оны 8-10 дугаар сарын хооронд зохион байгуулж "Престиж Инженеринг" ХХК шалгарч 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээг Зөвлөх компанитай байгуулж, орон нутагт хийх судалгааны ажлыг эхлүүлээд байна.<br>УУХҮСайдын 2017 оны А/208 тушаалаар "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулахад шаардагдах мэдээ мэдээлэл, тоо баримт бэлтгэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, төслийн судалгааны ажилд шаардлагатай газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа, стандарт, дүрэм журам, үйлдвэрийн байршил, дамжуулах хоолойн трассын төлөвлөлттэй холбоотой байр зүй, геодези, инженер-геологи, байгаль орчин, цаг уур, дэд бүтэц, түүхий эдийн хангамж, зах зээлийн талаарх мэдээ, мэдээлэл, тоо баримт, судалгаа шинжилгээний материалуудыг Энэтхэгийн Зөвлөх компанид бэлтгэн хүргүүлсэн. Дээрх мэдээ, мэдээлэлд үндэслэн БНЭУ-ын Зөвлөх компани төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн Эхлэлийн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ирүүлээд байна. Төслийн ТЭЗҮ-ийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тооцоо, судалгаа, техник, тоног төхөөрөмжийн сонголт, үйлдвэрийн болон дамжуулах хоолойн технологийн горимийг Монгол Улсын нөхцөл байдалд тохируулсан эсэхэд хяналт тавих үүднээс нарийвчилсан ТЭЗҮ-д хөндлөнгийн хяналт тавьж, дүгнэлт гаргах "Захиалагчийн инженер" (Owner's Engineer) компанийг нээлттэй сонгон шалгаруулах ажлыг 2017 оны 8-11 дүгээр сарын хооронд зохион байгуулж, Итали Улсын "КТ-Кинетикс технолоджи СПА" компани шалгарч гэрээ байгуулах хэлэлцээрийн шатандаа явж байна. | |
| **Зорилт 6. Бодит салбарын өсөлтийг хангах эрчим хүчний бодлого хэрэгжүүлж, эрчим хүчний эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ** | | | | | | | |
| 6.1 | МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.97 дахь заалт | Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх | Дарханы ДЦС-ын барилгын ажлын явц, хувиар | 100.0 | | Сангийн яам, Эрчим хүчний яам, Дарханы дулааны цахилгаан станц, ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн банкны төлөөлөгчид оролцсон хуралдааны шийдвэрийн дагуу төслийн нэмэлт зээл болох 4.5 сая еврогийн зээлийн гэрээнд гарын үсэг зурах эрх олгосноор 2017 оны 6 дугаар сард Сангийн сайд гэрээг зурж баталгаажуулсан.<br>Мөн төсөлд дахин шаардлагатай байгаа 5 сая еврогийн асуудлыг хэлэлцэн ХБНГУ-ын талаас зээл хэлбэрээр Монгол Улсын Засгийн газарт олгохоор шийдвэрлэсний дагуу 2017 оны 6 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж Сангийн сайд гэрээг зурж баталгаажуулсан. Төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг ХБНГУ-ын хуулийн дагуу зохион байгуулан, тус улсын Сэргээн босголтын зээлийн банкнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр гүйцэтгэгчээр БНХАУ-ын "China energy engineering group" компанийг шалгаруулж тус компанитай 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр гэрээ байгуулсан. Төслийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч компани нь 2017 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>40000Квт трансформатор угсарч суурилуулсан өргөтгөлийн барилгын түр ханын суурийг хийсэн. | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Одоогийн байдлаар төслийн талбайд өргөтгөлийн барилгын төмөр хийцийн угсралт, эргэлтийн усны насос станцын шугамын тулгууруудын ажил, 6кв-ын хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил, хөргөгч цамхагын авлагын ажлууд тус тус хийгдэж байна. Нэмэлт санхүүжилтийн хүрээнд олон улсын тендерийг зарлаж төслийн гүйцэтгэгчээр БНХАУ-ын "ТЕРС" компани шалгарсан. Төслийн гүйцэтгэгчээр шалгарсан БНХАУ-ын "ТЕРС" компанитай 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр гэрээг хийж, барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна. Мөн үндсэн тоног төхөөрөмжүүдийг үйлдвэрлэсэн ОХУ-ын Калугын турбины үйлдвэр, генератор үйлдвэрлэсэн Привод компаниудтай хамтран ажиллах гэрээг хийж байна. | |
| | | | Эрдэнэтийн ДЦС-ын барилгын ажлын явц, хувиар | 10.0 | | Төслийн гүйцэтгэгчээр БНХАУ-ын "Hunan Industrial Equipment Installation" компани шалгарч 2017 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр гэрээг байгуулсан. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Экспорт Импортын банкны хооронд байгуулсан зээлийн ерөнхий гэрээний дагуу төсөл болон төслийн гүйцэтгэгчээр шалгарсан компанид аудит хийх ажил явагдаж байна. Төслийн барилга угсралтын ажлыг 2018 онд эхлүүлж, 2020 онд дуусган ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Мөн Сангийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 105 дугаар тушаалаар Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулан ажиллаж байна. | |
| | | | ДЦС-3, Чойбалсангийн ДЦС-ын өргөтгөлийн санхүүжилтийн гэрээ байгуулах ажлын явц, хувиар | 100.0 | - | Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Эрчим хүчний яамны ТНБД-ын 2017 оны 19 дүгээр тушаалаар байгуулсан.<br>**Чойбалсангийн ДЦС-ыг** өргөтгөх төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр, **ДЦС-3-ын** өргөтгөлийн төслийн гүйцэтгэгчийг 3 дугаар сарын 6-ны тус тус зарлаж, 3 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд хүлээн авч үнэлгээг хийв.<br>**Чойбалсангийн ДЦС-ыг** өргөтгөх төслийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гүйцэтгэгчээр шалгарсан БНХАУ-ын “CITIC HIC Engineering and Technology” компанид тус яамнаас 2017 оны 04 дугаар сарын 26-ны өдөр 84.9 сая.ам.доллараар, **ДЦС-3-ын өргөтгөлийн** төслийн гүйцэтгэгчээр шалгарсан БНХАУ-ын “Чайна чангжиан энержи корпораци, Хунан индустрал экүйпмент инсталэйшн” компанид тус яамнаас 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн в/1433 тоот албан бичгээр 414.9 сая.ам.доллараар гэрээ байгуулах мэдэгдлийг тус тус хүргүүлсэн.<br>Гэвч төслийн хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх нөхцөл нь тодорхойгүй байсан тул төслийн гэрээг цуцлах тухай мэдэгдлийг БНХАУ-ын “CITIC HIC Engineering and Technology”, “Чайна чангжиан энержи корпораци, Хунан индустрал экүйпмент инсталэйшн” компаниудад хүргүүлээд байна.<br>2018 оны 1 дүгээр 4-ний өдрийн Засгийн газрын 01 дүгээр тогтоолоор ДЦС-3, ДЦС-4-ын өргөтгөлийн ажлыг ОХУ-ын Засгийн газрын зээлийн хүрээнд санхүүжүүлэхээр шийдвэр гарсан байна.<br>Тус тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 10 тоот тушаалаар ажлын даалгаварыг тодотгохоор ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. | |
| 6.2 | МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.98 дахь заалт | Өмнөд говийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах хүрээнд Тавантолгойн цахилгаан станцыг байгуулах бэлтгэл ажлыг хангах | Бэлтгэл ажлыг хангах ажлын явц, хувиар | 100.0 | - | Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 65 дугаар тушаалаар Тавантолгойн цахилгаан станцын төсөл хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулсан. Тус ажлын хэсэг Тавантолгойн цахилгаан станцын төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Эрчим хүчний яам, Хөгжлийн банкны хооронд хийгдэх гэрээний төслийг боловсруулах, өмнө байгуулсан “төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай” гэрээг дүгнэх ажлуудыг хийсэн. Ажлын хэсгээс Монгол Улсын Засгийн | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын 2017 оны 42 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж, Тавантолгойн цахилгаан станцын төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2014 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан "3-ДЦ-Б 2014-09" дугаартай "Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ"-ний дагуу үргэлжлүүлэн Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх саналыг Сангийн яаманд хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Төслийн хөрөнгө оруулагч Маребуни, Эм Си Эс компанийн түншлэл "450 МВт-ын ДЦС барих" төслийн "Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ"-ний хэлэлцээрийг Оюу толгой компанитай хийж байна.<br>Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаас "Өмнөд бүсийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах гэрээ"-г цуцлах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг даалгасны дагуу 2014 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Улаанбаатар хотноо байгуулсан "Өмнөд бүсийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах гэрээ"-г цуцалсан. | |
| 6.3 | МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.100 дахь заалт | Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн барилгын ажлыг үргэлжлүүлэх | Барилгын ажлын явц, хувиар | 50.0 | | Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн барилгын ажлыг эхлүүлэх ажлын хүрээнд:<br>Дархан-Уул аймгийн Хонгор суманд **10 МВт**-ын нарны станц 2017 оны 1 дүгээр сард ашиглалтад орсон.<br>Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт баригдах **50 МВт**-ын хүчин чадалтай салхин цахилгаан станц төслийн барилга угсралтын ажил дуусан 11 дүгээр сард ашиглалтад орсон.<br>Улаанбаатар хотын СХД-ийн нутаг дэвсгэрт Эвридэй ХХК-ийн **10 МВт-ын** нарны станц 2017 оны 11 дүгээр сард ашиглалтад орсон.<br>Дорноговь аймгийн Сайншанд суманд баригдах **55 МВт-ын** хүчин чадалтай Сайншандын салхин паркийн санхүүгийн хаалтын гэрээг хийсэн. Барилга угсралтын ажил 2017 оны 9 дүгээр сард эхэлсэн бөгөөд 2018 онд ашиглалтад орно.<br>Люкстюм ХХК Төв аймгийн Зуунмод сум **9 МВт**-ын нарны станцын төслийн ажлаа эхлүүлэхээр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдох зөвшөөрлөө аваад 2017 оны 6 дугаар сарын 3-ны өдөр шав тавьсан.<br>Нарантээг ХХК Дорноговь аймгийн Замын-Үүд суманд 15 МВт, Дезорт солар даур ваун ХХК Дорноговь аймгийн Сайншанд суманд **30 МВт-**ын нарны цахилгаан станц барихаар Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулаад байна. | |
| 6.4 | МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.101 дэх заалт | Бүс нутгийн эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлэх | Барилгын ажлын явц, хувиар | 10.0 | | **Оюутолгой-Цагаансуваргын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын талаар:**<br>Оюутолгой-Цагаансуваргын 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийн барилга угсралтын ажлыг “Барих-шилжүүлэх” нөхцөлөөр “МАК” компанитай “Шууд гэрээ” байгуулах концессын гэрээний төслийг бэлтгэж 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүлсэн. Төслийн нийт төсөвт өртөг 32.2 сая.ам доллар бөгөөд үүний 23.4 сая ам.доллар нь барилга угсралтын ажилд, 8.8 сая ам.доллар нь зээлийн хүүгийн зардалд зарцуулагдахаар тооцсон байна.<br>Төслийн барилга угсралтын ажлыг Барих-Шилжүүлэх нөхцөлтэйгээр байгуулсан концессийн гэрээний дагуу МАК компани Оюутолгой-Цагаансуваргын 220 кВ-ын 2 хэлхээт 159.5 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилгын ажлыг дуусгаж 2017 оны 6 дугаар сарын 19-ний өдөр ашиглалтад оруулжээ.<br>Энэхүү шугамын ажил дууссанаар Дорноговь аймгийн Мандах, Хатанбулаг сумдыг төвлөрсөн эрчим хүчний системээс эрчим хүчээр хангах төдийгүй тус бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхай болон барилгын материалын үйлдвэрүүдийг найдвартай эрчим хүчээр хангах нөхцөл бүрдэж байна.<br>**Багануур-Чойрын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын талаар:**<br>Эрчим хүчний яамнаас 2017 оны 1 дүгээр сарын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 27-ны өдөр “Түлхүүр гардуулах гэрээгээр өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх нөхцөлтэй Багануур-Чойрын 220 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, Багануур дэд станцын төслийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх ажлын Олон Улсын нээлттэй тендерийг зарласан. Уг тендерт БНХАУ-ын “Хэйлунгжиан барилга угсралтын групп” компани шалгарсан.<br>Засгийн газрын 2016 оны 180 дугаар тогтоолын 2 дугаар заалтад заасны дагуу төслийн ажилд гүйцэтгэгчээс гаргасан хөрөнгө оруулалтын ажлын зардлыг буцаан төлөх тухай асуудлын талаарх албан бичгийг “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний хамт 2017 оны 7 дугаар сарын 6-ны өдөр а/2173 тоот албан бичгээр холбогдох байгууллагад хүргүүлсэн болно. Төслийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлт хийгдэх нөхцөл тодорхойгүй гэсэн үндэслэлээр чиглэл, зөвшөөрөл өгөх боломжгүй болсон тул гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлсэн.<br>**Чойр дэд станцын талаар:**<br>Чойр дэд станцын өргөтгөлийн барилга угсралтын ажлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр барьж байгуулахаар Засгийн газрын 2016 оны 180 дугаар тогтоол гарсан.<br>Өмнө хийгдсэн концессын гэрээний хэлцлийг үргэлжлүүлэх саналыг Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн. Концесст шалгарсан компанитай гэрээний хэлэлцээр хийж, гэрээ байгуулсан. Төслийн нийт төсөвт өртөг 31.7 сая ам доллар. Одоогийн байдлаар барилга угсралтын ажил 60 хувьтай явж байна.<br>**Улаанбаатар-Мандалговийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын талаар:**<br>Улаанбаатар-Мандалговийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийн шав тавих ёслолыг 2017 оны 6 дугаар сарын 21-ний өдөр хийж, барилга угсралтын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлыг БНХАУ-ын "TBEA" компани эхлүүлээд байна.<br>Төслийн нийт төсөвт өртөг – 120.0 сая ам.доллар Төслийн зураг төсөл хийгдсэн. Тоног төхөөрөмжийн сонголтыг хийсэн. Мөн цахилгаан дамжуулах агаарын шуамын трассын дагуу 3 газар ажилчдын түр байр баригдсан.<br>**Төвийн бүсийн дамжуулах сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл:**<br>Эрчим хүчний яам, Сангийн яам, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК болон "KfW" банкны төслийн үнэлгээний багийн хооронд хэлэлцэн тохиролцсон асуудлуудыг нэгтгэн Харилцан ойлголцлын санамж бичгийн эцсийн хувилбарыг бэлтгэж гарын үсэг зурахад бэлэн болгосон. Харилцан ойлголцлын санамж бичгийг Эрчим хүчний яам, Сангийн яам, "KfW" банкны хооронд байгуулах ба ЭХЯ, СЯ-ны зүгээс дэмжиж "KfW" банкинд хандаад байна.<br>"KfW" банкнаас гэрээний төслийг Сангийн яаманд ирүүлээд байна. Гурван тал гарын үсэг зурснаар зээлийн гэрээ байгуулагдах бэлтгэл ажил бүрдэнэ. | |
| 6.5 | МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.102 дахь заалт | Аймгийн төвүүдэд байгаль орчинд ээлтэй дулааны станц, шугам сүлжээ барих ажлыг үргэлжлүүлэх | Барилгын ажлын явц, хувиар | 10.0 | | 2017 онд 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ барих төслийн өмнөх хэлэлцээрүүдийг үргэлжлүүлж үр дүнд хүргэх, БНСУ-ын талаас хөнгөлөлттэй зээл олгох асуудлыг түргэвчлүүлэх арга хэмжээг авч байна. Дээрх төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлүүдийг орчуулан, холбогдох материалын хамт БНСУ-ын талд хүргүүлсэн.<br>2017 оны 7 дугаар сард БНСУ-ын "ЭКСИМ" банкны төлөөлөгчид манай улсад ажиллаж, 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ барих төслийн ТЭЗҮ-ийг "ЭКСИМ" банкны хөрөнгөөр 2018 оны 6 дугаар сард багтааж шинэчлэн боловсруулах санамж бичигт МУ-ын Сангийн яам, Эрчим хүчний яам, БНСУ-ын "ЭКСИМ" банкны төлөөлөгчид гарын үсэг зурсан. БНСУ-ын "ЭКСИМ" банк Зөвлөхийн тендер | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулсан. Зөвлөх үйлчилгээний “KDHEC” компани 2017 оны 11 дүгээр сарын 8-11-нд манай улсад томилолтоор ажиллав.<br>10 аймгийн дулааны станцын төслийг эрчимжүүлэх талаар Эрчим хүчний дэд сайд Т.Гантулга, БНСУ-ын ЭКЗИМ банкны гүйцэтгэх захиралтай 2017 оны 12 дугаар сарын 4- өөс 8-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотноо уулзалт хийсэн. Уулзалтаар 2 тал барилга угсралтын ажлыг 2020 онд дуусгахаар харилцан тохиролцсон.<br>Монгол Улсын Ерөнхий сайд 2018 онд БНСУ-д хийсэн ажлын айлчлалын үеэр 10 аймгийн дулааны цахилгаан станцын төслийн ажлыг эрчимжүүлэх асуудлыг хэлэлцсэн. Энэ хүрээнд 2018 оны 1 дүгээр сарын 16-аас 25-ны өдрүүдэд БНСУ-аас 7 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж Эрчим хүчний яамны холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран 10 аймгийн төвд очиж холбогдох судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br>Мөн геологи, геодезийн судалгааны ажлыг 2018 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс 10 аймгийн төвд хийхээр ажиллаж эхлээд байна.<br>Төслийн дунд шатны ТЭЗҮ-ийн тайланг 2018 оны 3 дугаар сарын эхний 10 хоногт багтаан Эрчим хүчний яаманд хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | |
| 6.6 | МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.102, 2.103 дахь заалт | Хот, суурин газрын цахилгаан түгээх сүлжээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх | Барилгын ажлын явц, хувиар | 100.0 | | Эрчим хүчний сайдын 2017 оны төсвийн багцад тусгагдсан Улаанбаатарын гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын, айл өрхийг цахилгаан хангамжаар хангах 41 багц төслийн үнэлгээг хийж дуусгаж, төслийн хүрээнд Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүдийн айл өрхийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдэж, холбогдох барилга угсралтын ажлыг дуусгасан.<br>Дэлхийн банкны Эрчим хүчний төслийн нэмэлт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санхүүжилтийн төсөл дуусгавар болсонтой холбогдуулан уг төслийг дахин "хэрэгжүүлэх, төслийг сунгах тухай асуудлыг Дэлхийн банкинд тавьж, шийдвэрлүүлсэн. Дэлхийн банкнаас олгож буй уг зээлийн хөрөнгийг ашиглах санхүүжилтийн гэрээ, төсөл хэрэгжүүлэх гэрээний төслүүдийг холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлэх танилцуулга, гэрээний төслийн бэлтгэл ажлыг хангаж 2017 оны 5 дугаар сард УИХ-ын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж УИХ-ын 2017 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар соёрхон батлагдсан. АНУ-ын Вашингтон хотноо хуралдсан Дэлхийн банкны удирдах зөвлөлийн 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсад дээрх төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийхээр эцсийн шийдвэр гарсан. Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон Улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулах "Эрчим хүчний төсөл 2"-ын санхүүжилтийн хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Сангийн сайдад олгосны дагуу гэрээ зурагдсан.<br>Төслийн хүрээнд "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ", "Багануур Зүүн Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ", "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-иудын түгээх шугам сүлжээ, дэд станцуудыг өргөтгөн шинэчлэх юм. Энэхүү ажлыг хэрэгжүүлэхээр Дэлхийн банкнаас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | |
| **Зорилт 7. Эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн зам, тээврийн салбарыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ** | | | | | | | |
| 7.1 | МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.114, 2.116 дахь | Дамжин өнгөрөх тээврийн эрх зүйн орчныг сайжруулж, | Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хооронд байгуулах хэлэлцээрийн | 1 | - | "Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Оросын Холбооны Улс, Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг байгуулав. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | заалт | тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх | тоо | | | | |
| | | | Шинээр боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | 1 | - | “Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн төслийн жагсаалт”-ын 12 дугаарт туссан “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Оросын Холбооны Улс, Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулав. Энэхүү хэлэлцээрийг УИХ-аар соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг УИХ-ын холбогдох байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон.<br>Гэвч УИХ-ын Тамгын газрын газраас Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсантай холбогдон Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан баримт бичгийг шинэчлэн ирүүлэх чиглэл өгсөн. Үүний дагуу хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон үзэл баримтлалын төслийг шинэчлэн батлуулахаар ажиллаж байна. | |
| 7.2 | МУТХҮБ-ын 2.1.5. Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.107 дахь заалт | Олон улс, хот хооронд болон орон нутгийн чанартай авто замын төслүүдийг үргэлжлүүлэх | Ашиглалтад орох хатуу хучилттай авто замын урт, км | 457 | 199.83 Гадаад эх үүсвэр, Улсын төсөв | 2017 онд нийт 549.65 км авто замыг ашиглалтад оруулав. Үүнд:<br>1. Элсэнтасархай-Орхоны гүүр чиглэлийн 77 км хатуу хучилттай авто зам;<br>2. Алтай-Дарви чиглэлийн 263 км хатуу хучилттай авто зам;<br>3. Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 142.36 км хатуу хучилттай авто замын 4 дүгээр хэсгийн 15 км, 3 дугаар хэсгийн 10 км, 2 дугаар хэсгийн 23.35 км авто зам;<br>4. Замын-Үүдийн шалган нэвтрүүлэх боомтын 9.6 км хатуу хучилттай авто зам;<br>5. Дархан-Эрдэнэтийн авто замаас Орхон сум хүртэлх 5 км хатуу хучилттай авто зам;<br>6. Дулаанхааны 4 замын уулзвараас-Ерөө-Хүдэр сум хүртэлх 95 км хатуу хучилттай авто замын 2 дугаар хэсгийн 40 км, 3 дугаар хэсгийн 30 км хатуу хучилттай авто зам; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 7. Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум хүртэлх 17.2 км хатуу хучилттай авто зам;<br>8. Халзанбүргэдэй-Солонготын давaa чиглэлийн 100 км хатуу хучилттай авто замын үлдэгдэл 58 км хатуу хучилттай авто зам;<br>9. Орхон аймгийн Эрдэнэт хотын Дэнж багт баригдах 5.08 км хатуу хучилттай авто замын үлдэгдэл болох 1.5 км хатуу хучилттай авто замын барилгын ажиллууд дуусч, комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан. | |
| 7.3 | МУТХҮБ-ын 2.1.5. Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.108 дахь заалт, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 3.2.4 дэх заалт | Бодит салбарын өсөлтийг дэмжих төмөр замын төслүүдийг хэрэгжүүлэх | Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, хувиар | 60.0 | | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 01/1463 тоот албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлсэн. Тус чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг БНХАУ-аас Монгол Улсад хөнгөлөлттэй зээлээр олгох 1 тэрбум ам.доллараас 400 сая ам.доллар олгохоор Засгийн газрын 2017 оны 222 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Засгийн газрын 2017 оны 312 дугаар тогтоолоор дээрх 400 сая ам.доллар олгох тогтоолыг хүчингүй болгосон. Тавантолгой– Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн барилгын ажлыг үргэлжлүүлэн эрчимжүүлэх үүрэг бүхий Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам, Үндэсний хөгжлийн газартай хамтарсан ажлын хэсгийг яаралтай байгуулахаар ажиллаж байна. Барилгын ажлын явц 51.84 хувьтай байна. | 0 |
| | | | Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, хувиар | 10.0-аас доошгүй | | Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын техникийн зураг төслийг боловсруулах ажлын хүрээнд БНХАУ-ын “Башинь төмөр зам” компанийн захиалгаар БНХАУ-ын Зураг төслийг 3 дугаар хүрээлэн ТЭЗҮ-ийг боловсруулсан. Тус хүрээлэнгээс хураангуй ТЭЗҮ-ийг ирүүлсэн бөгөөд ТЭЗҮ-ийн эх хувийг хүлээж авахаар | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллаж байна. Барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг БНХАУ-ын Экзим банкнаас шийдвэрлэх, мөн хувийн хөрөнгө оруулалт концессоор шийдвэрлэхээр ажиллаж байна. |
| | | | Шивээхүрэн-Сэхэ чиглэлийн боомтын төмөр замын барилгын ажлын явц, хувиар | 100.0 | | Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын шугамын чигийг тогтоох Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж 2017 оны 126 дугаар тогтоолоор батлуулсан. “Монголын Алт” ХХК-ийн захиалгаар 2008 онд Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг БНХАУ-ын Зураг төслийн 3 дугаар хүрээлэн боловсруулсныг тус компани “Мөнгөн зөрлөг” ХХК-тай 2017 оны 05 дугаар сард гэрээ байгуулан ТЭЗҮ, зураг төслийг шинэчлүүлсэн. Тус чиглэлийн таригийн өргөний хэмжээг тогтоох тухай УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлал, холбогдох бусад материалыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж 35 дугаар тэмдэглэлээр УИХ-д өргөн барихаар тогтсон.<br>Гэвч Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсантай холбогдон Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан баримт бичгийг шинэчлэн ирүүлэх чиглэл өгсөн. Үүний дагуу УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг шинэчлэн батлуулахаар ажиллаж байна. Тус чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг тухайн бүс нутагт уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч нартай хамтарч шийдвэрлэхээр ажиллаж байна. |
| | | | Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, хувиар | 20.0 | | Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын чигийг Засгийн газрын 2017 оны 10 дугаар тогтоолоор батлуулсан. Концесс эзэмшигч “Нортерн рейлвэйс” ХХК нь хөрөнгө оруулалтын талаар БНХАУ-ын Хөгжлийн банктай яриа хэлэлцээг үргэлжлүүлэн хийж байгаа бөгөөд ТЭЗҮ-ийн эхний шатны тайланг тус банкинд хүргүүлсэн. 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Эрдэнэт хотод төмөр замын барилгын ажлын нээлтийг хийж шав тавих ёслолыг хийсэн. Концесс |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эзэмшигч тус төмөр замын төслийн ТЭЗҮ-ийн төгсгөлийн шатны тайланг боловсруулах ажлыг санхүүжүүлж гүйцэтгэх, цаашид хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг БНХАУ-ын “Чайна гэжуба групп” корпорацитай байгуулж, ТЭЗҮ-ийн төгсгөлийн шатны тайланг эцэслэн боловсруулж байна. Олон улсын банк санхүүгийн байгууллагын шаардлага хангасан ТЭЗҮ-ийг 2018 оны эхний улиралд багтаан боловсруулж дуусган төмөр замын барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. |
| | | | Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилтийн явц, хувиар | 10.0 | | Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн хурлаар асуудлыг хэлэлцүүлж, УИХ-ын 2017 оны 1 дүгээр сарын 26-ны нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж асуудлыг Эдийн засгийн байнгын хороо руу шилжүүлсэн. Анхны хэлэлцүүлгийг 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдөр хийсэн.<br>Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг БНХАУ-ын "Си Ар И Си" компани өөрийн хөрөнгөөр боловсруулж, “Монголын төмөр зам” ТӨХК-д хүлээлгэн өгөхөөр харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. “Си Ар И Си” компани нь ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан бөгөөд Монгол хэл рүү орчуулах ажил хийгдэж байна. УИХ-аар тус чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээ тогтоолгохоор ажиллаж байна. |
| | | | Богдхан төмөр замын төслийн хэрэгжилтийн явц, хувиар | 10.0 | | Богдхан төмөр замын төслийг хэрэгжүүлэхээр Зам, тээврийн хөгжлийн яам болон Азийн хөгжлийн банк хооронд 2014 онд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсны дагуу Азийн хөгжлийн банкнаас үзүүлж буй техник туслалцаагаар “Ай Си Ти Интернэшнл” ХХК тэргүүтэй зөвлөх компани “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Мандал өртөөнөөс Багахангай чиглэлд шинээр барих “Богдхан” төмөр зам төслийн чигийн судалгааг боловсруулсан.<br>Зөвлөх компани “Богдхан” төмөр замын чигийн 5 хувилбарыг 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, улмаар 5 дахь чигийн хувилбарыг дэмжиж, координат болон солбицлыг Засгийн газрын хуралдаанаар батлуулахаар ажиллаж байна. Зөвлөх компани чигийн судалгааны эцсийн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүлээлгэж өгсөн. | |
| 7.4 | МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.117 дахь заалт | Гадаад, дотоод худалдааг хөнгөвчлөх тээвэр, логистикийн төвийн үйлчилгээг бий болгох ажлыг үргэлжлүүлэх | Замын-Үүд сумын холимог тээврийн терминал, логистикийн төв байгуулах ажлын явц, хувиар | 80.0 | 3.12 Улсын төсөв | Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй "Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд улсын төсвийн 16.3 тэрбум төгрөгний санхүүжилтээс нийтдээ 11.9 тэрбум төгрөгний авто зам, гүүрэн байгууламж, хамгаалалтын хашааны барилга угсралтын ажил, эрчим хүчний шугам, 16 Квт-ын дэд станцын барилгын ажил, цэвэр усны шугам, холбоо интернэтийн шилэн кабел, цахилгаан эрчим хүчний шугам, 110 Квт-ын дэд станцын барилгын ажил хийгдэв.<br>2017 онд улсын төсвийн санхүүжилтээр 4.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий логистикийн төвийн 50 тн-ийн даацтай вандан кран нийлүүлэх ажил хийгдэхээр тендер зарлагдан Хятад улсын "Хэнань Дафан Хүнд Машин механизм" компани шалгаран гэрээ байгуулсан ба гэрээний гүйцэтгэл 40 хувьтай байна. Нийт төлөгдөх ёстой санхүүжилтийн 71 хувь хийгдсэн.<br>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэх Логистикийн төвийн барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгчээр "Хятадын төмөр замын 21 дүгээр товчоо" компани, хяналтын зөвлөхөөр БНСУ-ын "Сүсонг инженеринг компани", Монгол Улсын "Геозураглал", "NBCC" ХХК-иудын түншлэл ажиллаж байгаа бөгөөд 32.4 сая ам.долларын санхүүжилт хийгдэв. **Нийт барилгын ажлын гүйцэтгэл 81 хувьтай байна.** | 40 |
| | | | Хөшигийн хөндийд холимог тээврийн | 100.0 | | Хөшигийн хөндийд тээвэр логистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулах хөрөнгийн асуудал шийдвэрлэх ажлын хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | логистикийн төв байгуулах бэлтгэл ажлын явц, хувиар | | | хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтад танилцуулга хүргүүлэв.<br>Үндэсний тээвэр логистикийн сүлжээний зураглал гаргах ажлын даалгавар боловсруулж, 2017 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулав.<br>“Ай Си Ти Интернэшнл” ХХК зөвлөх компани “Богдхан” төмөр замын чигийн 5 хувилбарыг 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр Зам тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, улмаар 5 дахь чигийн хувилбарыг дэмжиж, координат болон солбицлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах шийдвэр гарсан. Энэ ажил хийгдсэний дараа Хөшигийн хөндийн тээврийн логистикийн төв байгуулах байршил, ТЭЗҮ хийх үндэслэл бүрдэнэ. | |
| 7.5 | МУТХҮБ-ын 2.1.5. Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.114, 2.118 дахь заалт, Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын 6.1.4 дэх дэд заалт | Иргэний нисэхийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх | Шинээр ашиглалтад оруулах олон улсын нисэх онгоцны буудлын тоо | 1 | 6.66 Улсын төсөв | Засгийн газрын 2017 оны 11 сарын 29-ны өдрийн 322 тоот тогтоолоор “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн япон талд ноогдох хувийг 51, Монголын талд ноогдох хувийг 49 байхаар тогтоол гарч хуулийн этгээдийг байгуулахаар шийдвэрлэсэн.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 123 дугаар тушаалаар 2017 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс 17-ны хооронд Улсын комисс ажилласан.<br>Хяналт шалгалтын дүнг 2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн Зөвлөх компанийн CS/E-L-G17-2162 тоот, ТХН-ийн 59 тоот, ИНЕГ-ын 01/293 тоот албан бичгийн дагуу Гүйцэтгэгчид “Ажил хүлээн авах гэрчилгээ”-г олгож 32 барилга байгууламжуудыг хүлээж авлаа.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилга, захиргааны барилга, нисэх буудлын үйлчилгээний барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр ЗТХЯ, “Ви Эйч | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | энд Би” ХХК, “Есүй ордон” ХХК-ийн түншлэлтэй 2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 13.970.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ байгуулсан Гүйцэтгэгч компани 2017 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр ажлаа эхлүүлсэн. 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилга 62.4%, захиргааны барилга 82.9%, нисэх буудлын үйлчилгээний барилга 73.3%, нийт барилгын ажил 75%-тай байна.<br><br>Дэлхийн стандартад нийцсэн, орчин үеийн тохилог үйлчилгээ бүхий шинэ нисэх буудлыг барих төслийн ажил 2018 оны 4 дүгээр улиралд дууcна. | |
| | | | Даланзадгад, Ховдын нисэх буудлын барилгын ажлын явц, хувиар | 20.0 | | Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад Ховд аймаг дахь нисэх буудлын аэродромын зураг төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах санхүүжилтийн 26 сая төгрөгийг тусгуулж, зургийн даалгаврыг 2017 оны 9 дүгээр сарын 7-ний өдөр батлуулсан бөгөөд ажлын зургийг боловсруулахаар “ЭЗТ” ХХК-тай гэрээ байгуулахаар ажиллаж байна.<br>Өмнөговь аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх, 4D ангиллын хүчин чадалтай олон улсын нөөц нисэх буудал болгох ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг Улсын төсөв, Концесс, зээлийн хүрээнд шийдвэрлэхээр ажиллаж, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах саналыг Үндэсний хөгжлийн газарт, зураг төсөв боловсруулах зардал, барилгын ажлын санхүүжилтийг “Эксим” банкны зээлээр санхүүжүүлэх саналыг тус тус хүргүүлсэн. Зураг төслийг хийх компаниудын дэлгэрэнгүй болон хураангуй жагсаалт гаргаж, тендерийн саналын урилга, ажлын даалгаврыг тендерт оролцогчдод хүргүүлэв. | |
| | | | Дамжин өнгөрөх | 3.0 | | Иргэний нисэхийн ерөнхий газар хоёр улсын хооронд шинээр агаарын хаалга нээх саналыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нислэгийн тооны өсөлт, хувиар | | | 2016 оны 11 дүгээр сар, 2017 оны 3 болон 5 дугаар саруудад БНХАУ-ын Нислэгийн хөдөлгөөний менежментийн товчооны холбогдох мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалтын үеэр, Монгол Улсын Ерөнхий сайдын БНХАУ-д 2017 оны 5 дугаар сард хийсэн айлчлалын үеэр тус тус тавьсан. Говь-Алтай аймгийн хил орчмоор агаарын хаалга нээх талаарх урьдчилсан судалгааг Хятадын талд хүргүүлэв.<br>Өнгөрөлтийн нислэгийн тоог нэмэгдүүлэх, агаарын навигацийн хураамжийн аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр IATA /international air transport Association/-ын гишүүн агаарын тээвэрлэгчидтэй зөвлөлдөх уулзалтад Монгол Улсын агаарын навигацийн хураамжийг тогтоох шинэчилсэн аргачлалын талаар танилцуулсан. Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд Зам тээврийн хөгжлийн сайдын "Агаарын замуудыг шинэчлэн тогтоох тухай" 2017 оны 9 дүгээр тушаалаар Монгол Улсын агаарын зайн үзүүлэлтэд тулгуурласан навигаци бүхий замуудыг шинэчлэн тогтоож, 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж эхлээд байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар өнгөрөлтийн нислэгийн тоо 110953-т хүрч өнгөрсөн оны мөн үетэй **харьцуулахад 11.8 хувиар өссөн байна.** | |
| 7.6 | ЗГҮАХ-ийн 2.117 дахь заалт | Дотоодын усан замын тээврийг хөгжүүлж, аюулгүй байдлыг хангасан нэгдсэн зогсоол, төв буудал барих бэлтгэл ажлыг хангах | Төв буудал барих бэлтгэл ажлын явц, хувиар | 100.0 | - | Усан замын төв буудал барих газрыг Хөвсгөл аймгийн Засаг даргын 2017 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 1/542 тоот, Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2017 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн А/16 тоот захирамж, Хатгал тосгоны захирагчийн 2017 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 1/71 тоот захирамжаар тус тус шийдвэрлүүлж, газар зүйн солбицол, координатыг тогтоолгоод байна.<br>Усан замын төв буудал барих ТЭЗҮ, зураг төслийн санхүүжилтийг гадаад эх үүсвэрээс шийдвэрлүүлэх зорилгоор АХБ, Дэлхийн банк, | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Жайка зэрэг 11 байгууллагад хандсан хүсэлтийг хүргүүлсэн. Үндэсний хөгжлийн газраас концессын сонгон шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна. | |
| **ГУРАВ. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО** | | | | | | | |
| **Зорилт 8. Хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот, суурин газрыг хөгжүүлж, хүн амын ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ** | | | | | | | |
| 8.1 | МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 6, ЗГҮАХ-ийн 2.77, 3.4.3 дахь заалт | Хүн амын орон сууцны хэрэгцээг хангах хүрээнд эрх зүйн орчныг сайжруулж, төсөл хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэх | Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | 2 | Монгол банк-192.0 Улсын төсөв 110.0 Нийт-302.0 тэрбум төгрөг | **Орон сууцны тухай хуульд** нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөл боловсруулах ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 98 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Үзэл баримтлалын төслийг эцэслэн боловсруулсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага, судалгаа, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн тайланг боловсруулахаар ажиллаж байна.<br>**Засгийн газрын ипотекийн хөтөлбөрийн журам:** 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд ипотекийн зээлд 110 тэрбум төгрөгийг тусгасан. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.76 дахь зорилтод "Ипотекийн зээлийн нөхцөлийг хөнгөвчилж, зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлэх бодлого баримталж, зээлийн цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлнэ" гэж заасны дагуу хүртээмжийг нэмэгдүүлэх хувилбарыг боловсруулсан бөгөөд Засгийн газрын ипотекийн хөтөлбөрийн журмын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудын саналыг авч нэгтгэн Засгийн газарт хүргүүлэхээр ажиллаж байна. | 70 |
| | | | "Түрээсийн орон сууц" хөтөлбөрт шинээр хамрагдах | 1000 | | Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 28 дугаар тушаалаар батлагдсан "Иргэдийг түрээсийн орон сууцад хамруулах журам", ТОСК ТӨААТҮГ-ын ерөнхий захирлын 2016 оны А/21 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн түрээсийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өрхийн тоо | | | орон сууцад иргэдийг бүртгэх, сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцад хамруулах ажлыг зохион байгуулах журам"-ын дагуу Улаанбаатар хотод 4150, орон нутагт 2222 иргэнд шаардлагатай мэдээллийг өгч, материалыг хүлээн авсан. 2017 онд нийт 3305 өрх хамрагдсанаас Улаанбаатар хотод шаардлага хангасан нийт 2376 иргэн, орон нутагт шаардлага хангасан 929 иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулаад байна. Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 25 дугаар тушаалаар Түрээсийн орон сууцны 1 мкв талбайн хэмжээг нийслэлд 6000 төгрөг, орон нутаг 4500 төгрөг байхаар тогтоосон. Мөн Барилга, хот байгуулалтын сайдын 26 дугаар тушаалаар зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журмыг батлуулсанаар өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуу гэр бүл, төрийн албан хаагч гэх мэт ангилалд тус тусын шалгуур үзүүлэлтийг тогтоосон. | |
| 8.2 | МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 5, 6, ЗГҮАХ-ийн 2.81, 2.85 дахь заалт | Газрын нэгдсэн бодлогын хүрээнд газар ашиглах, эзэмших, өмчлөх эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, геодезийн нэгдсэн тогтолцоог өргөжүүлэх | Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | 9 | | Төрөөс газрын харилцаа, геодези, зураг зүйн талаар баримтлах бодлого, Төрөөс орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар баримтлах бодлогын төсөл болон Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрын кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах журмын төслийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор батлуулсан. | 70 |
| | | | Геодезийн | 30-аас | | Монгол Улсын өндрийн тулгуур сүлжээний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэгдсэн тогтолцоог өргөжүүлэх ажлын явц, хувиар | доошгүй | | давтан хэмжилт буюу нивелирийн I ангийн (багц-1) нивелирдлэг хийх ажлыг бүрэн дуусгаж, ажлын гүйцэтгэлийн актыг үйлдэж, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. | |
| 8.3 | МУТХҮБ-ын 2.1.5. Зорилт 5, 6, ЗГҮАХ-ийн 2.78, 2.82 дахь заалт | Хот, суурин газрыг хөгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулж, барилга байгууламжийн норм нормативыг олон улсын жишигт нийцүүлэх | Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | 5 | - | - Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн хуулиар зохицуулах харилцааг Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах нь зүйтэй гэж Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж буй хуулийн зөвлөх багаас үзсэний дагуу Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн тухай хуулийн төсөл боловсруулах асуудлыг ажлын хэсгийн хуралд хэлэлцүүлэхээр хойшлуулаад байгаа болно.<br>- “Хот байгуулалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, “Хот, суурин, ногоон байгууламжийн тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулсан.<br>- “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдаж батлагдах дүрэм, журам”-ын төсөл, “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох журам”-ын төсөл, “Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах зорилгоор өмчлөгч, эзэмшигч газраар хувь нийлүүлэх журам”-ын төслийг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.<br>- Япон улсын Жайка төслийн багтай хамтарч “Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийх тухай болон газар хөдлөлтөнд тэсвэргүй барилга байгууламжийг хүчитгэх тухай” барилгын норм ба дүрэм /Дэд бүтэц, “Инженерийн шугам сүлжээниий газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ өгөх аргачлал”, “Өрөгт бүтээцэн барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал”, “Угсармал | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал", "Цутгамал төмөр бетон барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал"/-ийн техникийн даалгаврыг батлуулсан.<br>- "Газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм, дүрэм" /БНбД 22-04-16/ -ийг боловсруулж Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулсан.<br>- "Газар хөдлөлтийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар" /БД31-103-00/-д нэмэлт өөрчлөлт ,"Газар хөдлөлтийн дараа барилгын аюулгүй байдлыг үнэлэх арга зүйн заавар, "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм" /БНбД 22-01-01*/2006/-ийг шинэчлэх дүрмүүд тус тус Шинжлэх ухаан техник технологийн зөвлөлийн хурлаар дэмжигдэж, батлуулахаар ажиллаж байна. | |
| 8.4 | ЗГҮАХ-ийн 2.87 дахь заалт | Барилга, байгууламжийн өртгийг бууруулах хүрээнд барилгын материалын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих | Шинээр боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | 1 | - | Барилга, барилгын материалын салбарт баримтлах бодлого боловсруулах ажлын хэсгийг 2017 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 2 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг тус бодлогын баримт бичгийг 6 үндсэн чиглэлийн дагуу боловсруулахаар шийдвэрлэж, 6 чиглэл тус бүрд Техникийн даалгавар боловсруулан бодлогын баримт бичгийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан. | 70 |
| | | | Шинээр барих үйлдвэрийн тоо | 3-аас доошгүй | | "Монгол базальт" ХХК, "Вестерн Холд" ХХК, "Эрэл" ХХК, "Бэрэн" ХХК-уудын төслийг Хөгжлийн банкинд 2017 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн 01/81 тоотоор дэмжин уламжилсан. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотноо 9 дүгээр сард зохион байгуулагдсан Монгол-Хятадын 2 дахь удаагийн Экспогийн үеэр "Бэрэн" ХХК-ийн гангийн үйлдвэрийн төслийн танилцуулгыг "Томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтын хэлэлцүүлэг"-т танилцуулсан. "Баярс констракшн" ХХК-ийн перлитэн дулаалгын хийцийн үйлдвэрийн төсөл, "Дархан хөвөн" ХК- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ийн “Техник эдийн засгийн тооцоо”-г Хөгжлийн банкинд 2017 оны 01/577 тоот албан бичгээр дэмжин уламжилсан. “Эрэл” ХХК-ийн угсармал барилгын үйлдвэрийн шинэчлэлийн ажил бүрэн дуусч, туршилт тохируулга хийгдсэн тул 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр үйлдвэрийн нээлтээ хийлээ. | |
| 8.5 | МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 5, 6, ЗГҮАХ-ийн 2.91 дэх заалт | Улаанбаатар хот болон аймгуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэх | Шинээр барих цэвэрлэх байгууламжийн тоо | 6 | 16.9 Гадаад эх үүсвэр Хөгжлийн банк | **Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн төсөл:**<br>- Өвөрхангай аймгийн төвийн цэвэрлэх байгууламж, бусад туслах vйлчилгээний А1.4 дугаартай ажлын тендерийн үнэлгээг дуусгаж, үнэлгээний тайланг АХБ-нд зөвшөөрөл авахаар хүргүүлсэн.<br>- “Өмнөговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах vйлчилгээ” А1.3 багцын сонгон шалгаруулалтаар АХБ-аас ирүүлсэн зөвшөөрөлд үндэслэн “НАБ” ХХК-ийн түншлэл гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулан, гэрээг Барилга, хот байгуулалтын сайд, Өмнөговь аймгийн Засаг дарга нарт хүлээлгэж өгөөд байна.<br>- Дорноговь аймгийн төв Сайншандад баригдах бохир ус цэвэрлэх байгууламжийн өөрчлөлтийн ажлын зураг, Ар, өвөр шандыг холбох ариутгах татуургын шугамын ажлын зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчээр зураг төслийн “Хайдро Дизайн” ХХК шалгарч, гэрээ байгуулан ажлаа гүйцэтгэж байна.<br>- Архангай аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламж, бусад туслах vйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн Үнэлгээний хороо байгуулсан.<br>**Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл:** Бохир ус цэвэрлэх байгууламжийн элс баригч, анхдагч тунгаагуур, лаг өтгөрүүлэгч ба лаг усгүйжүүлэх | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууламжууд, бохир ус хүлээн авах станц, агаар өгөх компрессорын станц, лагийн насосны станц, ус хэмжигчийн байр, хяналтын удирдлагын байрны барилга угсралт, технологийн шугам, гадна дулаан, ус хангамж, ариутгах татуургын шугамын угсралт, ТП-ын барилга болон тоног төхөөрөмжийн угсралт зэрэг ажлууд хийгдэж дууссан. Уг байгууламжийг ашиглалтад оруулах захиалагчийн техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт /2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн дугаар № 01 дүгнэлт/ гарсан. Үүрэг даалгаврын биелэлтээр 2018 оны 6 дугаар сард багтаан туршилт тохируулгын ажлыг хийж, комисс ажиллуулж байнгын ашиглалтад хүлээлгэн өгнө.<br>**Улаанбаатар хотын 20000 м$^3$/хон хүчин чадалтай бохир усны цэвэрлэх байгууламжийн** барилга угсралтын ажил болон тоног төхөөрөмж суурилуулалтын ажил 100 хувь дууссан. | |
| 8.6 | МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 5, 6, ЗГҮАХ-ийн 2.103 дахь заалт | Сумын төвийн дэд бүтцийг сайжруулах ажлыг үргэлжлүүлэх | Хамрагдах сумын тоо | 16 | 6.1 Хөгжлийн банк | Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай Өмнөговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Төв, Увс, Хөвсгөл, Ховд, Хэнтий зэрэг 16 аймагт төслүүд хэрэгжиж байгаа бөгөөд 2017 онд Дундговь аймгийн Өлзийт, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ажлыг байнгын ашиглалтад оруулсан.<br>Дорнод аймгийн Баян-Уул, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Хэнтий аймгийн Биндэр, Ховд аймгийн Зэрэг, Говь-Алтай аймгийн Дэлгэр зэрэг 5 сумын ажил 60-90 хувьтай байна. | 70 |
| | | | Дэд бүтцийг сайжруулах ажлын явц, хувиар | 30.0 | | 2017 онд төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймгийн Өлгий сумын төвийн 0.4 кВ-н Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийн 206.4 сая төгрөгийн өртөг бүхий ажил, Баян-Өлгий аймгийн Өлгий сумын төвийн 0.4-10 кВ-н Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын шинэчлэлт 653.1 сая төгрөг /БАГЦ-1,2,4/, мөн аймгийн Сагсай сумын Битүү, Согог багийн 10 кВ Цахилгаан дамжуулах шугам, дэд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | станц 221.6 сая төгрөгийн ажлууд хийгдэж улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авсан.<br>Дорноговь аймгийн Мандах, Хатанбулаг сумдын хэрэглэгч, айл өрхүүдийг байнгын цахилгаан эрчим хүчинд холбосон. | |
| **Зорилт 9. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг сайжруулж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална** | | | | | | | |
| 9.1 | МУТХҮБ-ын 2.1.2. Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.2.8, 4.4.1 дэх дэд заалт | Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг сайжруулах | Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | 5 | - | 1. УИХ-ын 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн **нэгдсэн чуулганы хуралдаанаар “Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ыг хэлэлцэн** баталсан. Хог хаягдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Зар сурталчилгааны тухай, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн баталсан.<br>2. Байгаль хамгаалах санг, Байгаль орчин, уур амьсгалын сан болгон өөрчлөхөөр “Засгийн Газрын тусгай сангийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, УИХ-ын 2017 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар “Засгийн Газрын тусгай сангийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах болон уг хуультай дагалдан 4 хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг хэлэлцэж, нэгдсэн чуулганаар батлуулсан.<br>3. Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор 2017 онд захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдийг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дангаараа болон бусад Засгийн газрын гишүүнтэй | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтран батлан хэрэгжүүлэв. Үүнд:<br>- “Ундны болон ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээг батлах тухай” Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А-333/А-245 дугаартай хамтарсан тушаалаар батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны улсын нэгдсэн санд 2017 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 3784 дугаарт бүртгэгдсэн.<br>- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 8-р сарын 17-ний өдрийн А-226/А-182 тоот хамтарсан тушаалаар “Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал”, “Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний загвар”-ыг батлуулав.<br>- Засгийн газрын 2017 оны 9-р сарын 27-ны өдрийн 290 дүгээр тогтоолоор “Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ыг баталсан.<br>- Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 168 дугаар тогтоолоор “Эрчим хүч хэмнэх, дулааны үйлдвэрлэл, бохир ус цэвэрлэх, усны хэмнэлттэй техник, тоног төхөөрөмжийн жагсаалт”-ыг баталсан.<br><br>Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан Аюултай хог хаягдлын жагсаалт”, “аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”, Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журам, Аюултай хог хаягдлын дагалдах бичгийн, аюултай хог хаягдлын үүсгэгч болон тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх; аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх маягтын төслүүдийг боловсруулж, БОАЖС-ын 2017 оны А/349, А368 дугаар тушаалаар тус тус батлуулав.<br>"Усны чанарыг бохирдлын индексээр үнэлэх заавар"-ыг БОАЖ-ын сайдын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/332 дугаар тушаалаар батлав.<br>Байгаль орчны менежментийн тогтолцоо. Хэрэгжүүлэх ерөнхий аргачлал ISO 14004, Байгаль орчны менежмент, Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ-Арга зүйн заавар ISO 14031, Байгаль орчны менежемент, Байгаль орчны технологийн нотолгоо ISO 14034, Байгаль орчны менежмент, Амьдралын мөчлөгийн үнэлгээ, Тавигдах шаардлага ба хэрэглэх заавар ISO 14044 зэрэг 4 стандартыг батлуулав.<br>Ус, рашааны нөөц ашигласны төлбөр ногдох зүйлд мал аж ахуй, газар тариалангийн усалгаанд ашигласан усыг оруулж тооцох, зохистой хэрэглээний эрх зүйн орчинг бий болгох зорилгоор Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулга, Үзэл баримтлалын төслийг боловсруулсан. | |
| 9.2 | ЗГҮАХ-ийн 4.4.1 дэх дэд заалт | Казиногийн тухай хуулийн төслийг боловсруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Казиногийн тухай хуулийн төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн.<br>УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос Казиногийн тухай хуулийн төслийг УИХ-ын Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг, тус ажлын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсгийг ХЗБХ-ны даргын 2017 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулсан.<br>2017 оны 10-р сарын 23-ны өдөр ХЗБХ-ны ажлын хэсэг, дэд ажлын хэсгийн хуралдаан зохион байгуулагдсан бөгөөд тус хуралдаанд Засгийн газарт өргөн барьсан хуулийн төслийн танилцуулах илтгэлийг тавьсан.<br>Ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналууд, бусад улс орнуудад зохицуулж буй туршлагууд, шаардлагатай тодруулгуудыг тусгасан гарын авлагын эхийг боловсруулж, Засгийн газрын болон ажлын хэсгийн гишүүдэд Казиногийн тухай хуулийн төслийн мэдээллийг хүргүүлэв. Казиногийн тухай хуулийн төслийн дараагийн хэлэлцүүлгийг УИХ-ын 2018 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна. | |
| 9.3 | МУТХҮБ-ын 2.3.1. Зорилт 1, 2.3.3 дахь дэд заалт, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.2.1 дэх заалт | Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, хамгаалалтын арга хэмжээг сайжруулах | Тусгай хамгаалалтад авах газар нутгийн хэмжээ мян.га | 600-гаас доошгүй | 0.048 Улсын төсөв | Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын хилийн цэсийг 743 мян. га талбайгаар, Ноён уулын байгалийн нөөц газрыг 11 мян. га, Ноён уулын дурсгалт газрыг 650 мян. га талбайгаар хилийн заагийг тогтоолоо. Нийт 3 аймгийн 3 сумын **754 мян.га** буюу нийт газар нутгийн 0.44 хувийг тус тус улсын тусгай хамгаалалтад авч, нийт газар нутгийн хэмжээг 17.8 хувьд хүргэв. 2017 оны байдлаар олон улсын байгууллагын төсөл, хувийн хэвшлийн санхүүжилтээр тоног төхөөрөмж, машин техник, ажлын хувцас, багаж хэрэгсэл, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, хамгаалалтын арга хэмжээг сайжруулсан. | 100 |
| 9.4 | МУТХҮБ-ын 2.3.1, Зорилт 1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 4.2.3, 4.2.4 дэх заалт | Гидрогеологийн хайгуулын судалгаа хийж, бороо, цасны усыг хуримтлуулах | Хайгуул, судалгааны ажлын тоо | 1 | 0.85 Улсын төсөв | “Хот суурин газрын ус хангамж, гидрогеологийн зураглалын судалгаа” /Дундговь аймгийн Сайхан-Овоо сум/-ын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны хайгуул, судалгааны ажлыг явуулах сонгон шалгаруулалт явагдаж, “Ус амьдрал” ХХК шалгарч, 2017 оны 6 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөв, цөөрөм байгуулах, булаг шандны эхийг хашиж хамгаалах ажлыг үргэлжлүүлэх | | | | дугаар сарын 9-ний өдөр гэрээ байгуулсан. Сумын төвөөс 1.2-1.5 км зайд хүн амын унд ахуйн стандартад нийцсэн усны ордыг нээн илрүүлж, хээрийн ажилд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж, олборлолтод бэлтгэсэн цооногуудыг орон нутагт хүлээлгэн өгсөн. 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Усны нөөцийн зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн, усны нөөцийг 19.29 л/с буюу 1666.6 $м^3$/хоногоор баталсан бөгөөд усны нөөц бүхий 2 хувь тайланг улсын усны мэдээллийн санд бүртгэн авч, ажил гүйцэтгэх гэрээг дүгнэж акт үйлдэн баталгаажуулж, Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын төвийн хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэн, хайгуул судлагааны ажлыг бүрэн гүйцэтгэж, газрын доорх усны нөөцийг тогтоож, ажлын гүйцэтгэл 100 хувь биелэгдсэн. | |
| | | | Шинээр байгуулах хөв, цөөрмийн тоо | 3 | | Дорнод аймгийн Халх гол сумын төвд, Төв аймгийн Зуунмод сум, Увс аймгийн Бөхмөрөн суманд нийт **3 хөв цөөрөм** барьж 2017 оны 9-11 дүгээр сард хүлээн авч ашиглалтад оруулсан.<br>Увс аймгийн Улаангом сумын Тэрэм хадны суваг, Тариалан сумын Галданбошигтын хөвийн сувгийг тус тус сэргээн засварласан.<br>Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд хөв байгуулах зураг төслийн ажил хийгдсэн. | |
| | | | Хамгаалалт хийх булаг шандны тоо | 100-гаас доошгүй | | Усны нөөцийг хамгаалах, булаг шандны эхийг хамгаалах, нөхөн сэргээх ажлын хүрээнд орон нутгийн төсвөөр 21 аймаг, нийслэлийн хэмжээнд нийт **132** булаг, шандыг хашиж хамгаалах ажлыг зохион байгуулж, 2017 оны 2 дугаар хагас жилд багтаан хүлээн авч, гэрээг дүгнэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | |
| 9.5 | МУТХҮБ-ын 2.3.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 4.1.6 дахь дэд заалт | Түүхий нүүрсний хэрэглээг бууруулах, сэргээгдэх эрчим хүч, | Цахилгааны урамшуулал болон хөнгөлөлттэй үнээр сайжруулсан | 40,000-аас доошгүй | 4.5 Улсын төсөв | Цахилгааны 2 тарифт тоолууртай нийслэлийн болон төвийн бүсийн системд холбогдсон гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгааныг 100 хувь (сарын хөнгөлөлтийн хязгаар 700 кВтц), бусад аймаг орон нутгийн гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгааныг 50 хувь халаалтын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | цэвэр түлшний хэрэглээг нэмэгдүүлэх замаар агаарын чанарыг сайжруулах | түлш авах өрхийн тоо | | | улирал буюу 11-3 саруудад хөнгөлөлт үйлчилсэн бөгөөд 2017 онд гэр хорооллын **114512** хэрэглэгчдэд 3,3 тэрбум төгрөгийн цахилгааны хөнгөлөлт үзүүлсэн байна. Хөнгөлөлтийн хугацаанд шөнийн хамгийн их ачаалал 405МВт-д хүрсэн нь өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад **шөнийн ачаалал 70 МВт-аар буюу 17 хувь өссөн.** Шөнийн тарифыг тэглэснээр (гэр хорооллын нэг айл өрхийн цахилгаан халаагуурын чадлыг дунджаар 4кВт-аар тооцвол) нийт **хөнгөлөлт үзүүлсэн айл өрхийн 17176 буюу 15.2 хувь нь цахилгаан халаагуур ашигласан байна.**<br>Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2016 оны 02 дугаар тогтоолд "Зорилтот бүлэгт сайжруулсан зуух, боловсруулсан түлшийг олгох"-оор шийдвэрлэж, арга хэмжээг зохион байгуулсан. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын зорилтот бүлгийн 1600 өрхийг боловсруулсан түлшээр, 390 өрхийг цахилгаан халаагуураар хангах ажлыг зохион байгуулж, тус арга хэмжээнд улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгөөр нийт 1.3 тэрбум төгрөг зарцуулсан байна. | |
| 9.6 | МУТХҮБ-ын 2.3.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.2.7 дахь дэд заалт | Ойг хамгаалах, ойжуулах, нөхөн сэргээх ажлыг чанаржуулж, хүлэмжийн хийн шингээх чадварыг нэмэгдүүлэх | Ойжуулах, ойн зурвас байгуулах талбайн хэмжээ | 1000-аас доошгүй | 4.5 Улсын төсөв | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойн нөхөн сэргээлтийн ажлыг нийт **2074.2 га-д** гүйцэтгэсэн. Улсын төсвийн хөрөнгөөр 891 га, Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1183.2 га, нөхөрлөлүүд 400 га, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр 1197.1 га ойжуулалт хийж нийт 3672.1 га-д ойг нөхөн сэргээсэн байна.<br>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/12 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх ойт хээрийн бүсэд экологийн ач холбогдол бүхий шилмүүст модоор **280 га** талбайг ойжуулах ажлыг Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-т эрхийг шилжүүлэн гүйцэтгэсэн. БОАЖЯамны захиалгаар Хөвсгөл-Алаг-эрдэнэ- Их уул-40 га, Завхан,Тосонцэнгэл, Их-Уул, Тэлмэн сум-70 га, Сэлэнгэ Мандал сум- | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 10 га, Өвөрхангай Бат-Өлзий-20 га, УБ хотын ногоон бүс-30 га, нийт **170 га-д** ойжуулалт ажлыг хийж, гүйцэтгэлээ. | |
| | | | Хөнөөлт шавьж, өвчний тархалтыг хязгаарлах ажил гүйцэтгэх талбайн хэмжээ, мян.га | 200-гаас доошгүй | | Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг 2017 онд улсын төсвийн хөрөнгөөр Архангай, Завхан, Өвөрхангай, Увс, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дархан-Уул аймгийн зарим сумд, Нийслэлийн ногоон бүс, Горхи-Тэрэлжийн БЦГ-ын ойн санд 171,8 мянган га талбайд, орон нутгийн төсвийн хөрөнгөөр Хөвсгөл, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Булган, Орхон, Архангай аймгийн зарим сумд, Нийслэлийн ногоон бүсийн ойн санд 57,7 мянган га талбайд, нийт **229,5 мянган га** талбайд тэмцлийн ажлыг зохион байгуулсан болно. | |
| | | | Ойн цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ, мян.га | 34 | | БОАЖСайдын 2016 оны А/111 дүгээр тушаалаар аймаг, нийслэлийн ойн сангаас ойн арчилгаа, цэвэрлэгээгээр 2017 онд бэлтгэх модны хэмжээг батлан хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажилласан.<br>2017 онд урьдчилсан байдлаар ойн цэвэрлэгээг **34 мянган га** талбайд хийж 587,6 мянган шоометр мод ашиглан ойн төлөв байдлыг сайжруулсан байна.<br>Ойг хамгаалах, ойжуулах, нөхөн сэргээх ажлыг чанаржуулж, хүлэмжийн хийн шингээх чадварыг нэмэгдүүлэх зорилт арга хэмжээнд нийтдээ 4.5 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан байна. | |
| 9.7 | МУТХҮБ-ын 2.1.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.4.1 дэх дэд заалт | Аялал жуулчлалын төв замын дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор төвийн ТЭЗҮ-ийг боловсруулах | ТЭЗҮ-ийг боловсруулах цогцолбор төвийн тоо | 4 | 0.09 Улсын төсөв | Авто зам дагуу үйлчилгээний цогцолборын А ангиллын ТЭЗҮ-ийг боловсруулсан бөгөөд В, С ангиллын цогцолборын ТЭЗҮ, зураг төслийг холбогдох стандартад нийцүүлэн боловсруулан батлуулсан.<br>2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр зарлагдсан сонгон шалгаруулалтад Маруга ХХК шалгарч авто зам дагуу үйлчилгээний цогцолборын А, В, С ангиллын ТЭЗҮ-ийг бүрэн боловсруулсан. Аялал жуулчлалын төв замын дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор төвийн ТЭЗҮ-ийг боловсруулах арга хэмжээнд нийтдээ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 90.0 сая төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан байна. | |
| 9.8 | МУТХҮБ-ын 2.3.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 4.1.6 дахь дэд заалт | Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Улсын Их хурлын 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн **нэгдсэн хуралдаанаар "Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга"-ыг хэлэлцэн,** батлагдсан. Хог хаягдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Зар сурталчилгааны тухай, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлагдав. Хуулийг дагаж гарах дараах журам, аргачлалуудыг батлуулав. Үүнд:<br>1. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийг боловсруулж, батлуулав.<br>2. Аюултай хог хаягдлын жагсаалт", "аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам"-ыг боловсруулж, батлуулав.<br>3. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журмыг боловсруулж, батлуулав.<br>4. Аюултай хог хаягдлын дагалдах бичгийн, аюултай хог хаягдлын үүсгэгч болон тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх; аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх маягтын төслүүдийг боловсруулж, батлуулав.<br>5. "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөлбөр"-ийг боловсруулан Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан.<br>6. "Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журмыг Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолоор батлуулав.<br><br>- "Агаарын тухай хууль", "Засгийн газрын тусгай сангийн тухай хууль", "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан "Агаарын бохирдлын эсрэг санг байгуулахаар хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн барихаар шийдвэрлэв.<br>- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн барихаар шийдвэрлэв.<br>- Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн "Хөрс хамгаалах өдөртэй болох тухай" 149 дүгээр тушаал батлагдан, Хөрс хамгаалах үндэсний үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулав. | |
| 9.9 | МУТХҮБ-ын 2.3, ЗГҮАХ-ийн 4.3.1 дэх дэд заалт | Байгаль хамгаалах, байгалийн нөөц баялгийг арвижуулах, нөхөн сэргээх ажилд иргэд, олон нийтийн оролцоо, үйл ажиллагааг дэмжиж ажиллах | Шинээр бий болох ажлын байрны тоо | 200 | - | Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор "Байгаль хамгаалах нөхөрлөлийн Үндэсний II чуулганыг зохион байгуулж, 21 аймгийн ЗДТГ, 176 сумын Засаг дарга, 1000 гаруй нөхөрлөлүүдийн төлөөлөл оролцсон. Чуулганаар "Экологид ээлтэй бүтээгдэхүүн-2017" Үзэсгэлэн-худалдааг зохион байгуулж, "Ойн унанги болон хатсан мод, мөчир гишүү, навч боргоцой ашиглан гар урлалын бүтээгдэхүүн хийх" уралдааныг дүгнэж, 19 нөхөрлөлийг 11 сая төгрөг, эд бүхий зүйлээр урамшуулав. Үзэсгэлэнд 21 аймгийн 60-аад нөхөрлөл оролцсон. "Байгаль хамгаалах нөхөрлөлийн Үндэсний II чуулганаар | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | анхдугаар чуулганаас хойш хэрэгжүүлсэн ажлынхаа үр дүнг хэлэлцэж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх замаар нөхөрлөлийг чадавхижуулж, тэдгээрийн байгаль хамгаалах болон эдийн засгийн үйл ажиллагааг тогтворжуулах зорилт тавин ажиллаж байна.<br>НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын төслийн санхүүжилтээр Хэнтий, Сэлэнгэ, Дархан-Уул, Булган, Хөвсгөл зэрэг 5 аймгийн 102 нөхөрлөл, аж ахуйн нэгжийг чадавхижуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Ойн тогтвортой менежмент хэрэгжүүлж нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих нь" төслийн хүрээнд Сэлэнгэ сумын Түнхэл сумын 7 нөхөрлөлийг чадавхижуулж, шинээр **80 гаруй** ажлын байрыг бий болгон ажиллаж байна. | |
| **Зорилт 10. Гамшгаас хамгаалах мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, гамшгийн үеийн бэлэн байдлын түвшинг дээшлүүлнэ** | | | | | | | |
| 10.1 | МУТХҮБ-ын 2.3.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.3.3 дахь дэд заалт, Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр /цаашид "ГХЧБҮХ" гэх/-ийн 3.5.4 дэх зорилт | Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, аврах, гал унтраах ангийн чадавхыг сайжруулах | Ашиглалтад орох аврах, гал унтраах ангийн тоо | 6 | 13.4<br>Улсын төсөв | Улсын төсвөөс 2017 онд тус арга хэмжээнд 13.4 тэрбум төгрөг зарцуулж, 4 гал унтраах, аврах ангийн барилгыг Улсын комисс хүлээн авсан. Үүнд:<br>1. Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь гал түймэр унтраах, аврах ангийн барилга угралтын ажилд 3.3 тэрбум төгрөг зарцуулсан.<br>2. Дархан-Уул аймгийн Дархан суман дахь гал түймэр унтраах, аврах ангийн барилга угсралтын ажилд 3.3 тэрбум төгрөг зарцуулсан.<br>3. Хэнтий аймгийн Бэрх тосгон дахь гал түймэр унтраах, аврах ангийн барилга угралтын ажилд 2.1 тэрбум төгрөг зарцуулсан.<br>4. Говь-Алтай аймагт баригдаж байгаа гал түймэр унтраах, аврах ангийн барилга угсралтын ажилд 3.3 тэрбум төгрөг зарцуулсан.<br>Харин нийслэлийн Багахангай дүүргийн Онцгой | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах ангийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 75.0 хувь, 2017 онд батлагдсан төсвөөс 383.6 сая төгрөгийн санхүүжилт авсан нь нийт гэрээний үнийн дүнгийн 68.6 хувь болсон.<br>Төв аймгийн Зуунмод суман дахь гал түймэр унтраах, аврах ангийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 95.0 хувь, 2017 онд батлагдсан төсвөөс 1,042.0 сая төгрөгийн санхүүжилт авсан нь нийт гэрээний үнийн дүнгийн 98.1 хувь болсон. | |
| 10.2 | МУТХҮБ-ын 2.3.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.3.3 дахь заалт, ГХЧБҮХ-ийн 3.5.4 дэх зорилт | Онцгой байдлын албаны аврах, гал унтраах техник, тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх | Хэрэгжүүлэх төслийн тоо | 3-аас доошгүй | 3.9 Гадаад эх үүсвэр | Онцгой байдлын ерөнхий газрын эрхлэх асуудлын хүрээнд 2017 онд дараах 3 төсөл хэрэгжиж эхлээд байна. Үүнд:<br>**1.** Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага "Жайка"-ын тусламжтайгаар Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2002 онд нийлүүлэгдсэн 17, 2013 онд нийлүүлэгдсэн 22 гал түймэр унтраах автомашины 251 нэр төрлийн 941.0 сая төгрөгийн өртөг бүхий сэлбэг, хэрэгслийг 2017 оны 4 дүгээр улирал авч Онцгой байдлын байдлын ерөнхий газрын анги салбаруудад хуваарилсан.<br>**2.** Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-тай хамтран "Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийг 3.5 сая ам.долларын санхүүжилтийн хүрээнд 2017-2019 онд хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн төлөвлөгөөний дагуу 2017 онд Барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг үнэлэх барилгын дүрмийн төслийг боловсруулж Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. Түүнчлэн, "Авто зам, гүүр, инженер хангамжийн сүлжээнд газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлэх аргачлал" барилгын дүрмийн төслийг боловсруулж холбогдох байгууллагуудаас санал авч, Барилга, хот байгуулалтын яамны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж дэмжсэн. Цаашид төслийн төлөвлөгөөний дагуу 5 барилгыг сонгож бодитоор үнэлгээ хийх, хүчитгэлийн загварын зураг төслийг боловсруулах, үнэлгээний аргачлалыг танилцуулах сургалт зохион байгуулах бэлтгэлийг ханган ажиллаж байна.<br>**3.** Азийн хөгжлийн банктай хамтран "Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийг 3.0 сая ам.долларын санхүүжилтийн хүрээнд 2017-2019 онд хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн төлөвлөлтийн матрицын дагуу 2017 онд төсөл хэрэгжих 4 аймгийн 12 суманд Онцгой байдлын ерөнхий газар, орон нутгийн онцгой байдлын хэлтэстэй хамтарсан 12 сургалтыг сумын иргэд, орон нутгийн мэргэжлийн анги, сумын захиргааны байгууллагын албан хаагч нарыг хамруулан *(давхардсан тоогоор 2,148 хүн хамрагдсан)* зохион байгуулах, 12 сумын 853 иргэдтэй уулзалт хийж төслийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг танилцуулж, мэдээллээр ханган багийн хөршийн 126 бүлэг болгох, багийн гамшгийн эрсдлийн үнэлгээ хийх талаар олон улсын мэргэжилтэний сургалтыг 27 багт зохион байгуулж, 67 бүлгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу төслийн машин, тавилга, мэдээллийн технологийн болон төслийн зохицуулагчийн мотоциклийг хууль, журмын худалдан авах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>**4.** Швейцарийн хөгжлийн агентлагийн хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Аврах тусгай ангид "Хот дахь эрэн хайх аврах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зориулалтын сургалтын төв" байгуулах 265,400 Швейцарь Франкийн өртөг бүхий төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд "Хот дахь эрэн хайх аврах зориулалтын сургалтын төв"-ийн байгууламжийн эх загвар зураг, шаардагдах тоног төхөөрөмжийн жагсаалтыг төслөөр боловсруулан сургалтын хөтөлбөр, шаардагдах хүний нөөцийн судалгааны ажил хийгдэж байна. | |
| **ДӨРӨВ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НИЙГМИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **Зорилт 11. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын эрх зүйн орчныг сайжруулж, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ая тухтай сурч, боловсрох орчныг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлнэ** | | | | | | | |
| 11.1 | МУТХҮБ-ын 2.2.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.2.2, 3.2.5 дахь дэд заалт | "Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувийг нэмэгдүүлэх | Хамран сургалтын бохир жин, хувиар | 79.2 | 27.8<br>Улсын төсөв | Улсын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилд 256'720 хүүхэд буюу 10 хүүхэд тутмын 8 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулснаар хамран сургалтын **бохир жин 82.7 хувьд** хүрсэн. | 70 |
| | | | Ашиглалтад оруулах цэцэрлэгийн тоо | 12 | 8.9<br>Гадаад эх үүсвэр | Улсын төсөв, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр болон концессын гэрээгээр нийт 2525 хүүхдийн хүчин чадал бүхий 24 цэцэрлэг ашиглалтад орсон бол гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр нийт 675 хүүхдийн хүчин чадал бүхий 8 цэцэрлэгийг ашиглалтад оруулсан. Үүнд Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2 цэцэрлэг , АНУ-ын буцалтгүй тусламжаар 2 цэцэрлэг, БНСУ-ын төрийн бус байгууллагын тусламжаар 4 цэцэрлэгийг тус тус ашиглалтад оруулсан. | |
| | | | Шинээр байгуулах байгууллагын цэцэрлэгийн тоо | 10 | | **2017 онд нийт 11 байгууллагын дэргэд цэцэрлэг болон салбар бүлэг шинээр байгуулан** 1525 хүүхдийг хамруулсан. Үүнд<br>- Монголын үндэсний олон нийтийн радио телевиз 180 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг<br>- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 80 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг<br>- Хууль, зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Тагнуулын ерөнхий газар 540 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг<br>- ТЭЦ-3 180 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Хуримын ордон 25 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг<br>- Хан-Уул дүүргийн ЗД-ын ТГ-ын дэргэд 180 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг<br>- МУБИС 90 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг<br>- Санхүү, эдийн засгийн их сургууль 70 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг<br>- Цагдаагийн академи 180 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг | |
| 11.2 | МУТХҮБ-ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.2.3, 3.2.6 дахь дэд заалт | Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүртээмж, орчин нөхцөлийг сайжруулан хүүхдийн ая тухтай сурч, хүмүүжих орчныг бүрдүүлэх | Шинээр ашиглалтад оруулах сургуулийн тоо | 23 | | 2017 онд нийт 12440 хүүхдийн хүчин чадалтай 22 сургуулийг шинээр ашиглалтад оруулсан. Мөн нийт 500 хүүхдийн хүчин чадалтай 4 сургуулийн дотуур байр, 640 хүүхдийн хүчин чадалтай 2 спорт заал усан бассейны барилга ашиглалтад орсон. | 100 |
| | | | Орчин нөхцөлийг сайжруулах дотуур байрны тоо | 10 | 1.5<br>Улсын төсөв | 2017 онд нийт 1339 хүүхдийн хүчин чадалтай 20 дотуур байрны орчин нөхцлийг, 9 ерөнхий боловсролын сургуулийн ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэн сайжрууллаа.<br>Мөн авто замын ойролцоо оршдог нийслэлийн ерөнхий боловсролын 16 сургуулийн бүсийн орчинг сайжруулсан. | |
| 11.3 | МУТХҮБ-ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.2.8, 3.2.12, 3.2.14 дэх дэд заалт | Ерөнхий боловсролын сургалтын шинэчлэлийн хүрээнд монгол хэлний хичээлийн хөтөлбөрт цогц үнэлгээ хийх, амьдрах ухааны хичээлийн хөтөлбөрийг шинээр боловсруулах | Үнэлгээ хийх ажлын явц, хувиар | 100.0 | - | Бага, дунд, ахлах ангийн сургалтын цөм хөтөлбөр, зарим сурах бичигт дараах шалгуураар хөндлөнгийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргалаа. Үүнд:<br>- Үндэсний уламжлал, ёс заншил, соёлыг сурагчдад өвлүүлэн хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага хангаж буй эсэх;<br>- Хэл найруулга, зөв бичих дүрмийн шаардлагыг хангаж буй эсэх;<br>- Түүхийн үнэн бодит байдлыг хангаж буй эсэх.<br>Үнэлгээний дүгнэлтээр:<br>- Үнэлгээнд хамрагдсан сурах бичиг, сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний уламжлал, ёс заншил, соёлыг өвлүүлэн хөгжүүлэх хэрэгцээ хийгээд хэл найруулга, зөв бичих дүрэм талаас эргэн харж, сайжруулах шаардлагатай;<br>- Олон жил сургалтад хэрэглэж туршигдсан | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сурах бичгүүдтэй залгамж холбоогүй, уламжлал, шинэчлэлийг хоршин дэвжүүлж боловсруулаагүй;<br>Сурах бичиг, цөм хөтөлбөрийг цаашид үе үеийн төлөөлөл бүхий багт захиалга өгч, судалгааны үндсэн дээр уламжлал шинэчлэлийг хослуулан хөгжүүлэх байдлаар бүтээх шаардлагатай гэж үзсэн байна. | |
| | | | Хөтөлбөр боловсруулах ажлын явц, хувиар | 100.0 | - | Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын түвшинд хэрэгжүүлэх "Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөр"-ийн төслийг мэргэжлийн байгууллагын оролцоотой боловсруулж, нээлттэй хэлэлцүүлгийг хийсэн.<br>Мөн "Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын талаар баримтлах бодлого"-ын төсөлд амьдрах ухааны сургалтын агуулга, хөтөлбөр, зохион байгуулалт ямар байх талаар тусгасан. | |
| 11.4 | МУТХҮБ-ын 2.2.3, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 3.2.20 дахь дэд заалт | "Боловсролын зээлийн сан"-гийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, хүртээмжийг нэмэгдүүлэх | Зээлд хамрагдах оюутны тоо | 20000 | 48<br>Улсын төсөв | 2017 онд **нийт 22913 оюутанд 48 тэрбум төгрөгийн** зээл тусламж олгоод байна. Үүнд, амжилттай суралцаж байгаа магдлан итгэмжлэгдсэн 133 сургуулийн 5830 суралцагчдад 12.7 тэрбум төгрөг, багш мэргэжлээр элсэгчдийн 751-ээс дээш оноотой 2155 суралцагчдад 4.8 тэрбум төгрөг, Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу Монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа 122 гадаадын суралцагчдад 667.5 сая төгрөг, Монгол Улсаас гадаадад суралцаж байгаа 142 суралцагчдад 1.8 тэрбум төгрөг, орон нутагт хийх багшлах дадлагын тэтгэлэгт 704 суралцагчдад 327.1 сая төгрөг, Дэлхийн шилдэг 100 их сургуульд 239 суралцагчдад 14.6 тэрбум төгрөг, өндөр хөгжилтэй орны 226 магистр, доктort суралцагчдад 6.4 тэрбум төгрөг, төрийн албан хаагчдийн гэр бүлээс суралцаж байгаа 161 суралцагчдад 276 сая төгрөг, оюутны хөгжлийн зээлд 4.8 тэрбум төгрөг зарцуулсан байна. | 100 |
| 11.5 | МУТХҮБ-ын 2.2.3, | Боловсрол, соёл, шинжлэх | Шинээр болон шинэчлэн | 6 | - | 1. "Биеийн тамир, спортын хууль" /шинэчилсэн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Зорилт 4, 5, ЗГҮАХ-ийн 3.2.21, 3.2.34, 3.2.52, 3.2.29, 3.2.42 дахь дэд заалт | ухаан, спортын салбарын эрх зүйн орчныг сайжруулах | боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | | | найруулга/-ийг Улсын Их Хурлын 2017 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан.<br>2. Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын шинэчилсэн найруулгыг Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 295 дугаар тогтоолоор баталсан.<br>3. "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, оролцоог дэмжих Үндэсний хөтөлбөр"-ийн төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран боловсруулж, Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 321 дүгээр тогтоолоор баталсан.<br>4. Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 23 дугаар тогтоолоор "Спортыг дэмжих сан"-гийн хөрөнгийг зарцуулах журмыг баталсан.<br>5. Соёлын тухай хуулийг шинэчлэн батлуулах, Музейн тухай, Киноны тухай зэрэг хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг БСШУС-ын сайдын тушаалаар тус тус байгуулан ажиллаж байна. | |
| 11.6 | МУТХҮБ-ын 2.2.3, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 3.2.25 дахь дэд заалт | Дэлхийн шилдэг сургуулиудад бакалавр, магистр, докторын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах оюутныг ил тод, нээлттэй сонгон шалгаруулах тогтолцоог бүрдүүлэх | Хөтөлбөрт хамрагдах оюутны тоо | 225 | 14.7<br>Улсын төсөв | 2017 онд Дэлхийн шилдэг 100 их сургуульд 239 оюутан, Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд 1000 орчим оюутан тус тус суралцаж байна.<br>Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу тухайн орны Элчин сайдын яамдтай хамтран сонгон шалгаруулалтыг ил тод, шуурхай, боловсронгуй болгох зорилгоор доорхи арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд:<br>- Бүртгэлийг 100 хувь онлайн хувилбарт шилжүүлсэн.<br>- Бүртгэлийн давхардлыг арилгах зорилгоор БНХАУ, ОХУ, Унгар, Солонгос, Вьетнам, Польш, Турк зэрэг 16 орны элчин сайдын яамтай хамтран, хяналт тавьж ажилласан.<br>- Сонгон шалгаруулалтын мэдээллийг яам, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | их, дээд сургууль, коллежийн болон олон нийтийн цахим хуудсаар нээлттэй зарлаж, олон улсын боловсролын яармаг, нээлттэй хаалганы өдөрлөгүүдэд сурталчилсан. | |
| 11.7 | МУТХҮБ-ын 2.2.3, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 3.2.26 дахь дэд заалт | Оюутан суралцах хугацаандаа цагийн ажил, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх чиглэлээр “Орлоготой оюутан” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | БСШУСЯ-аас “Орлоготой оюутан” хөтөлбөрийг боловсруулан Засгийн газрын 2016 оны 178 дугаар тогтоолоор батлуулсан. 2017 онд тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, оюутнуудын санал санаачлагыг дэмжих чиглэлээр дараах ажлуудыг хийлээ. Үүнд:<br>- БСШУС-ын сайдын тушаалаар хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах орон тооны бус үндэсний зөвлөлийг байгуулсан.<br>- Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд “Оюутны бүтээлч санаачлагыг дэмжих тэтгэлэг” олгоход 418700 мянган төгрөгийг төсөвлөснөөс 117 оюутны багт 351000 мянган төгрөгийг зарцуулсан.<br>- Дээд боловсролын сургалтын байгууллага ба үйлдвэрлэлийн түншлэлийг хөгжүүлэх, оюутандаа ажил мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх талаар жишиг зааврыг нэгтгэн гарын авлага хэвлүүлж түгээсэн.<br>- Туршилт судалгаанд хамрагдсан 6 сургууль болон бусад 50 гаруй их, дээд сургуулийн холбогдох мэргэжилтнүүдэд 2 удаагийн нэгдсэн сургалт хийсэн.<br>- Нийт их дээд сургуулиудын оюутныг цагийн болон үндсэн ажлын байранд зуучилсан судалгааг хийсэн.<br>2017 оны жилийн эцсийн байдлаар 6320 оюутныг цагийн болон үндсэн ажлын байранд зуучилсан. | 70 |
| 11.8 | ЗГҮАХ-ийн 5.6.10 дахь дэд заалт | “Монгол судлал”-ыг бодлогоор дэмжиж, тогтвортой хөгжих | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 0.472 Улсын төсөв | Ерөнхий сайдын дэргэдэх Монгол судлалын үндэсний зөвлөлийн 2017 оны 01 тогтоолоор тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөөг шаардагдах зардлын хамт баталж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Мөн “Монгол судлалыг хөгжүүлэх үндэсний | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нөхцөлийг бүрдүүлэх | | | | хөтөлбөр"-ийн төслийг боловсруулан яамдаас санал аван нэгтгэж байна.<br>Монгол судлалыг хилийн чанадад хөгжүүлэх, сурталчлах бодлогын хүрээнд дараах шинэ төсөл, хөтөлбөрүүдийг 2017 оноос эхлүүлээд байна. Үүнд:<br>- Олон улсын Монгол судлаачдыг дэмжих хүрээлэнтэй хамтран монгол ахуй, соёл, өв уламжлалтай танилцах зуны сургалтыг гадаадын монгол судлалын чиглэлээр суралцаж буй оюутнуудын дунд 2017 оны 8 дугаар сард Монгол Улсад зохион байгуулсан.<br>- Монгол судлаачдын Европын бүсийн анхны чуулганыг Санкт Петербург хотноо 2017 оны 4 дүгээр сард, Азийн бүсийн чуулганыг Бээжин хотноо 2017 оны 11 дүгээр сард зохион байгуулсан.<br>- Хилийн чанад дахь монгол хүүхдүүдийн эх хэл, соёлоо сэргээх, түүхээрээ бахархах сэтгэлийг нь хөхиүлэн дэмжих зорилготой "Эх түүхийн олимпиад"-ыг 2017 оны 12 дугаар сард анх удаа зохион байгуулсан. | |
| 11.9 | ЗГҮАХ-ийн 3.2.46 дахь дэд заалт | Үндэсний бахархал, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн түүхэн сэдэвт бүтээл туурвихад дэмжлэг үзүүлэх | Түүхэн сэдэвт уран бүтээл туурвих ажлын явц, хувиар | 100.0 | 0.79<br>Улсын төсөв | 2017 онд дараах түүхэн сэдэвт уран бүтээл туурвихад дэмжлэг үзүүлэн Соёл урлагийг дэмжих сангаас санхүүжүүлсэн. Үүнд:<br>- "Монгол орон ба Монголчууд III" түүхэн гэрэл зургийн цомог<br>- "Эцэг өвгөдийн гэрээслэл" түүхэн драмын жүжиг<br>- "Манлайбаатар" дуулалт жүжиг<br>- "Эрдэнэ тээлийн уянга" дуурь зэрэг болно. | 70 |
| 11.10 | ЗГҮАХ-ийн 3.2.55 дахь дэд заалт | "Спортыг дэмжих сан" байгуулж, сангийн үйл ажиллагааны эрх зүйн | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 1.0<br>Улсын төсөв | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулинд 2016 оны 11 сарын 10-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулж "Спортыг дэмжих сан" байгуулан Засгийн газрын 2017 оны 23 дугаар тогтоолоор "Спортыг дэмжих сан"-гийн хөрөнгийг зарцуулах журмыг баталсан. 2017 онд 10 төсөлд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | орчныг бүрдүүлэх | | | | 599 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:<br>- Нийтийн биеийн тамир, хүн амын идэвхитэй хөдөлгөөнөөр хичээллэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээний хүрээнд 5 төсөл;<br>- Өндөр зэрэглэлийн тамирчин, дасгалжуулагчийг шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэх, хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээний хүрээнд 3 төсөл;<br>- Үндэсний спортыг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх хүрээнд 1 төсөл;<br>- Үндэсний хэмжээний тэмцээн, наадмын сэргээшийн эсрэг хяналтыг хэрэгжүүлэх, сэргээшийн эсрэг үйл ажиллагааны сургалт, сурталчилгааг зохион байгуулах хүрээнд 1 төслийг тус тус санхүүжүүлсэн.<br>Мөн Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай 372 дугаар тушаалаар олимп, тив, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд амжилттай оролцсон тамирчдын мөнгөн шагналыг тус сангаас зарцуулсан. | |
| **Зорилт 12. Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагааны чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ** | | | | | | | |
| 12.1 | МУТХҮБ-ын 2.2.3, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 3.2.19 дэх дэд заалт | Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, нэгж судлаач, эрдэмтэнд ногдох хувьсах зардлыг бууруулахгүй байх | Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлын улсын төсөвт эзлэх хэмжээ, хувиар | 0.2 | 10.3<br>Улсын төсөв | 2017 оны улсын төсөвт эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардалд 10.3 тэрбум төгрөг батлагдсан. Энэ нь улсын төсвийн 0.15 хувийг эзэлж байна. Эрдэм шинжилгээний ажлын зардал өмнөх оныхоос 1.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нэгж судлаачид ноогдох эрдэм шинжилгээний зардал 4.66 сая төг болсон. Энэ нь өмнөх оны дунджаас 500 мянган төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна. | 100 |
| 12.2 | МУТХҮБ-ын | Гадаадад | Үйл | 100.0 | - | Гадаадад мастер, доктор болон докторын дараах | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.2.3, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 5.6.13 дахь дэд заалт | эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлж байгаа монгол эрдэмтдийг дотоодын судалгааны ажилд оролцуулах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх | ажиллагааны хэрэгжилт, хувиар | | | судалгаа хийж байгаа нийт 50 гаруй байгууллагын 600 гаруй албан хаагч, багш, судлаачдын талаарх мэдээллийг нэгтгэн боловсруулав. БСШУСЯ, Залуу эрдэмтдийн холбоо хамтран зохион байгуулдаг "Хүрэлтогоот" эрдэм шинжилгээний хуралд гадаадад докторын зэрэг хамгаалж буй залуу судлаачид оролцон илтгэл тавьж, туршлага солилцов. Мөн гадаад дахь монгол судлаачид ТББ-тай хамтран эрдэм шинжилгээний хурлыг англи хэл дээр зохион байгуулав. БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн яамтай хамтран "Эрдэмтэн солилцооны хөтөлбөр"-ийг эхлүүлснээр монгол судлаачид Хятад улсын судалгааны байгууллагад судалгааны ажлаа үргэлжлүүлэх боломжтой болсон. | |
| 12.3 | МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 7, ЗГҮАХ-ийн 3.2.38 дахь дэд заалт | Ази, Европыг холбосон өндөр хурдны сүлжээгээр дамжих мэдээллийн урсгалыг нэмэгдүүлж, олон улсын интернетийн шинэ дамжлага гарцтай болох | Дамжлага гарцын тоо | 4 | - | Өнөөдрийн байдлаар Алтанбулаг, Замын-Үүд чиглэлийн 2 дамжлага гарцаар "Жемнет" ХХК олон улсын транзит мэдээллийн урсгалыг дамжуулж байна. Харин "Мобинетворкс" ХХК, "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХХК-иуд 2017 онд технологийн өргөтгөл хийж гарцын тоог 2-оор нэмэгдүүлэх техникийн боломжийг бүрдүүлсэн хэдий ч эдгээр компаниудын олон улсын мэдээллийн транзит урсгал дамжуулах үйлчилгээ эрхлэх А зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 7 дугаар тогтоолоор цуцалсан нь уг арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн. Харилцаа холбооны зохицуулах хорооноос дээрхи 2 компанийн зөвшөөрлийг 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор сэргээснээр Алтанбулаг, Замын-Үүд чиглэлийн гарцыг байгуулж олон улсын интернет холболттой төвүүдээр дамжуулан мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна.<br>Олон улсын интернет холболттой төвүүдээр дамжуулж интернет гарцыг нэмэгдүүлэх тул | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрш орнууд болон тухайн улсад ижил төстэй үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай бөгөөд 2018 оны 1 дүгээр улиралд багтаан дамжлага гарцын тоог 2-оор нэмэгдүүлэхээр төлөвлөсөн.<br>Уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд олон улсын түвшний бодлогын дэмжлэг шаардлагатай тул Гадаад харилцааны яамтай хамтран олон улсын түвшний дараах баримт бичгүүдэд тусгуулсан. Үүнд:<br>- НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засгийн комисс (UNESCAP)-ын "Ази-Номхон далайн орнуудын мэдээлэл, холбооны их багтаамжийн хурдны зам"-ын мастер план;<br>- Монгол-ОХУ-БНХАУ-ын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр; Хөгжлийн зам хөтөлбөр. | |
| | | | Мэдээллийн урсгалын нэмэгдэх хэмжээ | 2 дахин | - | Нийт хүн амын 70 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбогдох боломжийг бүрдүүлж, газар нутгийн байршлаас үл хамааран ижил үнэ, тарифыг мөрдөж, Ази, Европыг холбосон мэдээлэл дамжуулах өндөр хурдны сүлжээгээр дамжих мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх бөгөөд Монгол Улсаар дамжин өнгөрч буй транзит урсгалын хэмжээ нь "нууц"-ын зэрэглэлд хамрагддаг тул нарийн тоо хэлэх боломжгүй бөгөөд 2017 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн байна.<br>Тус газраас ХХЗХ болон үйлчилгээ эрхлэгч оператор компаниудтай харилцан санал солилцож, эхний ээлжинд хөрш орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллахаар болж БНХАУ-ын Хонконг-д зохион байгуулагдсан "Capacity Asia-2017" арга хэмжээнд оролцож хөрш орнуудын транзитын үйлчилгээ эрхлэгч томоохон компаниуд болох Росс телеком, Мегафон, Чайна телеком, Чайна юником, Чайна мобайл компаниудтай уулзаж төрөөс баримталж буй бодлогоо танилцуулж цаашдын хамтын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааны талаар санал солилцсон. | |
| 12.4 | МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 7, ЗГҮАХ-ийн 3.2.39 дэх дэд заалт | Монгол контентыг хөгжүүлж, интернетийн дотоод урсгалын хэмжээг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд экспортлох боломжтой программ хангамж, техник хангамжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх | Интернетийн дотоод урсгалын нэмэгдэх хэмжээ, хувиар | 20.0 | | "Монгол контентыг хөгжүүлж, интернетийн дотоод урсгалын хэмжээг нэмэгдүүлэх" арга хэмжээний хүрээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/30 дугаар тушаалаар "Тоон контентийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Энэхүү хөтөлбөр батлагдсанаар үндэсний контент үйлдвэрлэгчдэд шаардлагатай байгаа тоног төхөөрөмж, студи зэргийг байгуулах асуудалд дэмжлэг болох ач холбогдолтой юм.<br>- Нийслэлийн захирагчийн ажлын албатай үндэсний болон төрийн контентийг түгээх арга замыг тодорхойлох зорилгоор хамтран ажиллаж байна. Улаанбаатар хотын төв зам дагуу хамгийн их хүн цуглардаг 5 байршилд "иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээлэл болон үндэсний хэв шинжийг агуулсан, сурталчилсан, хүүхдийн хүмүүжил, ёс суртахуунд эерэг нөлөөлөл үзүүлэхээр бүтээгдсэн контентуудыг тасралтгүйгээр түгээх" зориулалттай дэлгэц суурилуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>- Гадаад зах зээлд экспортлох боломжтой програм хангамж, техник хангамжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:<br>- УИХ-ын 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2016 оны 208 дугаар тогтоолоор баталсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө"-нд монгол програм | 40 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хангамжийг экспортлох арга хэмжээг 1.38 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч 2017 онд санхүүжилтийн хүндрэлээс шалтгаалан хэрэгжээгүй.<br>- Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоо (МОСА)-той хамтран Ази номхон далайн орнуудын тооцоолон бодох үйлдвэрлэлийн (ASOCIO) олон улсын байгууллагын гишүүн орнуудын төлөөлөлтэй үндэсний програм хангамж үйлдвэрлэгчдийг холбож, цаашдын хамтын ажиллагааг нь дэмжих зорилгоор “Олон талт худалдааны уулзалт” олон улсын арга хэмжээг 2017 оны 6 сарын 14-17-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээний үеэр экспортод гаргах бүтээгдэхүүн, шийдлийн талаар салбарын аж ахуйн нэгжүүдтэй санал солилцох, зөвлөлдөх уулзалт зохион байгуулж дотоодын бүтээгдэхүүн, шийдлийг худалдан авах зах зээлийг тодорхойлох, түншлэл тогтоох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд манай улсаас "Монгол Контент" ХХК, "айТүүлс", "Грэйпсити", "Абле", "Од инновэйшн", "АйТи Зон", "Интерактив" зэрэг компаниуд оролцсон бөгөөд гадаад улс орноос оролцож буй төлөөлөгчдөд өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар танилцуулж, тэдэнтэй хамтран ажиллах, харилцаа холбоо тогтоосон.<br>- Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоотой хамтран төрийн албан хаагчдын цахим засаг, мэдээллийн технологийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, цахим засгийн шийдлүүдийг танилцуулах зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн 54 байгууллагыг хамруулсан GOVTECH-2017 чуулганыг 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан.<br>- Мэдээллийн технологийн үндэсний парк болон Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоо (МОСА)-той програм | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хангамж, техник хангамжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор хамтран ажиллаж байна. | |
| 12.5 | МУТХҮБ-ын 2.2.3, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 5.6.13 дахь дэд заалт | Гарааны компанийг байгуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрөөс дэмжлэг үзүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 0.74 Улсын төсөв | Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах 13 компанийн хүсэлтийг хүлээн авч, гарааны компанийн төслийн саналд үнэлгээ, дүгнэлт өгч Инновацийн тухай хуулийн 14, 15 дугаар зүйлд тавигдах шаардлагыг хангасан инновацийн төслийг нэгдсэн мэдээллийн санд оруулан бүртгэж, 11 гарааны компани байгуулахыг зөвшөөрөв.<br>2017 онд 32 инновацийн төсөлд 811 сая төгрөгийн санхүүжилтийг олгов. Үүнээс Гарааны ургамлын эмч, Гарааны цахирам, Гарааны монбиотик ХХК гэсэн 3 гарааны компанид 74.5 сая төгрөг олгосон. Мөн "Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого"-ын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Уг төрөөс баримтлах бодлогын төсөлд өндөр технологийн үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийсэн, дэвшилтэт технологийг нутагшуулсан аж ахуйн нэгжүүд буюу гарааны компаниудыг татвар зээлийн бодлогоор тусгайлан дэмжих зорилтуудыг тусгасан. | 70 |
| 12.6 | МУТХҮБ-ын 2.2.3, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 3.2.35 дахь дэд заалт | Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн бүтэц, шинжилгээ, судалгаа, үйл ажиллагааны чиглэл, орон тоог оновчтой болгож, менежментийг сайжруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогыг Засгийн газрын 2017 оны 9 сарын 27-ны 295 дугаар тогтоолоор баталсан. Энэхүү бодлогод салбарын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, менежментийг сайжруулах чиглэлээр тодорхой зорилт арга хэмжээнүүд тусгагдсан.<br>"Төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах, үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний 194 дүгээр тогтоолыг хэрэгжилтийг хангах зорилгоор БСШУС-ын сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг "Шинжлэх ухааны парк-Биотехнологи"-ийн үл хөдлөх болон холбогдох бусад эд хөрөнгийг Шинжлэх ухаан, технологийн их сургуульд шилжүүлэх ажлыг | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулсан.<br>Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хорооны 2017 оны “Шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагааг дэмжих зарим арга хэмжээний тухай” 17 дугаар тогтоол батлагдаж, Монгол Улсын Засгийн газрын “Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилтийг хянаж, шинжлэх ухааны байгууллагуудын бүтэц тогтолцоо, харьяалал өөрчлөгдсөнтэй холбоотой үүсч буй тулгамдсан асуудлыг судлан шийдвэрлэх талаар үүрэг даалгавар өгсөн.<br>Энэ дагуу тус яамнаас эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, цаашид бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг хэрхэн авч үзэх талаар хамт олны санал хүсэлтийг хүлээн авч судалж байна.<br>Мөн эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгаа боловсруулалтын ажлыг дэмжих, чадавхийг бэхжүүлэх, үндсэн чиг үүргийнх дагуу тогтвортой хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Эрдэм шинжилгээний байгууллагуудад суурь санхүүжилт олгох журмын төслийг боловсруулж байна. | |
| **Зорилт 13. Хүн амд чанартай, тэгш, хүртээмжтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүргэж, эх орондоо оношлуулах, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлнэ** | | | | | | | |
| 13.1 | МУТХҮБ-ын 2.2.2, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.1.7 дахь дэд заалт | Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн | 100,000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин, промиль | 27.9 | Нийт 713.2 сая төгрөг,<br><br>үүнээс<br><br>94.8 сая төгрөг (Дэлхийн эрүүл мэндийн байгууллага) | 2017 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд эхийн эндэгдлийн 20 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 26.9 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй **харьцуулахад 21.7 буюу 18 тохиолдлоор буурсан байна.**<br>Эхийн эндэгдлийг бууруулах талаар дараах арга хэмжээ авч ажиллажээ. Үүнд:<br>- 21 аймаг, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ), Амгалан амаржих газартай “Эх барихын тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудал” шуурхай цахим хурлыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | эндэгдлийг бууруулах | | | 28.8 сая төгрөг (НҮБ-ын Хүн амын сан)<br><br>23.6 сая төгрөг (Франц Улсын “СантеСюд” ТББ) | 21 хоног тутам зохион байгуулж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.<br>- 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 9 эмч, мэргэжилтэн Хэнтий, Өмнөговь, Завхан, Хөвсгөл, Баян-Өлгий зэрэг 5 аймагт ажиллаж, ажлын байрны сургалт зохион байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>- ЭХЭМҮТ-тэй хамтран эхийн эндэгдэл өндөртэй аймагт эмч солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж, 2017 онд Хөвсгөл, Сүхбаатар, Баянхонгор, Баян-Өлгий зэрэг 4 аймгийн 4 эмчийг ЭХЭМҮТ-д ажиллуулсан нь мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажлын байранд суралцах боломжийг бүрдүүлжээ.<br>- Франц Улсын “СантеСюд” ТББ-тай хамтран “Эх баригчийн мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх төсөл” хэрэгжүүлж, эх баригчдын ажлын байрны тодорхойлолтыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/216 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. Мөн эх баригч-сургагч багшийг үндэсний хэмжээнд бэлтгэх сургалтыг зохион байгулж, нийт 40 эх баригчийг сургагч багшаар бэлдсэн.<br>- Эх барихын бус шалтгаант өвчлөл, эндэгдлийг бууруулах зорилгоор 21 аймаг, УБ хотын дүүргийн дотрын эмч нарт “Эх барихын эрхтэн тогтолцооны хавсарсан эмгэг” сэдвээр сургалт зохион байгуулсан. | |
| | | | 1000 амьд төрөлтөд нялхсын эндэгдлийн түвшин, промиль | 14.0 | 91.0 сая төгрөг (Дэлхийн эрүүл мэндийн | 2017 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нялхсын эндэгдлийн 1,009 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 13.6 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.2 (306 тохиолдол)-оор буурсан байна.<br>- Нялхсын эндэгдлийг бууруулах, нярайн эрт үеийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан болсон амьсгалын дистресс хамшинжийн эмчилгээнд сурфактант ашиглах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2017 оны 03 сарын 15-ны А/102 дугаар тушаалаар “Нярайн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллага) 457.0 сая төгрөг (Улсын төсөв) 11.0 сая төгрөг | сурфактант эмчилгээний заавар", 2017 оны 07 сарын 28-ны А/297 дугаар тушаалаар "Нярайн амьсгал хямралын хамшинжийн оношилгоо, эмчилгээний заавар, Амьсгалын замд үргэлжилсэн эерэг даралт үүсгэн амьсгалуулах эмчилгээний заавар, Төрөх үед болон төрсний дараа нярайд үзүүлэх тусламжийн заавар, Нярайн сэхээн амьдруулалтын заавар, Дутуу, бага жинтэй нярайг амаар хооллох заавар"-ыг баталсан.<br>- Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн сургалтыг зохион байгуулж, нийт 120 эх барих, эмэгтэйчүүд, нярайн эмч, эх баригч, нярайн сувилагч хамрагдсан.<br>- Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 215 дугаар тогтоолоор амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчлөлийн дэгдэлтийг таслан зогсоох, иргэдийг өвчлөлөөс сэргийлэх зорилгоор томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээрээ 3-5 хоног асарсан ажил, хөдөлмөр эрхэлж байгаа эх, эцэг, асран хамгаалагчид 2017 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс 3 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд цалинтай чөлөө олгох асуудлыг шийдвэрлэсэн нь өвчний дэгдэлт, хүндрэлийг бууруулахад ач холбогдолтой арга хэмжээ болсон.<br>- Дутуу нярайн эндэгдлийг бууруулах зорилгоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөхтэй хамтран "Имж эх асаргаа" сэдэвт сургалтыг зохион байгуулж, үндэсний 12 сургагч багшийг бэлтгэсэн. |
| | | | 1000 амьд төрөлтөд 5 хүртэлх насны | 16.7 | (Дэлхийн эрүүл мэндийн | Улсын хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 1,244 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хүүхдийн эндэгдлийн түвшин, промиль | | байгууллага)<br><br>7.0 сая төгрөг (НҮБ-ын Хүүхдийн сан) | 16.7 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 384 тохиолдлоор буюу 4.1-ээр буурсан үзүүлэлттэй байна.<br>Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийг УИХ-ын чуулганы 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар батлуулсан. Хуулийн зорилт нь хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжих, эрүүл, аюулгүй хүнсээр хангах, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.<br>Нийгмийн даатгалын үндэсний үндэсний зөвлөлийн 2017 оны 01 сарын 07 өдрийн 01 дүгээр тогтоолоор 5 хүртэлх насны хүүхдийн 10 нэрийн 30 төрлийн эмийг эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь хөнгөлөлттэй үнээр олгох шийдвэрийн дагуу нийслэлд 318, орон нутагт 490, улсын хэмжээнд 808 даатгалын гэрээтэй хөнгөлттэй жороор олгох эмийн сангуудаар 29,440 хүүхдэд 457.0 сая төгрөгийн эмийг олгосон.<br>- Хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор өвчлөл, эндэгдэл өндөртэй Дорнод, Өвөрхангай, Хөвсгөл, Дундговь, Баян-Өлгий зэрэг 5 аймгийн 6 эмч ЭХЭМҮТ-д ажлын байрны сургалтад хамрагдсан. Мөн ЭХЭМҮТ-ийн хүүхдийн эмнэлгийн эмч нар 2017 онд Өвөрхангай, Хөвсгөл, Говьсүмбэр, Архангай, Баян-Өлгий, Орхон, Булган, Сүхбаатар, Сэлэнгэ, Дорнод, Дархан-Уул, Дундговь зэрэг 12 аймагт хүүхдийн өвчний цогц менежмент, хүүхэд, нярайд тохиолдох эмгэгүүд, нярайн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ, хүүхдэд зонхилон тохиолдох зүрхний эмгэгүүдийн талаар ажлын байран дээрх сургалтуудыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хханган ажилласан.<br>- Хүүхэд яагаад эндэв? 2016" цогц судалгааг олон улсын аргачлалын дагуу ДЭМБ-ын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санхүүжилтээр хийж, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, зөвлөмж өгсөн.<br>- "Хүүхдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудал" сэдэвт хэлэлцүүлгийг 2017 оны 11 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулж, аймаг, нийслэлийн хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан. | |
| 13.2 | МУТХҮБ-ын 2.2.2, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 3.1.3 дахь дэд заалт | Элэгний вирус хепатитийн халдварыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хүн амыг хамруулж, эмчилгээг эрчимжүүлэх | Оношлогоонд хамрагдах иргэдийн эзлэх хувь | 100.0 | 17.2 Улсын төсөв | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 05 сарын 12 өдрийн А/94/А/193 дугаар тушаалаар "Даатгуулагчийг элэгний В, С вирусын илрүүлэг, шинжилгээнд хамруулах, даатгалын сангаас зардлын төлбөрийг санхүүжүүлэх журам", Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/200 болон 2017 оны А/373 дугаар тушаалаар "Элэгний В, С вирусын илрүүлэг, шинжилгээнд хамруулах иргэдийн тоо, шаардагдах төсвийг аймаг, дүүргээр" баталсан. Мөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 11 дүгээр тогтоолоор "Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах журам"-ыг тус тус батлуулж элэгний вируст хепатитийн халдварыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хүн амыг хамруулах эрх зүйн орчинг бүрдүүлсэн.<br>Хепатитийн В, С вирусийн илрүүлэг, вирусийн идэвхжлийг тодорхойлох шинжилгээг 40-65 насны зорилтот бүлгийн хүн амыг хамруулахаар сонгон 2017 оны жилийн эцсийн байдлаар хепатитийн В, С вирусын эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээнд нийт 353,445 хүн хамрагдсан байгаа нь хамрагдвал зохих 40-65 насны хүн амын 47.1 хувийг эзэлж байна (аймгийн дундаж 60.4 хувь, нийслэл - 30.6 хувь).<br>Элэгний хорт хавдар, хатуурлын үндсэн шалтгааны нэг болсон С вирусийн өвчлөлийг эмчлэх 5 нэрийн эмийг улсын бүртгэлд бүртгэн, эм тус бүрийг нэг сарын 210,000 төгрөгийн, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гурван сарын нэг курс эмчилгээг нийт 630,000 төгрөгөөр эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнийн жороор олгож байна. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар С вирусын халдварын эсрэг эмчилгээнд нийт 20,288 даатгуулагч хамрагдаад байгаа бөгөөд Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газраас эдгээр иргэдийн эмчилгээнд 32,857 хайрцаг эмийн төлбөрт нийт 9.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг олгоод байна.<br>Мөн хепатитийн В вирус илрээгүй иргэдийг сайн дурын дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулж, нийт 73,869 гаруй иргэдийг хамруулсан. | |
| 13.3 | МУТХҮБ-ын 2.2.2, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 3.1.10 дахь дэд заалт | Гемодиализын тусламж, үйлчилгээний хүртээмжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нэмэгдүүлэх | Эмчилгээнд хамрагдах өвчтөний тоо | 616 | | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд анх удаа гемодиализийн тусламж, үйлчилгээг Засгийн газрын 2016 оны 11 сарын 23-ны өдрийн 159 дүгээр тогтоолоор гемодиализ-бөөр орлуулах эмчилгээний зардлыг төрөөс хариуцах тогтолцоог бүрдүүлсэн. Хувийн хэвшлийн 7 эмнэлэгтэй "Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан гемодиализ эмчилгээг санхүүжүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 2017 оны 2 дугаар сарын 15-аас эхлэн хувийн хэвшлийн 7 эрүүл мэндийн байгууллагаар 154 гаруй иргэн үнэ төлбөргүй эмчилгээ, үйлчилгээнд хамрагдсан.<br>2017 оны байдлаар нийслэл хотод 123, үүнээс хувийн хэвшилд 48 аппарат, 20 аймагт 51 аппарат, нийт улсын хэмжээнд 174 гемодиализын аппаратаар 642 иргэн гемодиализ эмчилгээнд хамрагдаж байна. Цаашид Дундговь аймагт 2 гемодиализийн аппарат суурилуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 100 |
| 13.4 | МУТХҮБ-ын 2.2.2, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 3.1.11 дэх дэд заалт | Эх орондоо оношлуулах нөхцөлийг сайжруулж, гадаад оронд эмчлүүлэх | Үндэсний оношлогоо эмчилгээний төвийн барилгын ажлын явц, | 50.0 | 2.2 Улсын төсөв | Үндэсний оношилгоо, эмчилгээний төв (ҮОЭТ)-ийн барилга угсралтын ажил хуваарийн дагуу хийгдэж, гүйцэтгэл 70 хувьтай байна (барилгын гадна өрлөг, фасадны ажил бүрэн дууссан).<br>"Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах" төслийн Монголын талын хөрөнгөөр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | иргэдийн тоог бууруулах бодлого хэрэгжүүлэх | хувиар; /одоогийн түвшин 5.0/ | | | цогцос хадгалах байрны барилгын угсралтын ажлын гүйцэтгэтгүүлэхээр “Жу Жу” ХХК-тай гэрээ байгуулан барилга угсралтын ажил үргэлжилж 2018 оны 6 дугаар сард ашиглалтад өгөхөөр ажиллаж байна. Мөн барилгын гадна шугам сүлжээний ажлыг гүйцэтгэхээр 2018 онд дахин тендер зарлахаар болсон.<br>Эх орондоо эмчлэгдэхгүй байсан дараах 9 төрлийн өвчнийг эх орондоо эмчилдэг болсон. Үүнд:<br>1. Гүрээний ба нурууны артерийн нарийсал, бөглөрлийн үеийн мэс засал;<br>2. Дунд тархи ба багана бүтцийн байрлалтай мальформац;<br>3. Ретинобластомийн улмаас нүд авахуулсны дараах нөхөн сэргээх мэс засал;<br>4. Абляци эмчилгээ хийлгэх шаардлагатай зүрхний хэм алдагдал;<br>5. Улаанхоолой-цагаан мөгөөрсөн хоолойн фистул;<br>6. Түлэгдлийн улмаас үүссэн талбай ихтэй, том мөчид болон цээжний хэлбэр алдагдсан сорив;<br>7. Төрөлхийн адреногениталь хам шинж;<br>8. Өндгөвчний төрөлхийн дутуу хөгжлөөс үүдсэн үргүйдэл;<br>9. Эрэгтэйчүүдийн үрийн сувгийн эмгэгээс үүдсэн үргүйдэл.<br>Түүнчлэн элэг, бөөр, ясны чөмөг шилжүүлэн суулгах мэс ажилбарын зардлыг төрөөс 100 хувь хариуцаж байна. | |
| 13.5 | МУТХҮБ-ын 2.2.2, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 3.1.10 дахь дэд заалт | Осол гэмтэл, түлэнхийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх | Түлэнхийн үндэсний төвийн барилгын ажлын явц, хувиар; /одоогийн түвшин 30.0/ | 80.0 | 0.5<br>Улсын төсөв | 2017 онд улсын төсвөөс 500.0 сая төгрөгийн санхүүжилт Түлэнхийн төвийн барилгын ажилд зарцуулагдсан. Барилгын угсралтын ажлын гүйцэтгэгч байгууллага “Цаст констракшн” ХХК-ийн А, С блокны ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд А блокын 5 давхрын ажил дууссан байна (гүйцэтгэл 70 хувь). 2 дах гүйцэтгэгч “Нутгийн зам” ХХК-ийн ажил нь Б блокын зоорь болон 2 давхрын цутгалтын ажил дууссан (гүйцэтгэл 30 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувь).<br>Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангаас 8 сая ам.долларын буцалтгүй тусламжийг олгохоор болж, 6.8 сая ам.долларыг барилгад, 1.2 сая ам.долларыг тоног төхөөрөмжид зарцуулахаар болсон. Засгийн газрын 2016 оны 56 дугаар тогтоолоор ГССҮТ-ийн харьяа Түлэнхийн төвийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн. | |
| 13.6 | МУТХҮБ-ын 2.2.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.1.16 дахь дэд заалт | Эмнэлгийн аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах хүрээнд бүсийн оношлогоо эмчилгээний төв болон аймгийн нэгдсэн эмнэлгийн дэргэд хог хаягдлыг түр хадгалах байгууламжийг барих | Шинээр байгуулах байгууламжийн тоо | 6 | 0.22 Улсын төсөв<br>0.15 Гадаад эх үүсвэр | Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5”-ын Эмнэлгийн хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн хүрээнд Өмнөговь, Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлгийн хог хаягдлын барилга байгууламжийг нийт 371 сая төгрөгөөр барьж байгуулсан. Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Увс, Хэнтий зэрэг 5 аймагт хог хаягдлын байгууламж барих тендер зарлах үйл ажиллагааны бэлтгэл ажил хийгдэж байна.<br>Хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор ДЭМБ-ын зөвлөх Яан Герд 5 өдрийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, хог хаягдал хариуцсан мэргэжилтнүүдэд нэг өдрийн уулзалт, семинарыг зохион байгуулсан. | 70 |
| 13.7 | МУТХҮБ-ын 2.2.2, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 3.1.11 дэх дэд заалт | Оношлогоо, эмчилгээний заавар, стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулж, эрүүл мэндийн чанар аюулгүй байдлыг сайжруулах | Шинээр болон шинэчлэн боловсруулах стандарт, зааврын тоо | 15 | - | 2017 онд бүтэц, үйл ажиллагааны 7 стандарт, эрүүл мэнд, оношилгоо, эмчилгээний 19 стандарт, заавар шинээр батлагдсан. Үүнд:<br>1. Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5292:2017 стандарт;<br>2. Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5095:2017 стандарт;<br>3. Клиникийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6673:2017 стандарт;<br>4. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6330:2017 стандарт;<br>5. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6674:2017 стандарт; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6675:2017 стандарт;<br>7. Эмгэг судлалын үндэсний төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6676:2017 стандарт;<br>8. “Автомат тохируулагтай дефибриллятор стандарт;<br>9. Зүрхийг автоматаар сэдээгч (ЗАС)-д тавих ерөнхий шаардлага MNS 6650:2017 стандарт;<br>10. “Бөөрний чулууны найрлагыг тодорхойлох нил улаан туяаны спектрофотометрийн арга MNS 6651:2017” стандарт;<br>11. Глауком өвчний оношилгоо, эмчилгээ. MNS 6677:2017 стандарт;<br>12. Хамрын таславч тэгшлэх мэс засал. MNS 5357:2017 стандарт;<br>13. Зонхилон тохиолдох өвчний үед цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх заавар;<br>14. Ревматоид артритын оношилгоо, эмчилгээний заавар;<br>15. Нярайн сурфактант эмчилгээний заавар;<br>16. Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдлийн үнэлгээ хийх заавар;<br>17. Хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан заавар;<br>18. Яс үений үрэвслийн оношилгоо, эмчилгээний заавар;<br>19. Тарваган тахал, боом, галзуу, хачигаар дамжих халдварт өвчний, бэтэг, урвах тахал өвчний хяналт, сэргийлэлтийн заавар;<br>20. Зоонозын халдварт өвчний үед ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн заавар;<br>21. Нянгийн халдварлгүйтгэлийн заавар;<br>22. Хүнсний сав, боодлын нүүрэн хэсэгт шим тэжээлийн мэдээлэл байршуулах заавар;<br>23. Тосны булчирхайн хоргүй хавдрын, Дээд уруулын богино хөвчний, Шүдний гаралтай эрүү хоншоор ясны үрэвслийн, Амны хөндийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | салстын хучуур эдийн гаралтай хоргүй хавдрын, оношилгоо, эмчилгээний заавар;<br>24. Нярайн амьсгал хямралын хамшинжийн оношилгоо, эмчилгээний заавар;<br>25. Амьсгалын замд үргэлжилсэн эерэг даралт үүсгэн амьсгалуулах эмчилгээний заавар;<br>26. Төрөх үед болон төрсний дараа нярайд үзүүлэх тусламжийн заавар, Нярайн сэхээн амвдруулалтын заавар;<br>27. Дутуу, бага жинтэй нярайг амаар хооллох заавар;<br>28. БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, Бэлгийн замаар дамжих халдварын оношилгоо, эмчилгээний заавар;<br>29. ХДХВ, ДОХ-ын оношилгоо, эмчилгээний заавар;<br>30. Хоол хүнсээр дамжих өвчний голомтонд ажиллах заавар;<br>31. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар;<br>32. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний заавар.<br>33. Хоол хүнсээр дамжих өвчний үеийн хариу арга хэмжээ авах журам;<br>34. Эмнэлзүйн заавар, хөтөч боловсруулах журам. | |
| 13.8 | МУТХҮБ-ын 2.2.2, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 3.1.9 дэх дэд заалт | Үндэсний эмийн үйлдвэрүүдэд “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал” /GMP/-ыг нэвтрүүлж, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр | “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал” /GMP/-ын батламж олгох үйлдвэрийн тоо | 2 | - | - Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/348 дугаар тушаалаар “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал” (GMP)-ын батламж олгох журам” баталсан.<br>- “Нахиа” эмийн үйлдвэрт “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал” (GMP)-ын батламжийг олгож, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/492 дугаар тушаалаар баталгаажуулсан.<br>- "Энхийн шүүдэр" дуслын шингэний үйлдвэр, “Айвико” үйлдвэрт Эмийн үйлдвэрлэлийн зохистой дадал GMP-ын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | иргэд, эрүүл мэндийн байгууллагыг хангах | | | | урьдчилсан үнэлгээ хийх шинжээч томилон ажиллуулан холбогдох дүгнэлтийг гаргасан.<br>- "Эм үйлдвэрлэлийн зохистой дадал" (GMP) сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулж, GMP шинжээч, МХЕГ-ын байцаагч, эмийн үйлдвэрийн менежер зэрэг 50 хүнийг хамруулсан. | |
| 13.9 | ЗГҮАХ-ийн 3.1.2 дахь дэд заалт | Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношлогоо, шинжилгээнд үе шаттайгаар хамруулах | Шинжилгээнд хамрагдах хүний тоо | 125,000 | | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор "Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах журам"-ыг батлуулсан. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан 40-65 настай даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд 3 багцаар буюу дотор эрхтний архаг өвчлөлийг илрүүлэх, дотор эрхтний архаг өвчлөл болон үе мөчний эмгэг илрүүлэх, хавдрын эрт илрүүлэх үзлэгт хамруулахаар болсон. Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/94/А/193 дугаар тушаалаар "Даатгуулагчийг элэгний В, С вирусын илрүүлэг, шинжилгээнд хамруулах, даатгалын сангаас зардлын төлбөрийг санхүүжүүлэх журам", Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/200 болон 2017 оны А/373 дугаар тушаалаар "Элэгний В, С вирусын илрүүлэг, шинжилгээнд хамруулах иргэдийн тоо, шаардагдах төсвийг аймаг, дүүргээр" баталсан. Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах эрх зүйн орчин бүрдүүлсэн.<br>2017 оны байдлаар нийслэлийн хэмжээнд 32, орон нутагт 45 хувийн хэвшлийн болон төрийн эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. Нийт 41,276 даатгуулагч урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулсан. Мөн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хепатитийн В, С вирусын эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээнд нийт 353,445 хүн хамрагдсан байгаа нь хамрагдвал зохих 40-65 насны хүн амын 47.1 хувийг эзэлж байна.<br>Хөдөө, орон нутгаас нийслэлд суралцаж буй оюутан, суралцагчдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын харьяаллыг Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2016 оны А/51, А/47, А/136 дугаар тушаал батлагдаж, оюутан, суралцагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн. | |
| 13.10 | МУТХҮБ-ын 2.2.2, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 3.1.11, 3.1.17 дахь дэд заалт | Өндөр өртөгтэй оношлогоо, шинжилгээ, мэс заслын зардлыг бууруулах бодлого хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | | Өндөр өртөгтэй оношилгоо, эмчилгээ, мэс заслын тусламж, үйлчилгээний зардалд үнэлгээ хийх, бодит өртгийг тооцох ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2016 оны 12 сарын 19-ний өдрийн А/298/А199 дүгээр хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгууллагдан өндөр өртөгтэй оношилгоо, эмчилгээ, мэс заслын тусламж, үйлчилгээний зардалд үнэлгээ хийж, бодит өртгийг тооцсон "Даатгуулагчид үзүүлэх өндөр өртөг бүхий мэс заслын зарим тусламж, үйлчилгээнд шаардагдах зарим эмнэлгийн хэрэгсэл, протезийн зардлыг даатгалын сангаас олгох зардлын хэмжээ"-г боловсруулж, нийт 484 нэр төрлийн эмнэлгийн хэрэгслийг 612 нэр төрөл болгон нэмэгдүүлэх саналын боловсруулав.<br>2017 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопедийн зардалд 30.5 тэрбум төгрөгийг 18,570 даатгуулагчдад олгосон нь 2016 оны дүнгээс 14.9 тэрбум төгрөгөөр их юм.<br>Мөн Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд хандив тусламжаар нийлүүлэгддэг мэс заслын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, цусны хавдарын эмүүдийг гаалийн татвараас чөлөөлүүлэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлж, НӨАТ-аас чөлөөлөх асуудлыг Засгийн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 30 дугаар тэмдэглэлээр дэмжсэн. | |
| 13.11 | МУТХҮБ-ын 2.2.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.1.10 дахь дэд заалт | Багийн эмч болон хотын алслагдсан хороодын өрхийн эрүүл мэндийн төвийг унаагаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 5.3 Улсын төсөв | Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн автомашины хэрэгцээний судалгааг авч, 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 21 аймгийн сумын эрүүл мэндийн төвүүд, алслагдсан хороодын өрхийн эрүүл мэндийн төвүүдэд улсын төсвийн санхүүжилтээр түргэн тусламжийн шинэ автомашин хуваарилж, орон нутгийн түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлтийг хийсэн. 2017 оны Эрүүл мэндийн сайдын багцаас нийт 190 автомашин худалдан авч нийт 5.3 тэрбум төгрөг зарцуулсан. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/172, А/237, А/310 дугаар тушаалаар орон нутгийн болон алслагдсан дүүрэг, тосгоны эрүүл мэндийн байгууллагад автомашиныг хуваарилсан. Эрүүл мэндийн сайдын А/391 дүгээр тушаалаар нийслэлийн алслагдсан Хан-Уул, Баянзүрх дүүргийн алслагдсан хороодын өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд 14 ширхэг Тоёота Пробокс автомашин хуваарилсан байна. Мөн 2017 оны 12 дугаар сард нийт 111 мотоцикл (96 баг, 5 алслагдсан хороодын өрхийн эрүүл мэндийн төв)-ийг баг, алслагдсан хороодын өрхийн эрүл мэндийн төвд хуваарилсан. | 100 |
| 13.12 | МУТХҮБ-ын 2.2.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.1.2 дахь дэд заалт | Хөдөөгийн хүн амд зориулсан явуулын үзлэг, оношлогоо, эмчилгээ хийх эмнэлгийн үйлчилгээг бий болгох | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 0.9 Гадаад эх үүсвэр | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, БНСУ-ын олон улсын эрүүл мэндийн сан, БНСУ-ын иргэдийн сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлж буй "Эрүүл мэндийн анхан болон олон нийтийн түвшинд мобайл технологийг нэвтрүүлэх нь" төслийн хүрээнд явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай 23 нэр төрлийн тоног төхөөрөмж, оношлуурыг Архангай, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл, Говь-Алтай, Төв зэрэг 10 аймгийн сонгосон нэг сумын Эрүүл мэндийн төв, нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн сонгосон 1 өрхийн Эрүүл мэндийн төвд хуваарилж, нийт 54,000 хүнийг урьдчилан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэргийлэх үзлэгт хамруулсан. Нийт 45 эмч, мэргэжилтнийг эрт илрүүлгийн сургалтад хамруулж чадавхжуулсан.<br>2017 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг явуулын хэлбэрээр нийт 19 аймгийн 275 сум, нийслэлийн 9 дүүргийн 323,804 иргэнийг хамруулж, 1,654 иргэнийг төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ авахаар холбогдох байгууллагуудад шилжүүлж, эмчилгээг хийсэн.<br>Сүрьеэгийн өвчлөл өндөртэй Дархан-Уул, Сэлэнгэ, Говьсүмбэр, Дорноговь, Завхан зэрэг 5 аймагт сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэгт 7,936 хүнийг, сүрьеэгийн тохиолдол илэрсэн 35 хүнийг эмчилгээнд хамруулсан. | |
| **Зорилт 14.Гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих бодлого явуулж, эрх зүйн орчныг сайжруулна** | | | | | | | |
| 14.1 | ЗГҮАХ-ийн 3.3.28, 3.4.9 дэх дэд заалт, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын Зорилт 4.3 | Гэр бүл, Хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих бодлого хэрэгжүүлж, эрх зүйн орчныг сайжруулах | Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | 4 | - | 1. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоолоор баталсан.<br>2. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг УИХ-ын 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.<br>3. Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн А/186 дугаар тушаалаар байгуулан ажиллаж төслийг Завхан, Дорнод, Дорноговь, Дархан-Уул аймгуудын залуучуудын бүсийн хэлэлцүүлэг, “Тогтвортой хөгжилд залуучуудын оролцоо” үндэсний чуулгыг зохион байгуулж хэлэлцүүлж, залуучуудын санал, зөвлөмжийг тусган боловсруулсан.<br>4. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 321 дүгээр тогтоолоор баталсан. | 100 |
| 14.2 | МУТХҮБ-ын | Нийгмийн | Шинээр болон | 3 | - | 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.2.1, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 3.3.17 дахь дэд заалт | даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах | шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | | | "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл" сэдэвт үндэсний хэлэлцүүлгийг УИХ-ын гишүүд, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Олон улсын Хөдөлмөрийн байгууллага, Японы улсын олон улсын хамтын ажиллагааны "ЖАЙКА" байгууллагын төлөөлөгчид, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын болон нийслэл, хөдөө , орон нутгийн удирдлага нар, нийгмийн түншлэгч талуудын төлөөлөл, эрдэмтэн, судлаачид, төрийн болон хувийн хэвшлийнхний 160 гаруй төлөөлөгчдийн оролцоотой зохион байгуулсан.<br>Мөн хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог боловсруулж, хуулийн төсөлд яамдын саналыг тусган, Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэний дагуу, УИХ-д өргөн мэдүүлсэн. Төслийг УИХ-ын 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр НББСШУ-ны Байнгын хороонд шилжүүлсний дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төслийг дагалдуулан 10 гаруй хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлээд байна.<br>Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр холбогдох эрх зүйн зохицуулалтын судалгаа хийх, Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж хуулийн төслийг боловсруулав.<br>Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгээс "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль"-ийн төсөл, "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль"-ийн төсөл, "Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хууль"-ийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулж, ХНХ-ын сайдын зөвлөлийн 2017 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлж, зөвлөлийн гишүүдийн саналыг тусган эцэслэн боловсруулсан. | |
| 14.3 | МУТХҮБ-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.1.19 дэх дэд заалт | Эрүүл мэндийн салбарын албан хаагчийн цалин хөлсний ангилал, зэрэглэлийг боловсронгуй болгох бодлого хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчилж, цалин хөлсний оновчтой тогтолцоо бий болгох арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/04/А/21 дугаар хамтарсан тушаалаар дэд ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө батлан хэрэгжүүлсэн. Үүнд:<br>1. Эмнэлгийн мэргэжилтний ажлын байрыг онооны аргаар үнэлэх аргачлалыг боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн А/107,А/230 тоот хамтарсан тушаалаар батлуулсан.<br>2. Эмнэлгийн мэргэжилтний ажлын байранд үнэлгээ хийх үнэлгээний хорооны бүрэлдэхүүн Эрүүл мэндийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн А/231 дүгээр тушаалаар байгуулагдаж, үнэлгээнд хамрагдах төлөөлөх ажлын байр, холбогдох ажлын байруудыг судалж, үнэлгээний хорооны хурлаар хэлэлцүүлэн сонгосон.<br>3.Эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны үнэлгээ хийх үндсэн болон дэд хүчин зүйлсийг боловсруулах, харгалзах түвшингүүдийг тодорхойлох, түвшингүүдийн оноог тогтоох, бүлэглэх, зэрэглэх, зэрэглэлийн тоо болон онооны интервалыг тогтоох зэрэг ажлуудыг хийж, "Эмнэлгийн мэргэжилтний ажлын байрыг онооны аргаар үнэлэх аргачлал"-ын дагуу сонгогдсон 75 төлөөлөх ажлын байранд урьдчилсан үнэлгээ хийж, үр дүнг нэгтгэн боловсруулалт хийж, хэлэлцүүлсэн. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн А/139 дугаар тушаалаар эрүүл мэндийн салбарын ажил, мэргэжлийн жагсаалт, индекс кодыг шинэчлэн батлуулсан.<br>5. Эрүүл мэндийн яамны харъяа аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын байрыг үнэлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан удирдамжийг батлуулж, хэрэгжүүлсэн. Удирдамжинд заасны дагуу эрүүл мэндийн гурван шатлалыг хамруулсан төв, орон нутгийн нийт 30 байгууллагын 2600 орчим эмч, эмнэлгийн мэргэжилтнээс мэргэшлийн ур чадвар, хариуцлага, ажлын ачаалал, хөдөлмөр эрхлэлтийн нөхцлийг харгалзсан ажлын байрны үнэлгээг авсан.<br>6. Үнэлгээний үр дүнг нэгтгэн боловсруулалт хийсний үндсэн дээр ажлын байрны ангилал, зэрэглэлийн төслийг боловсруулж, “Ажлын байранд суурилсан цалин хөлсний тогтолцоог нэвтрүүлэх нь” сэдэвт ОУХБ, нийгмийн түншлэгч талууд, салбарын яамдын төлөөллийг оролцуулсан уулзалт хэлэлцүүлэгт танилцуулсан. Уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнд гарсан саналуудыг тусган, Эрүүл мэндийн яамтай хамтран эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийн төслийг эцэслэн боловсруулсан. | |
| 14.4 | МУТХҮБ-ын 2.2.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.3.19 дэх дэд заалт | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн | Шинээр боловсруулах хөтөлбөрийн тоо | 1 | - | “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний 5 дахь хөтөлбөр”-ийн төслийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын дагуу боловсруулан холбогдох судалгааг хийж, хэлэлцүүлгүүдийг үе шаттай зохион байгуулан саналыг тусган Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 243 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бодлого боловсруулах | | | | дугаар тогтоолоор батлуулсан. | |
| 14.5 | МУТХҮБ-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.17 дахь заалт | Бичил аж ахуйн нэгж, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг зээлийн бодлогоор дэмжих | Шинээр боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | 2 | 10 ХЭДС | Монгол Улсын Засгийн газар болон Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн хооронд 2011 оны 6 сарын 17-ны өдөр байгуулсан "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслийн "Санхүүжилтийн хэлэлцээр", түүнд оруулсан 2013 оны 4 сарын 1-ний өдрийн Нэмэлт өөрчлөлтийн гэрээний хүрээнд Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Голомт банк хооронд 2017 оны 8 дугаар сарын 01-ний өдөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож буй жижиг зээлд батлан даалт гаргах "Багцын батлан даалт"-ын гэрээг байгуулан хэрэгжүүлсэн. 2017 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг хариуцан гүйцэтгэх арилжааны банкыг сонгон шалгаруулж, Голомт банктай гэрээг байгуулан 20.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг байршуулан, жижиг зээл олгов.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагааг 2017 онд Төрийн банк, Капитал банк, Голомт банк хариуцан гүйцэтгэж 1915 зээлдэгчид 9.8 тэрбум төгрөгийн жижиг зээлийг олгосноор 6163 ажлын байр бий болсон байна. | 40 |
| | | | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авах бичил аж ахуйн нэгж, иргэдийн тоо | 6000 | | | |
| | | | Шинээр бий болох ажлын байрны тоо | 10,000 | | | |
| 14.6 | МУТХҮБ-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.3.4 дэх дэд заалт | Хөдөлмөрийн зах зээлд эрэлт ихтэй мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд олгох хөдөлмөр эрхлэлтийн болон үйлдвэрлэл дээрх сургалтыг | Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдах хүний тоо | 5000 | 0.7 ХЭДС | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор "Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр"-ийг батлан нэгдсэн удирдамжийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 02 сарын 16-ны өдрийн А/26 тоот тушаалаар, зардлын жишиг хэмжээг 2017 оны 01 сарын А/18 тоот тушаалаар тус тус батлан хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд 3273 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд, 523 иргэнийг үйлдвэрлэл дээрх сургалтад, 3428 иргэнийг мэргэжлийн болон давтан сургалтад, тус тус хамруулж ур чадвар эзэмшсэн 1377 иргэнийг тогтвортой | 100 |
| | | | Үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдах хүний тоо | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | зохион байгуулах | | | | ажлын байртай болгосон. | |
| 14.7 | МУТХҮБ-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.3.10 дахь дэд заалт | Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын удирдах ажилтан, багш нарыг чадавхижуулах | Сургалтад хамрагдах багшийн тоо | 200 | - | 2017 онд 86 сургалтын байгууллага, зургаан бүсийн арга зүйн төвүүдэд багш, арга зүйчийг хөгжүүлэх чиглэлээр 1629 багшийг сургалтад хамруулан мэргэшүүлсэн. Мөн 469 багшийг мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллээр хангаж, 273 багш, арга зүйчдийг туршлага судлах аялалд хамруулж, зургаан Бүсийн арга зүйн төвүүдийн нийт 209 менежер арга зүйчид, мэргэжилтнүүдийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан.<br>Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, төслийн хүрээнд Түнш байгууллагуудад гадаадын 12 техникийн зөвлөх ажиллаж, барилга, механикийн чиглэлээр нийт 8 удаагийн 60 багшид түгээн дэлгэрүүлэх сургалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудад зохион байгуулсан. ХБНГУ болон Сингапур улсад 4 удаагийн нарийн мэргэжлийн сургалт явагдсан ба нийт 25 багш, 7 аж ахуйн нэгжээс төлөөлөл хамрагдсан.<br>Үйлдвэрлэлийн дадлагажуулагч багш бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд ХБНГУ-д 34 сургагч болон шалгагч багш, Монгол Улсад бэлтгэгдсэн 89 сургагч болон шалгагч багш, аж ахуйн нэгжийн дадлагажуулагч 273 багшийг тус тус бэлтгэсэн.<br>Гамшигийн мэдлэг олгох сургалтын мэргэжлийн багш нарын чадавхи бэхжүүлэх 2 хоногийн 16 цагийн сургалтыг Онцгой байдлын ерөнхий газар, Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан. Сургалтанд нийт 86 багш, арга зүйчдийг хамруулж, гэрчилгээ олгосон. | 100 |
| | | | Байгууллагын тоо | 40 хүртэл | | | |
| 14.8 | ЗГҮАХ-ийн 2.15 дахь заалт | "Итгэлийн зээл" олгох хөтөлбөр хэрэгжүүлэх | Бэлтгэл ажлын явц, хувиар | 100.0 | 10.0 ХЭДС | Тогтвортой үйл ажиллагаа эрхлэн явуулж буй бичил бизнес эрхлэгчдийг ажлын байраа хадгалах болон шинээр ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд итгэлийн зээл буюу эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг арга хэмжээг хэрэгжүүлсэн.<br>Үүний хүрээнд 2017 онд 2151 иргэнд 5.05 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгосноор 2696 ажлын байр шинээр бий болсон байна.<br>Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан хэрэгжүүлж байна. Үүнд:<br><br>1. Банкинд байршуулсан зээлийн хөрөнгийн тогтмол үлдэгдэлд хүү тооцох. Ингэснээр банк иргэн, аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршоонд богино хугацаанд жижиг зээл олгох нэгэн хөшүүрэг болж өгсөн.<br>2. Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хэмжээг зорилтот бүлгүүдийн онцлогт тохируулан 50-иас доошгүй хувь болгон нэмэгдүүлэх. Ингэснээр 2017 оноос эхлэн олгогдож буй санхүүгийн дэмжлэгүүд 100 хувь эргэн төлөлттэй болсон.<br>Хөдөлмөр, нийгэм, хамгааллын салбарын институц шинэчлэгдэн зохион байгуулагдсантай холбоотойгоор жижиг зээлийн хөрөнгөнд хяналт тавих, тайлагнах, зохион байгуулалтад өөрчлөлт оруулсан. Мөн 2017 оны 8 дугаар сарын 01-ний өдөр багцын батлан даалтын гэрээг шинэчлэн байгуулж мөрдлөг болгон ажиллаж байна. | |
| 14.9 | ЗГҮАХ-ийн 3.3.22 дахь дэд заалт | “Насны хишиг”-ийг Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгох | Хамрагдах ахмад иргэдийн тоо | 78.800 | 19.6 ХЭДС | Засгийн газраас өргөн мэдүүлсэн Ахмад настны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг Монгол Улсын Их Хурал 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталж 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж байна.<br>Хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор “Ахмад настанд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг, хөнгөлөлт олгох журам", "Ахмадын сан байгуулан ажиллах журам", "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам", "Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн санг удирдах, ашиглах журам", "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх" журмуудыг тус тус батлан 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж байна.<br>Мөн Ахмад настны тухай хуулийн 12.2-т заасны дагуу Засгийн газрын 2017 оны 31 дүгээр тогтоолоор "Насны хишиг олгох журам"-ыг батлан хэрэгжүүлж байна. Насны хишигт зориулан 2017 оны улсын төсөвт 20.5 тэрбум төгрөгийг тусган Билгийн тооллын хаврын тэргүүн сар-цагаан сар, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярыг тохиолдуулан Монгол Улсын дараахь насны иргэнд доор дурдсан хэмжээгээр жилд хоёр удаа олгож байна. Үүнд:<br>- 65-69 настай ахмад настанд тавин мянган төгрөг;<br>- 70-79 настай ахмад настанд наян мянган төгрөг;<br>- 80-89 настай ахмад настанд нэг зуун тавин мянган төгрөг;<br>- 90 ба түүнээс дээш настай ахмад настанд хоёр зуун тавин мянган төгрөгийг тус тус олгож байна.<br>Журамд заасны дагуу Насны хишгийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газартай нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох гэрээ байгуулсан Төрийн банк, Хаан банк, Капитал банкаар дамжуулан 2017 онд насны хишгийг нийт 118 мянга гаруй ахмад настанд олгож улсын төсвөөс 19.6 тэрбум төгрөгийг зарцуулаад байна. | |
| 14.10 | МУТХҮБ-ын 2.2.3, | Хүүхэд харах үйлчилгээний | Үйл ажиллагааны | 100.0 | 5.8 Улсын төсөв | Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Сангийн сайдын 2017 оны 3 дугаар сарын 21-ний А/41, 89 тоот | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Зорилт 1 | тухай хуулийн дагуу хүүхэд харах үйлчилгээг үргэлжлүүлэх | хэрэгжилт, хувиар | | | хамтарсан тушаалаар хүүхэд харах үйлчилгээнд хамруулах хүүхдийн тооны дээд хязгаарыг аймаг, нийслэлийн эрэлт, хэрэгцээтэй уялдуулан баталсан. Уг тушаалаар нийт 5275 хүүхдийг хамруулахаас 2017 оны жилийн эцсийн байдлаар 4948 хүүхэд /үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 138/ хамрагдлаа.<br>Хүүхэд харагчдыг чадавхижуулах сургалтын хүрээнд сургагч багшаар нийслэл, дүүрэг, төрийн бус байгууллагаас нийт 25 хүнийг бэлтгэж, хүүхэд харагч нарыг давтан сургах ажлыг 2017 оны 04-06 дугаар сард 9 дүүрэг, Өвөрхангай, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад зохион байгуулж, 551 хүүхэд харагчийг хамруулж, давтан сургалтын гэрчилгээ олгов. Бусад аймгуудад Хүүхэд харагч нарт зориулсан сургалтын жишиг хөтөлбөрийг, хүргүүлж, 986 хүүхэд харагч давтан сургалтад хамрагдсан.<br>2018 оны төсвийн тухай хуулийг УИХ-д өргөн барихтай холбогдуулан Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгох асуудлаар хуулийн төсөл боловсруулан, батлуулав. | |
| **ТАВ. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО** | | | | | | | |
| **Зорилт 15. Хууль сахиулах үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгоно** | | | | | | | |
| 15.1 | МУТХҮБ-ын 2.4, Зорилт 1, 2, ЗГҮАХ-ийн 5.1.15 дахь дэд заалт | Хууль сахиулах үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах | Шинэчлэн найруулах хуулийн төслийн тоо | 4 | - | - Цагдаагийн албаны тухай хууль,<br>- Прокурорын байгууллагын тухай,<br>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай,<br>- Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулав. | 100 |
| | | | Шинээр боловсруулах хуулийн төслийн тоо | 2 | - | - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.<br>- Цагдаагийн албаны тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг Улсын Их хурлаар 2017 оны 2 дугаар 9-ний өдрийн болон 2017 оны 5 дугаар сарын 11-ний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав. | |
| 15.2 | МУТХҮБ-ын 2.4, Зорилт 1, 2, ЗГҮАХ-ийн 5.2.5, 5.2.7 дахь дэд заалт | Төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгох, иргэний өмчлөх эрхийг баталгаажуулах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг сайжруулах | Шинээр боловсруулах хуулийн төслийн тоо | 3 | - | Иргэн, хуулийн этгээдийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн баталгааг хангах хүрээнд<br>- Улсын бүртгэлийн ерөнхий хууль,<br>- Иргэний улсын бүртгэлийн тухай хууль<br>- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Засгийн газрын 2016 оны 12 сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжин, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэв. | 70 |
| | | | Шинэчлэн боловсруулах журмын тоо | 3 | - | “Монгол Улсын виз олгох журам” болон “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. | |
| 15.3 | МУТХҮБ-ын 2.4, Зорилт 1, 2, ЗГҮАХ-ийн 5.2.8 дахь дэд заалт | Улсын бүртгэлийн ажиллагааг онлайн горимд шилжүүлж, “Нэг иргэн-нэг бүртгэл” хөтөлбөр хэрэгжүүлэх замаар бүртгэлийн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлэх | Гадаад паспортын үйлчилгээнд цахим олголтын программыг нэвтрүүлэх ажлын явц, хувиар | 60.0 | - | Гадаад паспорт олголтын програмыг боловсруулж, гадаад паспортыг 2017 оны 2 дугаар сараас цахим хэлбэрээр олгож, мэдээлэл програмаас шууд гардаг болсон. Уг програм нэвтэрснээр гадаад паспорт олголтын хугацаа өмнөхөөс 4 дахин багассан үзүүлэлттэй байна. Иргэний гадаад паспорт авах хуудас дээрх бар кодыг уншуулж, тухайн гадаад паспорт аль хайрцагт, хэд дэх дугаарт байгаа талаарх мэдээлэл програмаас шууд гардаг болсноор иргэдэд шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх нөхцлийг бүрдүүлсэн. Түүнчлэн иргэнд олгосон гадаад паспортын хугацаа системд бүртгэгдэж мэдээллийн сан үүсч, ингэснээр олгосон гадаад паспортын мэдээлэлд хяналт тавих боломж бүрдсэн. | 70 |
| | | | Иргэдэд тоон гарын үсэг олгох бэлтгэл ажлын явц, хувиар | 100.0 | - | Иргэний цахим үнэмлэхийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор эхний ээлжинд бүртгэлийн нэгж дээр чипэн дэх мэдээллийг уншиж, хаягийн бичвэрийг хийх замаар хэрэглээнд нэвтрүүлэх програм хангамжийг боловсруулахаар Смарткарт ХХК болон Интерактив ХХК-тай тоон гарын үсгийг таниулах ажил дээр хамтран ажиллаж байна. Иргэний цахим үнэмлэх хэвлэх үйлдвэрийн програм | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хангамжид орох өөрчлөлтийн талаар холбогдох байгууллага болох Датакарт, Жемалто компаниудад хүсэлт тавьж, ажлын явцыг сайжруулах, бүртгэлийн байгууллагад тоон гарын үсгийг хүсэлт гаргасан иргэдэд зөвшөөрөл өгөх, иргэдэд тоон гарын үсэг олгохыг бүртгэлийн нэг үйлчилгээ болгох, хос түлхүүрийг 2048 битийн урттай 1 ширхэг сертификатыг үүсгэж, CSR буюу тоон гарын үсгийн хүсэлтийг тоон гарын үсгийн албан ёсны эрх бүхий гэрчилгээжүүлэгч байгууллага болох Монпасс ХХК-ны загварын дагуу өөрчилж, сервес /ОӨУБЕГ, Монпасс, Үндэсний Дата Төв эдгээрийг холбосон сүлжээ/-ээр өгөгдөл дамжуулан иргэний цахим үнэмлэхийн чип рүү бичилтийг амжилттай хийсэн. | |
| 15.4 | МУТХҮБ-ын 2.4, Зорилт 1, 2, ЗГҮАХ-ийн 5.3.4 дэх дэд заалт | Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | УИХ-ын 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, бусад дагалдах хуулийн төслийг хэлэлцүүлж, батлуулав. | 100 |
| 15.5 | МУТХҮБ-ын 2.4, Зорилт 1, 2, ЗГҮАХ-ийн 5.3.12 дахь дэд заалт | Гадаадын иргэнд үзүүлэх зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, бүртгэл, хяналтыг сайжруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | 2017 онд "Цахим иммигрэйшн" зорилтыг дэвшүүлж, зорилтын хүрээнд визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх програм хангамжийн хэрэглэгчийн шаардлагыг боловсруулж, ашиглалтад оруулснаар evisa.mn хаягаар үйлчилгээг үзүүлж, тайлант хугацаанд нийт 58 системийн хэрэглэгчийг бүртгэн 15 визийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлээ. Виз, зөвшөөрлийн газрын үйлчилгээний хариуг иргэдэд мессежээр өгөх "SMS Pro" програм хангамжийг шинээр боловсруулан, 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн нэвтрүүлж, үүрэн утасны сүлжээ компаниудтай гэрээ байгуулснаар үйл ажиллагаа хэвийн үргэлжилж тайлант хугацаанд Мобикомын 3554, Юнителийн 1199, Скайтелийн 360 буюу нийт 5113 мессежний хариуг иргэдэд хүргүүллээ. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "ISM" системийн өргөтгөл сайжруулалтын хүрээнд "APIS буюу APP" системийг холбох тооцоо судалгааг хийж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөлд хүргүүлж, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сангийн холболтыг шинэчлэн програм хангамжийн сайжруулалтыг хамтарсан тушаалаар Цагдаагийн байгууллага, Гадаадын иргэн, харьяатын байгууллагын хамтран ажиллах журам, Харилцан солилцох мэдээллийн жагсаалтыг баталсан. Олон улсын эрэн сурвалжилж байгаа иргэний мэдээллийн бүртгэлийн систем болох Интерполын мэдээллийн системийг "ISM" системтэй холбох зорилгоор "ISM" системийн виз бүртгэл, хяналт шалгалтын хэсгийг бүсийн газруудад нэвтрүүлж, зайны сургалтыг зохион байгуулан, холбогдох эрхийг нээж өгсөн.<br>Интерполын үндэсний төв товчооны сургалтад 3 албан хаагч хамрагдан, програм хангамжийн хэрэглэгчийн шаардлагыг тодорхойлж "ISM" системтэй холбох бэлтгэл ажлыг хангасан. | |
| 15.6 | МУТХҮБ-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 5.4.10 дахь дэд заалт | Аж ахуйн нэгжтэй хамтарсан оёдлын болон шохойн чулууны үйлдвэрлэлийг өргөтгөж, ялтныг ажлын байраар хангах | Ялтныг ажлын байраар хангах хувь | 59.0 | 0.1 Дотоод орлого | 409 дүгээр хаалттай хорих анги "Тод баярт" ХХК-тай гэрээ байгуулан 23.8 сая төгрөгөөр цегейкен малгайн үйлдвэрийн 8 төрлийн 14 ширхэг тоног төхөөрөмж худалдан авч, суурилуулан, алба хаагчдын нормын хувцасны хангалтад 234 ширхэг өвлийн цегейкен малгайг үйлдвэрлэн нийлүүлсэн. 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги "Дөлгөөн" ХХК, "Өлзий" ХХК, "Харьяат тайчин" ХХК, "Саруул баясгалант" ХХК, "Монланс" ХХК, "Нарлаг Монгол" ХХК, 415 дугаар хаалттай хорих анги "Дөрвөлжийн бэл" ХХК, 409 дүгээр хаалттай хорих анги "Уушгийн агуй" ХХК, 439 дүгээр хаалттай хорих анги, 435 дугаар хаалттай хорих ангиуд "Эрдэнэт" ХК-тай тус тус хамтран ажиллах гэрээ байгуулан гэрийн бүрээс, арьсан тавчик, эсгий улавч, монгол гутал, арьсан тэлээ, даацын шуудай, баяжмалын шуудай зэрэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт **260** хоригдлыг ажлын байраар хангасан.<br>Шохойн чулууны чиглэлээр: 415 дугаар хаалттай хорих ангийн харьяа "ШТН" ТӨААТҮГ-ыншохойн чулууны уурхайн үйл ажиллагааг өргөтгөх, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор "Bluemore" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу Бутлуурын үйлдвэрийн төхөөрөмжийг суурилуулан, ашиглалтад оруулсан.<br>"Галт Юнайтэд" ХХК-тай 5 мянган тонн, "Эм жи жи" ХХК-тай 30 мянган тонн шохойн чулуу нийлүүлэх гэрээг тус тус байгуулж, өнөөдрийн байдлаар "Галт Юнайтэд" ХХК-ий 5 мянган тонн, "Эм жи жи" ХХК-д 15.2 мянган тонн, бусад байгууллагад 3.8. мянган тонн шохойн чулууг тус тус олборлон гэрээт байгууллагуудад нийлүүлсэн. Шохойн чулууны үйлдвэрт **30-50** хоригдлыг ажлын байраар ханган ажиллалаа.<br>2017 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр барилгын материалын үйлдвэрлэлд 115, уул уурхайн олборлолт 49, оёдол 638, мод бэлтгэл, модон эдлэл 163, чулуун бүтээгдэхүүн 88, газар тариалан 77, мал аж ахуй 112, гар урлал 144, хэвлэх цех 37, туслах аж ахуйд 1797 гэрээгээр 170, өөрсдийн барьж буй барилгад 93, нийт 3483 хоригдлыг ажлын байраар хангасан бөгөөд **нийт ялтны 62.4 хувийг ажлын байраар** хангав. | |
| 15.7 | МУТХҮБ-ын 2.4, Зорилт 1, 2, ЗГҮАХ-ийн 5.2.2 дахь дэд заалт | Худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгож, цахим хэлбэрээр зохион байгуулах | Нийт худалдан авалтад цахим худалдан авалтын эзлэх хувь | 60.0 | 0.2 Гадаад эх үүсвэр | Засгийн газрын Худалдан авах ажиллагааны анхны системийг 2012 онд ашиглалтад оруулж байсан бөгөөд үүнийг 2015-2016 онд шинэчлэн боловсронгуй болгох ажил хийгдэж, 2017 оны 2 дугаар сард ашиглалтад оруулснаар тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах боломж бүрдээд байна. Түүнчлэн худалдан авах ажиллагааны цахим системийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор оролцогч талуудад зориулсан сургалтыг орон даяар амжилттай зохион байгуулсан. Сургалтад | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | захиалагчийн төлөөллөөс нийт 790 хүн хамрагдсан бол тендерт оролцогчдын төлөөллөөс нийт 770 хүн хамрагдсан байна. Худалдан авах ажиллагааны цахим системд нийт 44 төсвийн ерөнхийлөн захирагчдийн 309 байгууллагын ерөнхий төлөвлөгөө нийтлэгдсэн байна. Улсын хэмжээнд цахим худалдан авалтын системд нийт 3581 урилга нийтлэгдсэн байх бөгөөд үүнээс нийт 2150 цахим тендер зарлагдсан байна. | |
| 15.8 | МУТХҮБ-ын 2.4, Зорилт 1, 2, ЗГҮАХ-ийн 5.2.1, 5.2.3 дахь дэд заалт | Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 126 дугаар тушаалаар батлагдсан Ажлын хэсгээс дараах хууль тогтоомжийн төслийг боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлсэн. Үүнд:<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;<br>- “Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл;<br>- “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” УИХ-ын тогтоолын төсөл зэрэг болно.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны тогтоолоор дараах журам, шийдвэрүүд батлагдаж, төрийн болон орон нутгийн өмчийн эрх зүйн зарим зохицуулалтыг тодорхой болгосон. Үүнд:<br>- ТӨБЗГ-ын 2017 оны 90 дүгээр тогтоолоор “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”;<br>- 2017 оны 67 дугаар тогтоолоор “Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам”; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай” 2017 оны 53 дугаар тогтоол батлагдаж, төрийн өөрийн өмчийн түрээсийн асуудлын зохицуулалтыг тодорхой болгосон.<br>- ТӨБЗГ-ын 2017 оны 86 дугаар тогтоолоор “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”;<br>- ТӨБЗГ-ын 2017 оны 276 дугаар тогтоолоор “Төрийн өөрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам” зэрэг болно.<br>Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 69 дүгээр тогтоол, Засгийн газрын хуралдааны 2016 оны 41 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэх арга хэмжээг авч, ТӨБЗГ-аас “Албан даалгавар” гарган зарцуулагдаагүй цалин, хөлс, урамшуулал, томилолт, тавилга, эд, хогшил, эхлээгүй ажил үйлчилгээний зардлуудыг хэмнэх, төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулсан. Үүний үр дүнд төрийн өмчит хуулийн этгээдийн борлуулалтын орлого 2016 онд 1,555.1 тэрбум төгрөг байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,797.8 тэрбум төгрөгт хүрч, 242.8 тэрбум төгрөгөөр, 2016 онд 1,105.2 сая төгрөгийн алдагдалтай байсан бол 2017 онд 3,442.7 сая төгрөгт хүрч цэвэр ашиг өмнөх оноос 3 дахин өссөн байна. Төрийн өмчийн 38 хуулийн этгээд 2016 онд ашигтай ажилласан бол 2017 онд 54 компани цэвэр ашигтай ажиллажээ. Төрийн өмчийн ногдол ашгийн 12.5 тэрбум төгрөгийг 2017 онд улсын төсөвт төвлөрүүлсэн нь 2016 оноос 3 дахин өссөн бөгөөд өмч хувьчлалын орлого 16.8 тэрбум төгрөг, үүнээс | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түрээсийн орлого 2.1 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. | |
| 15.9 | МУТХҮБ-ын 2.4, Зорилт 1, 2, ЗГҮАХ-ийн 2.12 дахь дэд заалт | Шударга өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөрийг боловсруулж, батлуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын даргын 2017 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн А/01 тоот тушаалаар "Шударга өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөрийг боловсруулж батлуулах" ажлын хэсэг байгуулан ажиллав. Ажлын хэсгээс Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ, бодлогын баримт бичгүүдийн уялдаа, шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийн төсөөлөл, тооцоо, хэлэлцүүлгийн саналын товъёог, нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, шалгуур үзүүлэлт, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөр (Шударга өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөр)-ийн төслийг боловсруулав. | 70 |
| 15.10 | МУТХҮБ-ын 2.4, Зорилт 1 | Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох судалгааг хийж, шаардлагатай бол төрийн | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Энэ хуулийн 7-16 дугаар зүйлд заасан бодлогыг баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг Засгийн газар батална." Гэж заасны дагуу Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг 89 дүгээр тогтоолоор баталсан. Энэхүү журам батлагдсанаар Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хэрэгжих, хөгжлийн бодлого оновчтой, үр дүнтэй хэрэгжиж байгаад үнэлгээ, дүгнэлт өгч, гарсан үнэлгээний тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон. Үндэсний хөгжлийн газар "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-г хэрэгжүүлэхтэй холоотой урт, дунд хугацааны | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгууллагын бүтэц, ажил үүргийн хуваарьт нэмэлт, өөрчлөлт оруулах | | | | бодлогын уялдааг хангах, хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, Монгол Улсад хүчинтэй хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр зарласан бөгөөд шалгарсан баг 10 дугаар сараас хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг үнэлэх, хүрэх түвшинг тодорхойлох нэгдсэн аргачлалыг боловсруулах, дунд хугацаанд бодлогын уялдаа зохицуулалтыг ханган хэрэгжүүлэх, дунд хугацааны хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийг хийх ажлыг эхлүүлээд байна.<br>"Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-г хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чиглэлийн төсөл, хөтөлбөрийг эрэмбэлэх, хөрөнгө оруулагч нарт үйлчлэх нэг цэгийн үйлчилгээ бий болгох зорилгоор Үндэсний хөгжлийн газрын орон тоог нэмэгдүүлж, бүтэц, үйл ажиллагааны стратеги, чиг үүргийг шинэчлэн батлах саналыг Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн "Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 69 дүгээр тогтоолын 3.1-д "төрийн албан хаагчдын тоог 2017 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байх" гэсэн шаардлагын дагуу тухайн саналыг дэмжээгүй. | |
| 15.11 | МУТХҮБ-ын 2.4, Зорилт 1 | Төрийн эрх мэдлийн хуваарилалтыг төгөлдөржүүлэх чиглэлээр Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар явуулсан анхдугаар зөвлөлдөх санал асуулгын зөвлөмжийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын даргын 2017 оны 78 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд боловсруулж хуулийн төсөлд ХЗДХЯ-аас санал, дүгнэлтийн төсөл бэлтгэж хүргүүлсэн. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | судалж, төрийн байгууллалттай холбоотой хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох асуудлаар судалгаа, шинжилгээ хийх, шаардлагатай бол холбогдох арга хэмжээ авах бэлтгэл ажлыг хангах | | | | | |
| **Зорилт 16. Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулж, хилийн чанадад амьдарч буй монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулан, хөрш орнуудад хийх худалдааг өргөжүүлэх бодлого баримтална** | | | | | | | |
| 16.1 | Гадаад бодлогын үзэл баримтлал /цаашид "ГБҮБ" гэх/-ын 2.14.1 дэх дэд заалт, ЗГҮАХ-ийн 5.6.2 дахь дэд заалт | Монгол-ОХУ-БНХАУ-ын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Хөрөнгө оруулалтын төв байгуулах чиглэлээр ажиллах | ОХУ, БНХАУ-ын талтай хийх уулзалтын тоо | 10 | - | Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалтын төв байгуулах асуудлыг БНХАУ болон ОХУ-ын талд тавьж ажиллав. Тухайлбал, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн 2017 оны 1 дүгээр сард ОХУ-ын Элчин сайд И.К.Азизов, БНХАУ-ын ЭСЯ-ны Хэргийг түр хамаарагч Ян Чиндун нарыг тус тус хүлээн авч гурван талын шинжээчдийн түвшний уулзалтыг хугацаанд зохион байгуулах санал дэвшүүлсэн. Мөн үеэр "Хөрөнгө оруулалт, судалгааны хамтарсан төв"-ийн концепцийн төслөө манай тал орос болон хятадын талд хүргүүлсэн. 2017 оны 3, 8 дугаар саруудад зохион байгуулсан Гурван талын шинжээчдийн түвшний уулзалтуудаар асуудлыг дэлгэрэнгүй ярилцсан. Тэргүүлэх чиглэлийн эхний төслийг хэрэгжүүлж эхэлсний дараа Хөрөнгө оруулалтын зураг төслийн хамтарсан төвийг Улаанбаатар хотод байгуулахаар зарчмын тохиролцоонд хүрсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Хөрөнгө оруулалтын зураг төслийн төв”-ийг Засгийн газрын 2017 оны 262 дугаар тогтоолоор Гадаад харилцааны яамны дэргэд байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд уг тогтоолын хавсралтаар төвийн дүрмийг батлуулж, Гадаад харилцааны сайдын 2017 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн Б/70 дугаар тушаалаар Г.Амартүвшинг захирлаар томилсон. | |
| 16.2 | ГБҮБ-ын 2.14.4 дэх дэд заалт, ЗГҮАХ-ийн 5.6.4 дэх дэд заалт | Олон улсын болон бүс нутгийн байгууллагууд тай хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх | АНУ-ын Мянганы сорилтын корпорацитай байгуулах /хоёрдугаар компакт/ гэрээний тоо | 1 | - | Мянганы сорилтын корпораци (МСК)-ийн Хөрөнгө оруулалт, менежментийн хороо 2017 оны 4 дүгээр сард хуралдаж, Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх болон гэр хорооллын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг сайжруулах талаар боловсруулсан төсөл хөтөлбөрийн дэлгэрэнгүй саналыг хэлэлцэж, нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийн дэлгэрэнгүй саналыг дэмжсэн. Нийт ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх болон усыг дахин цэвэршүүлж үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашиглах төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн ажлын даалгаврыг эцэслэн боловсруулж монголын талаас МСК-д хүргүүлсэн. ТЭЗҮ-ийг санхүүжүүлэх 10.5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн тухай хэлэлцээрийг Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Гадаад харилцааны сайдад олгосон. Хэлэлцээрийн дагуу дээрх ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай нийт 10.5 сая ам.долларын санхүүжилтийг МСК дангаараа хариуцан гаргах бөгөөд энэ нь Компакт гэрээний нийт үнийн дүнгээс хасагдахгүй юм.<br>МСК-ийн Монгол Улсыг хариуцсан баг 2017 оны 2, 5 дугаар сард Улаанбаатар хотноо ажиллаж, компакт гэрээний бэлтгэл ажлын хүрээнд Гадаад харилцааны сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн дэд сайд болон Нийслэлийн удирдлагатай уулзалт хийж, Хөрөнгө оруулалт, менежментийн хорооны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдвэрийг танилцуулан компакт гэрээний ТЭЗҮ-ийн судалгаа, Монгол Улсын Засгийн газраас компакт гэрээг боловсруулах болон хэрэгжүүлэх шатанд гаргах шаардлагатай байгаа хөрөнгө, санхүүжилт зэрэг асуудлаар санал солилцож, тохиролцоонд хүрсэн.<br>"Компакт гэрээ боловсруулахад дэмжлэг үзүүлэх буцалтгүй тусламж, түүний гүйцэтгэлийн тухай" Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпораци хоорондын хэлэлцээрийг 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр байгуулав.<br>Мянганы сорилтын корпорацийн Захирлуудын зөвлөл 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хуралдаж, Монгол Улсыг хоёр дахь компакт гэрээ байгуулах боломжтой орноор дахин шалгаруулсан.<br>Нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр 2018 оны 6 дугаар сард эхлэх бөгөөд ТЭЗҮ-ийн судалгаа болон шинэ цэвэрлэх байгууламжийн концессийн ажлын явцаас шалтгаалсан ТЭЗҮ-ийн судалгааг эцэслэх, Компакт гэрээний төсөл, хөтөлбөрийн бүтэц, агуулгыг гаргахаар ажиллаж байна. | |
| | | | Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төв үүсгэн байгуулах хэлэлцээрт нэгдэн орох улсын тоо | 2 | - | Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төв (ОУСТ)-ийн гол зорилт болох ОУСТ-ийг үүсгэн байгуулах тухай Олон талт хэлэлцээрт 10 Далайд гарцгүй хөгжиж буй орнуудыг нэгдүүлэх ажлыг идэвхтэй зохион байгуулсны үр дүнд 2017 онд тус хэлэлцээрт Тажикистан, Кыргыз болон Балба Улс нэгдэн орж, уг хэлэлцээр 2017 оны 10 дугаар сарын 6-ны өдөр хүчин төгөлдөр болсон.<br>Хэлэлцээр хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан Нью-Йорк дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд хэвлэлийн бага хурал хийж, олон талт хэлэлцээр хүчин төгөлдөр болж, Олон улсын судалгааны төв албан ёсоор үүсгэн байгуулагдсаныг олон нийтэд зарласан. | |
| 16.3 | ГБҮБ-ын 3.21.6 дахь дэд заалт, | Хөрш орнуудад хийх | Замын-Үүд–Эрээний хил | 40.0 | - | Хөрш орнуудад хийх худалдааг өргөжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ЗГҮАХ-ийн 5.6.5, 5.6.7 дахь дэд заалт | худалдааг өргөжүүлэх бодлого баримтлах, гадаад худалдааг хөгжүүлэх зорилгоор чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх | дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ажлын явц, хувиар | | | Үүнд:<br>- “Замын-Үүд чөлөөт бүс”-ийн Захирагчийн ажлын албанаас БНХАУ-ын 58.8 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийг 2014 оноос хэрэгжүүлж, 2017 онд Дулааны цахилгаан станц, усан хангамж, ариутгах татуургын систем барьж *(25.3 км цэвэр усны шугам, 10.4 км бохир усны шугам)* 2017 оны 9 дүгээр сард туршилт тохируулгын ажил хийгдсэн. Замын-Үүдийн хуучин цахилгааны дэд станцыг өргөтгөн 10кВт хүчин чадалтай цахилгаан дамжуулах шугам 2.8 км нэмж ашиглалтанд оруулсан. Мөн 12.8 км автозам, холбооны ажил хийгдэж 2017 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Улсын комисс хүлээн авсан байна. Түүнчлэн хил дамнасан чөлөөт бүсийн техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нарийвчилсан үнэлгээг 2017 онд боловсруулсан.<br>Шадар сайд Ө.Энхтүвшин тэргүүтэй төлөөлөгчид 2017 оны 12 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд Замын-Үүд боомтод ажиллаж, Чөлөөт бүсийн үйл ажиллагаатай танилцаж, хятадын талын холбогдох албаны хүмүүстэй ажлын уулзалт хийсэн бөгөөд уулзалтын үеэр хятадын талаас Замын-Үүд-Эрээний хил дамнасан чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлж, хоёр талын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг ойрын хугацаанд байгуулах хүсэлтийг тавьсан. Шадар сайд Замын-Үүд чөлөөт бүсэд баригдсан дэд бүтцийн бүтээн байгуулалтыг ойрын хугацаанд Улсын комисст хүлээлгэн өгч, чөлөөт бүсийн үйл ажиллагааг эхлүүлэх ажлыг түргэвчлэх, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хятадын талын төсөлд ойрын хугацаанд хариу өгөх талаар мэдэгдсэн. | |
| | | | ОХУ-тай хийх уулзалтын тоо | 4 | - | ОХУ-тай дараахь томоохон уулзалтыг хийсэн.<br>Үүнд: | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | УИХ-ын гишүүн Н.Оюундарь тэргүүтэй Монгол Улсын Их Хурлын гишүүд, бизнес эрхлэгчид 2017 оны 2 дугаар сард ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсад айлчилж, энэ үеэр УИХ-ын гишүүн Н.Оюундарь Буриадын Төр, засаг, бизнесийн төлөөлөгчидтэй<br>**1.** "Алтанбулаг" чөлөөт бүсийг хамтран хөгжүүлэх талаар санал солилцсон.<br>**2.** Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг тэргүүтэй ажлын хэсэг 2017 оны 1 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд Сэлэнгэ аймагт ажиллаж, Монгол, Оросын хилийн Алтанбулаг-Хиагт боомтын хилийн хяналт шалгалтын үйл ажиллагаа, боомтын барилга байгууламж, тоног төхөөрөмж, хангамж, боомтын өнөөгийн үйл ажиллагаа, тулгамдсан асуудлаар зөвлөлдөх уулзалт хийсэн. Энэ үеэр Хиагт боомтын өргөтгөлийн ажилтай "Алтанбулаг" чөлөөт бүсийг хэрхэн уялдуулж, хоёр талын боомтын шалган нэвтрүүлэх цэгийг шууд холбож болох талаар санал солилцсон. Үүний үр дүнд Монголын тал Оросын талаас Хиагт боомтын өргөтгөлийн ажлын зураг төслийн тойм зургийг авах хүсэлтээ хүргүүлсэн.<br>**3.** Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайд Б.Дэлгэрмаа 2017 оны 8 дугаар сарын 18-ны өдөр ОХУ-ын Гадаад хэргийн орлогч сайд И.Н.Моргуловтай хийсэн уулзалтаар Алтанбулаг, Хиагт хилийн боомттой холбоотой хоёр улсын гаалийн байгууллага хоорондын хамтын ажиллагааны баримт бичиг байгуулж ажиллах талаар санал солилцсон.<br>**4.** Улаанбаатар хотод 2017 оны 10 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулагдсан "Монгол-Оросын хамтын ажиллагаа 2017" чуулга уулзалтад ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн эдийн засгийн байнгын хорооны нэгдүгээр орлогч дарга |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | С.В.Калашников тэргүүтэй төлөөлөгчид оролцсон. Чуулга уулзалтын үеэр С.В.Калашников Монгол Улсын УИХ-ын дарга М.Энхболдод бараалхаж, УИХ-ын гишүүн Б.Энх-Амгалантай уулзаж хоёр орны бүс нутгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөвийн талаар санал солилцсон бөгөөд "Алтанбулаг" чөлөөт бүсийг хөгжүүлэх асуудлын талаар яриа, хэлэлцээ тус тус хийсэн. | |
| 16.4 | ГБҮБ-ын 6.27.5 дахь дэд заалт, ЗГҮАХ-ийн 5.6.9, 5.6.12 дахь дэд заалт | Хилийн чанад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээг сайжруулах | Цахим консулын үйлчилгээг нэвтрүүлэх дипломат төлөөлөгчийн газрын тоо | 4 | | Нэг. Консулын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх хүрээнд:<br>"Хилийн чанад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газраас иргэний гэр бүлийн байдлын бүртгэл хөтлөх заавар"-ын дагуу 2017 оны 3 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн Дипломат төлөөлөгчийн газарт паспорт захиалсан иргэдийн материалыг цахимаар хүргүүлдэг болсноор хилийн чанадад байгаа иргэд ДТГ-т паспорт захиалаад 2-3 сар хүлээдэг байсан хүндрэлтэй байдал арилсан. Ялангуяа шууд нислэггүй, дипломат шуудан хүргүүлэх боломж багатай ДТГ-т паспорт захиалсан иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх боломж нээгдлээ.<br>ГХЯ-ны албан ёсны фэйсбүүк, твиттер хаягаар дамжуулан олон нийтийн сүлжээгээр дотоодоос болон гадаад улсаас ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдолд шуурхай хариу өгдөг боллоо.<br>Гадаадын улс орнуудад онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн улс, бүс нутагт байгаа монгол иргэдийн аюулгүй байдлыг хангах, шаардлагатай үед тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулсан.<br>Түүнчлэн консулын үйлчилгээг цахимжуулах хүрээнд Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2017 оны 6 дугаар сарын 7-ны | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрийн А/24, А/157, А/93 тоот хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулж гадаадад оршин суугаа монгол иргэдийн бүртгэлийг цахимаар хийх програмыг боловсруулан туршилтийг амжилттай хийж нэвтрүүлэхэд бэлэн болгов. Үүнтэй уялдуулан Монголын нотариатчдын танхимаас нэвтрүүлэхээр төлөвлөж буй цахим нотариатын үйлчилгээний төсөлд ДТГ-ыг хамруулахаар төлөвлөж байна.<br>Хоёр. Цахим виз нэвтрүүлэх хүрээнд:<br>Цахим визний мэдээллийн систем нэвтрүүлэх тендерийн үнэлгээний хороог Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн А/112 тушаалаар Гадаад харилцааны яам, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Үндэсний Дата төв зэрэг байгууллагуудын төлөөлөлтэй байгуулж, тендерийг зарласан боловч тодорхой шалтгааны улмаас дахин тендер зарлах шаардлага үүссэн. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2017 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн албан бичгээр тендер шалгаруулалтыг түр түдгэлзүүлсэн.<br>Цахим консулын үйлчилгээ нэвтрүүлэх хүрээнд гадаад паспортыг цахимаар захиалах үйлчилгээг нийт 42 Дипломат төлөөлөгчийн газарт нэвтрүүллээ. | |
| | | | Мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажлын явц, хувиар | 10.0 | | Консулын газрын эрхлэн ажиллуулдаг www.consul.mn цахим хуудсаар дамжуулан авдаг үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан байгуулж, лавлагаа авах боломжтой болгох, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулахаар шат дараатай арга хэмжээ авч байна. Энэ хүрээнд Консулын газрын үзүүлдэг үйлчилгээ авах анкет, үйлчилгээний мэдээллийг байршуулаад байгаа бөгөөд цахим хуудасны мэдээлэл, дизайныг шинэчлэх, англи хэл дээрх сонголтыг оруулсан.<br>Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Үндэсний статистикийн хорооны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даргын 2017 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А/24, А/157, А/93 тоот хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулж, гадаадад оршин суугаа монгол иргэдийн бүртгэлийг цахимаар хийх программыг боловсруулан туршилтийг амжилттай хийж нэвтрүүлэхэд бэлэн болгов. Энэ нь цаашид цахим мэдээллийн сан үүсгэхэд ач холбогдолтой юм. | |
| **Зорилт 17. Батлан хамгаалах салбарын эрх зүйн орчныг сайжруулж, улс орныг батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ** | | | | | | | |
| 17.1 | Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс /цаашид МУБХБҮ гэх/-ийн 6.1, 6.2 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.5.1 дэх дэд заалт | Батлан хамгаалах, энхийг дэмжих ажиллагаанд оролцох чиглэлээр эрх зүйн орчныг сайжруулах | Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо | 7 | - | Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.3 дахь хэсэгт хамаарах тул нууцаар тайлагнана. | 70 |
| 17.2 | МУБХБҮ-ийн 2.5 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.5.2 дахь дэд заалт | Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг сайжруулан, бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх | Хуурай замын цэргийн бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхын өсөлт, хувиар | 15.0 | | Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.3 дахь хэсэгт хамаарах тул нууцаар тайлагнана. | 100 |
| | | | Зэвсэглэл, цэргийн техникийн чанар байдлын өсөлт, хувиар | 23.0 | | | |
| 17.3 | МУБХБҮ-ийн 2.3.2 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.5.3, 5.5.4 дэх дэд заалт | Монгол Улсын агаарын хилийн хяналт, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог сайжруулах, кибер аюулгүй байдлыг хангах, | Агаарын хил, орон зайн хяналтын техник хэрэгслийн шинэчлэлт, хувиар | 20.0 | 0.88 ЗХХС | Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.3 дахь хэсэгт хамаарах тул нууцаар тайлагнана. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтолцоог сайжруулах, чадавхыг нэмэгдүүлэх | | | | | |
| 17.4 | МУБХБҮ-ийн 3.2.3 дахь дэд заалт, ЗГҮАХ-ийн 5.5.5, 5.5.7 дахь дэд заалт | НҮБ-ын мандаттай энхийг дэмжих болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх | Цэргийн атташетай болох улсын тоо | 3 | - | Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.3 дахь хэсэгт хамаарах тул нууцаар тайлагнана. | 100 |
| | | | Энхийг дэмжих ажиллагааны чадавхын өсөлт, хувиар | 20.0 | | | |
| 17.5 | МУБХБҮ-ийн 2.8, 5.5 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.5.8, 5.5.10 дахь дэд заалт | Цэргийн байгууллагын эрдэм шинжилгээ, судалгааны чадавхыг сайжруулж, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх | Цэрэг, эх оронч үзэл, хүмүүжил олгох шинэ хөтөлбөрийн тоо | 1 | 0.611 ЗХХС | Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.3 дахь хэсэгт хамаарах тул нууцаар тайлагнана. | 70 |
| | | | Туршилтын нэгдсэн лаборатори байгуулах ажлын явц, хувиар | 5.0 | | | |
| **Нийт үнэлгээний дундаж, хувь** | | | | | | | **79.3** |